



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨРИЙН ХЭТ ДАВАМГАЙЛСАН, ЗАХ ЗЭЭЛИЙН БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ДУЛААНЫ
ЭРЧИМ ХҮЧНИЙ СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТГҮЙ ТОГТОЛЦОО НЬ САЛБАРЫН
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ АЛДАГДУУЛЖ, ӨР ТӨЛБӨР БОЛОН ХҮЧИН
ЧАДЛЫН ДУТАГДЛЫГ ДААМЖРУУЛЖ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН БЭЛЭН БАЙДАЛ,
ХЭРЭГЛЭГЧДИЙГ ДУЛААНААР ХАНГАХ, ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: ГАГ-2026/10-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



УЛААНБААТАР 2026 он

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755, цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Дарьмаа

Утас: 261456, цахим хаяг: darimaas@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Төмөрбаатар

Утас: 261456, цахим хаяг: tumurbaatart@audit.gov.mn

Аудитор Н.Онон

Утас: 261456, цахим хаяг: ononn@audit.gov.mn

Аудитор Б.Очмаа

Утас: 261456, цахим хаяг: ochmaab@audit.gov.mn

Аудитор Г.Очирваань

Утас: 261456, цахим хаяг: ochirvaanig@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК, Тавантолгой түлш ХХК болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.


3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Н.Учрал), Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Б.Энхбаяр), Эрчим хүчний сайд (Б.Найдалаа) нарт зөвлөж, Эрчим хүчний зохицуулах хороо (Э.Түвшинчулуун), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Б.Пүрэвдагва), Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Д.Ихбаяр), "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК (Ц.Амарсанаа), "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК (Ч.Амарсанаа), "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК (Ц.Минжинхүү), "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК (Б.Сандуйжав), "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК (П.Болдбаатар), "Налайхын дулааны станц" ТӨХК (Ц.Энхтүвшин), "Багануурын дулааны станц" ТӨХК (Б.Ариун-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН



“Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчил хариуцах		Мөнгөн дүн (сая төгрөг)	Албан шаардлагын товч утга
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Эрчим хүчний яам	Сайд Б.Найдалаа	59,998.8	Хийн дулааны станц/Цэцэрлэгт хүрээлэн 1/-ын төслийн газрын асуудлыг шийдвэрлээгүй, зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй байхад урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь Төсвийн тухай хууль, мөн тендерт шалгарсан компани нь Эрчим хүчний тухай хуульд заасан шаардлагыг тус тус хангаагүй зөрчил тогтоогдов.
2	Тавантолгой түлш ХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Амгалан	3,272.8	Компани нь үндсэн хөрөнгийн жагсаалт дахь өөрөө буулгагч автомашинуудыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн байна. Энэхүү шилжүүлгийг холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаагүй төдийгүй, хүлээн авагч байгууллага өөрийн хөрөнгөд бүртгээгүй зөрчил тогтоогдов.



АГУУЛГА

АГУУЛГА.....	5
Нэр томъёоны тайлбар.....	9
Хүснэгтийн жагсаалт.....	10
Графикийн жагсаалт.....	11
Дүрслэлийн жагсаалт.....	12
Хавсралтын жагсаалт.....	12
ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ.....	13
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	15
Улаанбаатар хотын дулаан хангамжийн систем.....	15
Хууль эрх зүйн орчин.....	16
Дулаан хангамжтай холбоотой бодлого, хөтөлбөрүүд.....	17
Дулаан хангамжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олголт.....	18
БҮЛЭГ 1. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ БОДЛОГЫГ ӨСӨН НЭМЭГДЭХ ХЭРЭГЛЭЭНД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛААГҮЙ, ЗАСАГЛАЛЫН НЭГДМЭЛ, ХАРААТ БУС БАЙХ ЗАРЧИМ АЛДАГДСАН НЬ САЛБАРЫГ НЭГДСЭН БОДЛОГООР ХАНГАХ, УДИРДАХ БОЛОМЖҮЙ БОЛГОЖЭЭ.....	20
Оршил.....	20
Эрчим хүчний салбарын бодлогын нэгдмэл байх зарчим алдагдсан нь нэгдсэн төлөвлөлтөд давхардал, хийдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж, засаглалын хувьд Засгийн газраас хараат байгаа нь дулааны эрчим хүчний үнэ тариф бодит өртөгт хүрэхгүй байх нөхцөл болсоор байна.....	20
Салбарын хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, цалин урамшууллыг нэгдсэн зарчмаар зохицуулах механизм бүрдээгүй нь цаашид мэргэшсэн инженер, техникийн ажилтны хомсдол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.....	23
Дулааны хэрэглээний хэтийн төлөвлөлтөд Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн чиг хандлагыг харгалзаагүй нь ирээдүйн сорилтод тэсвэртэй, тогтвортой дулаанаар хангах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.....	25
Салбарын байгууллага хоорондын мэдээлэл солилцооны давтамж, уялдаа алдагдаж, өгөгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй нь эрчим хүчний бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах мэдээлэл үнэн, бодитой байх шаардлагыг хангахгүй байна.....	26
Төрийн өмчит компаниудыг удирдлагаар хангах чиглэлээр Засгийн газар, Нийслэлийн удирдлагын гаргасан шийдвэрүүд салбарын компаниудад санхүүгийн нэмэлт дарамт болж, хөрөнгө үргүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлжээ.....	27
Төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй төрийн жинхэнэ албан хаагчид хуульд заасан хязгаарлалтыг зөрчиж, хяналтын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.....	30
Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн зохицуулах зөвлөлийн хуулийн этгээдийн хэлбэр үйл ажиллагаатайгаа нийцэхгүй байна.....	32
Эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл олголтын хууль тогтоомжийн хийдэл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 2023-2025 оны байдлаар 4,460.3 сая төгрөгийн санхүүгийн дарамт үзүүлжээ.....	33
Дулаан хангамжийн бодлогын хэрэгжилтэд тавих хяналтыг төлөвлөх, зөрчил арилгах үйл ажиллагаа үр дүнгүй байна.....	34
Дулаан хангамжийн системийн хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл олголт, нөхцөл, шаардлагын нийцэл, норм, стандартын хэрэгжилтэд хийсэн хяналтаар илэрсэн зөрчил, түүнийг арилгах үйл явц үр дүнгүй байна.....	35

БҮЛЭГ 2. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН ҮЙЛДВЭРЛЭХ, ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ ОРГИЛДОО ХҮРЧ ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН БАЙНА37

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн талаар ерөнхий мэдээлэл	37
Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийг түүхий эдээр хангаж буй Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхгүйгээр шинээр эх үүсвэр нэмсэн ч түүхий эдээр хангах боломжгүй байна	38
Нүүрсний уурхайнуудад техник, технологийн шинэчлэл хийхгүйгээр цаашид өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах боломжгүй байна	41
Төвлөрсөн дулаан хангамжийн системийн барилга, байгууламжийн үндсэн тоноглол, тоног төхөөрөмжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоосон норм, дүрэм байхгүй нь засвар, шинэчлэл, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх үйл явц бодит хэрэгцээнд үндэслэхгүй байх эрсдэлтэй байна	42
Дулааны болон дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолуудын эдэлгээний хугацаа дуусаж, шинэчлэлт хийхэд ихээхэн хэмжээний хөрөнгө шаардахаар байна	43
Эрчим хүчний шинэ эх үүсвэр нэмэгдээгүй байхад хүчин чадлаас давсан хэрэглээнд техникийн нөхцөл олгосоор байгаа нь төвлөрсөн дулаан хангамжийн системд доголдох үүсэх эрсдэлийг бий болгож байна	45
Төвлөрсөн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид санхүүгийн хүндрэлд орж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болох хэмжээнд хүрчээ	47
Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд дулаан дамжуулах сүлжээний горим, тохируулга, ашиглалт болон техникийн нөхцөл олгох нэгдсэн зохицуулалт байхгүй байна	47
Эх үүсвэрүүдийн хүчин чадал дутагдлаас шалтгаалж өвлийн оргил ачааллын үеийн горимын төлөвлөлт дутуу хийгдэж, хэрэглэгч шаардлагатай хэмийн дулаанаа авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна.....	48
Дулааны эрчим хүч дамжуулах сүлжээ холбогдсон ачааллаа дийлэхээргүй болж, ачаалал оргилдоо хүрчээ	50
Дулаан дамжуулах шугам хоолойн нэвтрүүлэх чадвар зарим чиглэлд хүрэлцэхгүй байна	51
Төвлөрсөн дулаан хангамжийн системийн өмчлөгч, эзэмшигч нь тодорхойгүй 59.4 км урт шугамд гэмтэл саатал гарсан үед шуурхай засварлах, ашиглалтыг хариуцах эзэнгүй байна	54
Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн суурилагдсан хүчин чадал, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүй, системийн чадлын дутагдал өндөр хэвээр байна	55
Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хэрэглэгчдийн 1.7 хувь нь хэрэглээнд суурилсан төлбөрийн тогтолцоонд шилжсэн байна	60
Эрчим хүч хэмнэх үүрэг хүлээсэн хэрэглэгчид үүргээ биелүүлж, хэмнэлт гаргасан байна	61
Эрчим хүчний зөв зохистой хэрэглээг сурталчлах ажил хийж байгаа ч үр нөлөөг тооцож, бүртгэж чадахгүй байна.....	62
Дулаан хангамжийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид санхүүгийн хүндрэлд орж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байна	63

БҮЛЭГ 3. НИЙСЛЭЛИЙН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИД ХОЛБОГДООГҮЙ АЙЛ ӨРХИЙН ГЭР, БАЙШИНГИЙН ДУЛААЛГА ХИЙХ, САЙЖРУУЛСАН ТҮЛШ ҮЙЛДВЭРЛЭХ, НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХАД 2.1 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛСАН Ч ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНГ ҮЗҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....64

Багануур, Налайх дүүрэг дулаан хангамжийн чадлын дутагдалд орж, үндсэн тоноглолууд хуучирсан байна	64
--	----

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй зарим хэсгийг бага хүчин чадалтай дэд станц барьж дулаанаар хангах шийдвэрээс зөвхөн 28МВт-ын хүчин чадалтай Сэлбэ дулааны станц барьж ашиглалтад оруулсан байна.....	66
Зарим дэд төвийн барилга байгууламжид олгосон техникийн нөхцөл хүчингүй болсон нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удаашруулах эрсдэлтэй байна	67
Эрчим хүчний хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболт хийх, хийн түлшээр ажиллах дэд төвийн технологийн шийдлийг шинэчлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд нийслэлийн өмчит аж ахуйг байгуулж, тендерт шалгаруулсан байна.....	67
Гэр, хорооллын айл өрхийн дулаалга, хийн түлшээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх ч айл өрхүүдийг хэрхэн сонгосон талаар баримт, судалгаа байхгүй байна	69
Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах зорилгоор байгуулсан үйлдвэрүүдийг импортын түлш савлах болон агуулахын зориулалтаар ашиглаж байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр ашиггүй байгааг харуулж байна.....	71
Тавантолгой түлш ХХК нь төрийн өмчийн хөрөнгийг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй шилжүүлж, данс бүртгэлээс хасаж холбогдох журмыг зөрчсөн байна	79
ДҮГНЭЛТ.....	81
ЗӨВЛӨМЖ.....	84
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ.....	87
ХАВСРАЛТУУД	93

Товчилсон үгсийн тайлал

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АББҮХ	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо
АДС	Амгалан дулааны станц
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БНДС	Багануур дулааны станц
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ДДЦС	Дарханы дулааны цахилгаан станц
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭХ	Дулаан эрчим хүч
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИТА	Инженер техникийн ажилчид
НАОБТГ	Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
НДС	Налайх дулааны станц
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮТББ	Нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТБОНАХӨАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨК	Төрийн өмчит компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТТТ	Тавантолгой түлш
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮТ	Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ХИХУГ	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар
ХК	Хувьцаат компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХОСК	Хувийн орон сууцны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч

ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХҮТ	Эрчим хүчний үндэсний төв
ЭХЯ	Эрчим хүчний яам

Нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Тодорхойлолт
Эрчим хүчний эх үүсвэр	Эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламж
Нэгдсэн сүлжээ	Цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний нэгдэл
Эрчим хүчний барилга байгууламж	Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станцыг барьж байгуулах, технологийн үндсэн тоноглолд техникийн шинэчлэл хийх, сэргээн засварлах, өргөтгөх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх
Төвлөрсөн дулаан хангамж	Цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагаа
Дулаан дамжуулах сүлжээ	эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмж
Дулаан түгээх сүлжээ	Дулаан хуваарилах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмж
Халаалтын улирал	Барилга, байгууламжийг дулаанаар хангах шаардлагатай, хүний ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон жилийн цаг агаарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон хугацаа
Тариф	Үйлдвэрлэгчийн үнэ, дэмжих тариф диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ, хэрэглэгчийн эрчим хүчний үнэ, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Эрчим хүчний зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнэ
Диспетчерийн зохицуулалт	Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлэн нэгдсэн сүлжээний өдөр тутмын шуурхай үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохицуулах үйл ажиллагаа

Эх сурвалж: Эрчим хүчний тухай 2001 оны хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Нэр томъёо	Тодорхойлолт
Дулаан хангамж (Heat supply)	Хэрэглэгчийг дулаанаар хангах үйлдэл, үйл ажиллагааны нэгдэл
Төвлөрсөн дулаан хангамж (Centralized heat supply)	Дулааны нэг буюу түүнээс илүү тооны (дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх) эх үүсвэрээс хэрэглэгчийг нэг ерөнхий дулаан дамжуулах шугам сүлжээгээр дамжуулан дулаанаар хангах систем буюу үйл ажиллагаа
Төвлөрсөн бус дулаан хангамж (Non centralized heating supply)	Дулаан дамжуулах нэг ерөнхий шугам сүлжээнд холбогдоогүй, бие даасан (бага чадлын) эх үүсвэрээс хэрэглэгчийг дулаанаар хангах систем буюу үйл ажиллагаа
Дулаанжуулалт (Heating)	Технологийн нэгдмэл орчинд цахилгаан, дулааныг хамтатган үйлдвэрлэх төвлөрсөн дулаан хангамжийн үйл ажиллагаа буюу дулаан цахилгааны төв, дулааныг дамжуулж, түгээх сүлжээний нэгдэл
Дулааны цахилгаан станц (Thermal power station)	Түлшний (шатаалтын) химийн эрчмийг цахилгаан буюу ДЭХ болгон хувиргах зориулалттай цахилгаан, дулаан үйлдвэрлэх тоног төхөөрөмж бүхий техник-технологийн нэгдэл
Дулааны шугам сүлжээ (Heating network)	Дулааны эрчмийг хэрэглэгчид дамжуулах, хуваарилах зориулалттай дулаан дамжуулах шугам, тоног төхөөрөмж, байгууламжийн нэгдэл
Дулаан дамжуулах сүлжээ (Heating transmission network)	Эрчим хүчний эх үүсвэр (цахилгаан станц)-ээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийн нэгдэл. Дулаан хуваарилах төвөөс дулааны хэрэглэгчийн шугам сүлжээний оролт хүртэлх шугам тоног төхөөрөмжийн нэгдлийг дулаан түгээх сүлжээ

Эх сурвалж: Эрчим хүч ба цахилгаанжуулалт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 2919:2003 стандарт

Нэр томъёо	Тодорхойлолт
Дулааны цахилгаан станц (Thermal power station)	Түлшний (шатаалтын) химийн эрчмийг цахилгаан буюу дулааны эрчим хүч болгон хувиргах зориулалттай цахилгаан, дулаан үйлдвэрлэх тоног төхөөрөмж бүхий техник-технологийн нэгдэл
Дулааны эрчим хүч (Thermal power)	Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, хэрэглэх, түүнийг эрчим хүчний өөр төрлийн хэлбэрт шилжүүлэх асуудлыг хамарсан эрчим хүчний дэд салбар
Температур (Temperature)	Хий буюу шингэний халалтын зэргийг тодорхойлох хэмжигдэхүүн
Дулаан багтаамж (Heat capacity)	Биеийн температурыг 1 градусаар нэмэгдүүлэхэд шаардагдах дулаан

Дулааны урсгал (Heat transfer rate)	Нэгж хугацаанд биеэр дамжих дулаан
Дулаан нэвтрүүлэлт (Heat conductivity)	Жигд бус халсан биед нэг хэсгээс нь нөгөө хэсэгт дулааны энерги атом, молекулын хөдөлгөөний үр дүнд шилжих дулааны солилцооны үзэгдлийн нэг үндсэн механизм
Дулаан нэвтрүүлэх чадвар (Thermal conductivity)	Биеийн дотор 1м зайд 1 градусын температурын ялгавар үүссэн нөхцөлд түүгээр нэгж хугацаанд нэвтрэн өнгөрөх дулаан
Түлш (Fuel)	Зууханд дулаан гаргаж авах зориулалтаар ашиглаж буй шатамхай бодис
Дулааны үүсгүүр (Heat source)	Дулааны эрчим хүч үйлдвэрлэх төхөөрөмж
Зуухны төхөөрөмж (Boiler unit)	Зуух ба агаараар үлээх, утаа сорох, түлш бэлтгэх ба өгөх, үнс, шаарга зайлуулах, үнс барих тоноглолууд, халаах гадаргууг цэвэрлэх хэрэгсэл, уур, ус дамжуулах хоолой, хаалт, арматур, хянах, хэмжих, хамгаалах хэрэгслүүд болон ус боловсруулах төхөөрөмж, утааны яндан зэргээс бүрдсэн цогцолбор
Уурын турбин (Steam turbine)	Даралттай халсан (зарим цөөн тохиолдолд ханасан) уурын дулааны энергийг түүний хурдны кинетик энергиэр дамжуулан механик энергид хувиргах хүрдэт дулааны хөдөлгүүр
Дулаанжуулалтын турбин (Extraction turbine)	Технологийн болон төвлөрсөн дулаан хангамжийн хэрэгцээнд уур ашиглах зориулалтаар дундын (үйлдвэрийн болон дулаанжуулалтын гаргалгатай хийсэн уурын турбин
Уурын турбины төхөөрөмж (Steam turbine plant)	Уурын турбин болон бусад туслах тоноглолуудаас бүрдэх төхөөрөмж
Хийн турбин (Gas turbine)	Даралттай халсан хийн дулааны энергийг урсгалын кинетик энергиэр дамжуулан механик энергид хувиргах хүрдэт дулааны хөдөлгүүр
Дулааны насос (Heat pump)	Нам температуртай орчны дулааныг гадны энерги ашиглан өндөр температуртай орчинд дамжуулах термодинамикийн урвуу циклээр ажиллах төхөөрөмж
Халаалт /дулаацуулга/ (Heating)	Барилгын дулааны алдагдлыг дулаан хангамжийн системээс буюу дулааны эх үүсгүүрээс шууд нөхөх
Дулааны баланс (Heat balance)	Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл ба хэрэглээ, алдагдал хоорондын тэнцэл
Дулааны ачаалал (Heat load)	Дулааны үүсгүүрээс хэрэглэгчдийн нэгж хугацаанд авч байгаа дулааны хэмжээ ба сүлжээний алдагдлын нийлбэр

Эх сурвалж: Дулаан хангамжийн дулааны эрчим хүч. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5085:2001 стандарт

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улаанбаатар хотын сарын дундаж агаарын температурын мэдээлэл	15
Хүснэгт 2	Улаанбаатар хотын өрх, хүн амын тоо дулаан хангамжийн хэлбэрээр, мянган нэгж	15
Хүснэгт 3	Улс орнуудын эрчим хүчний шилжилтийн индекс	17
Хүснэгт 4	Орон сууцны айл өрхөд борлуулах ДЭХ-ний тарифын мэдээлэл	19
Хүснэгт 5	ААНБ-уудад борлуулах ДЭХ-ний тарифын мэдээлэл	19
Хүснэгт 6	ЭХЗХ-ны удирдлага, зохицуулагчдын мэдээлэл	21
Хүснэгт 7	Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх болон зохицуулалттай хангах ТЗЭ-дийн ажиллагсдын тоо, өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувиар	22
Хүснэгт 8	Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах ТЗЭ-дийн ажиллагсдын сарын дундаж цалин (сая төгрөг)	23
Хүснэгт 9	УБДС ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо болон орон тооны дээд хязгаарыг шинэчлэх баталсан шийдвэрүүд	23
Хүснэгт 10	Улаанбаатар хотын хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоо, мянган хүнээр	24
Хүснэгт 11	Эрчисл Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулсан дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцогч компаниудын санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сая төгрөг	27
Хүснэгт 12	Эрчисл Монгол ХХК-ийн тэтгэмж олгосон албан хаагчдын тоо, тэтгэмжийн дүн сая төгрөгөөр	28
Хүснэгт 13	Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн орон тоо	29
Хүснэгт 14	Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын төлөөллийн бүтцийн мэдээлэл	30
Хүснэгт 15	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцогч төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингийн мэдээлэл, сая төгрөг	32
Хүснэгт 16	ЭХҮТ ТӨХХК-аас 2023-2025 онд олгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тоогоор	32
Хүснэгт 17	Салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ (2024 оны байдлаар)	35
Хүснэгт 18	Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийн тоо	36
Хүснэгт 19	ЭХЯ-ны Салбарын хяналт хариуцсан нэгжийн хяналт, шалгалтын мэдээлэл	36
Хүснэгт 20	Төвлөрсөн дулаан хангамжийн системийн 2020-2025 онд үйлдвэрлэсэн дулаан, мянган Гкал/цаг	38

Хүснэгт 21	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хэрэглэгч, хангаагчийн мэдээлэл	39
Хүснэгт 22	Багануур ХК-ийн 2020-2025 онд борлуулсан нүүрс, мянган тонноор	39
Хүснэгт 23	Нүүрс нийлүүлэлтийн дүнд хугацааны төлөвлөгөө, мянган тонноор	37
Хүснэгт 24	Багануур ХК-ийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд	37
Хүснэгт 25	Шивээ-Овоо ХК-ийн 2020-2025 онд борлуулсан нүүрс, мянган тонноор	40
Хүснэгт 26	Шивээ-Овоо ХК-ийн шинэчилсэн дүнд хугацааны ТЭЗҮ-ээр олборлох нүүрс, мянган тонноор	40
Хүснэгт 27	Шивээ-Овоо ХК-ийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд	41
Хүснэгт 28	ЭХЗХ-оос Багануур ХК, Шивээ-Овоо ХК-ийн эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоосон байдал	41
Хүснэгт 29	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийн ашиглалтын хугацаа, хүчин чадал	43
Хүснэгт 30	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийн үндсэн тоноглолтын насжилт, 2025 оны жилийн эцсийн байдлаар	44
Хүснэгт 31	ДЦС-уудын тоноглолд гарсан аваарын зогсолт	45
Хүснэгт 32	ДЦС-4 ТӨХК-ийн зуухны төлөвлөгөөт засварын ажлын зардлын төлөвлөгөө, 2026 он	45
Хүснэгт 33	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн хүчин чадал, холбогдсон болон хүлээгдэж байгаа хэрэглээ, 2025 оны байдлаар, Гкал/цаг	45
Хүснэгт 34	Ирэгн, ААНБ-аас 2020-2025 онд ДЭХ-ний техникийн нөхцөл хүссэн байдал, Гкал/цагаар	46
Хүснэгт 35	Төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрт 2020-2025 онд холбогдсон ачаалал, Гкал/цаг	46
Хүснэгт 36	2025-2026 оны халаалтын улирлын гидравлик тооцооны дүн, эх үүсвэрүүдийн сүлжээний усны зарцуулалт	48
Хүснэгт 37	УБДС ТӨХК-ийн 2025-2026 оны халаалтын улирлын тооцооны дүн, горим ажиллагааны хэрэгжилт	49
Хүснэгт 38	ДЭХ-ийг дамжуулах шугамын нормативт болон бодит хүчин чадлын мэдээлэл	50
Хүснэгт 39	УБДС ТӨХК-ийн ДЭХ дамжуулах, түгээх шугамын насжилтын судалгаа, 2025 оны байдлаар	51
Хүснэгт 40	УБДС ТӨХК-ийн дамжуулах, түгээх шугам сүлжээний гэмтлийн судалгаа, ашигласан жилээр	52
Хүснэгт 41	УБДС ТӨХК-ийн 2020-2025 оны борлуулалтын орлогын гүйцэтгэл	53
Хүснэгт 42	ДЭХ дамжуулах шугам, хоолойн эзэмшил, өмчлөл 2025 оны жилийн эцсийн байдлаар	55
Хүснэгт 43	Дулааны шугам сүлжээний 2023-2025 онд гарсан гэмтлийг засварласан тоо	55
Хүснэгт 44	Төвлөрсөн дулаан хангамжийн үйлдвэрлэх, дамжуулах ТЭЗ төрийн өмчит ААНБ-ын 2023-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг	60
Хүснэгт 45	ДЭХ хэрэглэгчдийн тоолууржуулалтын мэдээлэл, 2025 оны байдлаар	60
Хүснэгт 46	Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн мэдээлэл	62
Хүснэгт 47	Эрчим хүч хэмнэх үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хөрөнгө оруулалтын судалгаа	62
Хүснэгт 48	Эрчим хүчний хэрэглээг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт	63
Хүснэгт 49	БНДС-ын үндсэн тоног төхөөрөмжийн хүчин чадал, насжилтын судалгаа	64
Хүснэгт 50	Багануур дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо	64
Хүснэгт 51	БНДС ТӨХК-ийн 2020-2025 оны үйл ажиллагааны үр дүн, татаас, өртгийн мэдээлэл	64
Хүснэгт 52	Налайх дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо	65
Хүснэгт 53	Гэр хорооллын дэд төвүүдийн байршил, талбайн хэмжээ тогтоосон шийдвэрийн жагсаалт	65
Хүснэгт 54	Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн дулаан хангамж, инженерийн дэд бүтцийн ажлын гүйцэтгэл, 2026 оны 4 дүгээр сарын байдлаар	66
Хүснэгт 55	Гэр, байшин дулаалах байршлын мэдээлэл, төсөв	69
Хүснэгт 56	Нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүргийн зарим хороодын гэр, байшин дулаалах болон хийн тоног төхөөрөмж суурилуулахад зарцуулах төсвийн мэдээлэл	69
Хүснэгт 57	Гэр, хорооллын айл, өрхийн дулаалга, хийн хангамжийн тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан санхүүжилтийн задаргаа	71
Хүснэгт 58	Улаанбаатар хотын төвлөрсөн инженерийн байгууламжгүй хэсгийн дулааны эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл	72
Хүснэгт 59	Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг, хэрэглэгч, хэрэглээний судалгаа	73
Хүснэгт 60	Сайжруулсан түлшний өдрийн хэрэглээ, сууцны талбайгаар	74
Хүснэгт 61	Сайжруулсан түлшний чанарт өгсөн үнэлгээ	75
Хүснэгт 62	Тавантолгой түлш ХХК-ийн 2018-2025 онд Энержи ресурс ХХК-аас татан авсан мидлинг, мянган тонн	77
Хүснэгт 63	Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгийн нэгтгэл, тэрбум төгрөгөөр	77
Хүснэгт 64	Тавантолгой Түлш ХХК-ийн 2018-2025 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, мянган тонн	77

Графикийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
График 1	Монгол Улсын эрчим хүчний шилжилтийн бэлэн байдлын индекс, бүрэлдэхүүн индекс (2025 оны байдлаар)	17
График 2	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн ТЭЗ-дийн эдийн засгийн үзүүлэлт, сая тэрбум төгрөгөөр	21
График 3	УБДС ТӨХК-ийн дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлт, мянган.Гкал	24
График 4	ЭХЗХ-ны зохицуулах үйлчилгээний орлого, сая төгрөг	31
График 5	ЭХҮТ ТӨХХК-ийн олгосон тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн үйлчилгээний хөлсний мэдээлэл, сая төгрөгөөр	33
График 6	2020-2026 оны сүлжээний усны тооцоот зарцуулалт, тонн/цаг	50
График 7	АДС-ын ДЭХ-ний үйлдвэрлэл, өртөг, борлуулалтын судалгаа	56

График 8	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн ДЭХ-ний бодит өртөг, борлуулсан дундаж үнийн харьцуулалт (2025 он)	61
График 9	Сайжруулсан түлшний өдрийн хэрэглээ	74
График 10	Түлшний олдоц муудсан авч буй арга замууд, түлшний цэгийн байршилд өгсөн үнэлгээ	75

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дулаан хангамжийн хангамжтай холбогдох бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцооны одоогийн үйл явцын Графиклал	21
Дүрслэл 2	Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар	26
Дүрслэл 3	Эрчист Монгол ХХК-ийн зорилго, үйл ажиллагааны чиглэл	27
Дүрслэл 4	Салбарын ТӨК-уудын удирдлагын тогтолцооны ерөнхий Графиклал	29
Дүрслэл 5	ЭХЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг	34
Дүрслэл 6	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн үйл явцын Графиклал	37
Дүрслэл 7	ДЦС-4 ТӨХК-ийн эх үүсвэрээс шууд холбогдсон ачаалал, хэрэглэгчийн тоо	48
Дүрслэл 8	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн ДЭХ-ний бодит өртөг, борлуулсан дундаж үнийн харьцуулалт (2025 он)	53
Дүрслэл 9	Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км дулааны шугамын байршлын График	54

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хавсралт 1	ТУЗ-ийн гишүүдийн ажиллаж буй байгууллага, албан тушаалын мэдээлэл	93
Хавсралт 2	Төвлөрсөн дулаан хангамжийн системийн ДЦС-уудын үндсэн тоноглолуудын ашиглалтын судалгаа	95
Хавсралт 3	Төвлөрсөн дулаан хангамжийн дулааны техникийн нөхцөл олголтын судалгаа, 2020-2025 он, хүсэлтийн тоо, хүчин чадал Гкалаар	96
Хавсралт 4	УБДС ТӨХК-ийн 2020-2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	96
Хавсралт 5	Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн дулаан хангамж, инженерийн дэд бүтцийн ажлын гүйцэтгэл	97
Хавсралт 6	Эрдэнэс-Тавантолгой ХК-аас Тавантолгой түлш ХХК-тай байгуулсан гэрээ, олгосон санхүүжилтийн мэдээлэл	98
Хавсралт 7	Тавантолгой түлш ХХК-ийн зээлийн эргэн төлөлт хийх хуваарь	100
Хавсралт 8	Тавантолгой түлш ХХК-ийн 2018-2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн мэдээлэл	101
Хавсралт 9	Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын Гэрээт ажилчдад олгосон цалингийн мэдээлэл	102

ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаалаар баталсан сэдвийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Улаанбаатар хотын дулаан хангамжийн найдвартай бэлэн байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах бодлого, тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
- Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагаа үр дүнтэй эсэх;
- Улаанбаатар хотын төвлөрсөн инженерийн байгууламжгүй байшин болон гэрт амьдардаг хэсгийн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг түлшээр хангах, түгээх үйл ажиллагаа үр дүнтэй эсэх.

ХАМАРСАН ХҮРЭЭ

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үүрэг хүлээсэн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргалт, чиг үүргийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тайлагнал, мөн төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байдал, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, үр дүн болон бусад холбогдох үйл ажиллагаа, баримт материалыг хамруулсан.

Аудитад Эрчим хүчний яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрчим хүчний зохицуулах хороо, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Тавантолгой түлш ХХК, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, ОСНААУГ ОНӨААТҮГ, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, Эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ, Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК, Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК, Амгалан дулааны станц ТӨХК, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Үндэсний статистикийн хороо болон бусад холбогдох байгууллагын 2020-2025 оны үйл ажиллагааг хамрууллаа.

АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль тогтоомжийг аудитын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хууль эрх зүйн шалгуур үзүүлэлт:

- НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 онд баталсан Тогтвортой хөгжлийн зорилт 2030;
- Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (2.0);
- Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (3.0);
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /хүчингүй болсон/;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай;

	- Компанийн тухай хууль; - Монгол Улсын Засгийн газрын тухай хууль; - Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль; - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; - Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль; - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль; - Хууль тогтоомжийн тухай хууль; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; - Хөдөлмөрийн тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Төрийн албаны тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; <i>Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт:</i> - УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”; - УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”; - УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; - УИХ-ын 2024 оны 64 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай”; - Засгийн газрын 2018 оны Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 62 дугаар тогтоол; - Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”; - Засгийн газрын 2021 оны 374 дүгээр “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол; /Хүчингүй болсон/ - Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, 2024-2028; - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 02/09 дүгээр тогтоол зэрэг
АУДИТЫН БҮРЭЛДЭХҮҮН	Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Саруул хэрэгжүүлэн, ахлах аудитор С.Дарьмаа, Б.Батдэлгэр, Т.Төмөрбаатар, аудитор Н.Онон, Б.Очмаа, Г.Очирваань нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.
ТАЛАРХАЛ	Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох байгууллага, ажилтан, албан хаагчдад талархал илэрхийлье.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн хотуудын нэг бөгөөд агаарын дундаж температур өвлийн улиралд буюу жилийн 1, 2, 11, 12 дугаар саруудад хасах 10.1°C-аас хасах 18.9°C хүртэл буурч, үнэмлэхүй бага температур дээрх саруудад хасах 25.6°C-аас хасах 31.3°C хүртэл хүйтэрдэг байна. Зуны улиралд үнэмлэхүй бага температур эерэг утгатай байх боловч 5 дугаар сарын үнэмлэхүй бага температур хасах 3.0°C, 9 дүгээр сард хасах 2.5°C хүртэл хөрж, зун болон намрын эхэн саруудад хүйтэрдэг нөхцөл байдлаас харахад Улаанбаатар хотын 1,673.3 мянган хүн ам, 490.5 мянган айл өрхийн хувьд дулаан байх хэрэгцээ жилийн 8-9 сарын туршид үргэлжилдэг онцлогтой байна.

Хүснэгт 1. Улаанбаатар хотын сарын дундаж агаарын температурын мэдээлэл

№	Үзүүлэлт	2020-2025 оны дундаж											
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	Агаарын дундаж температур	-18.9	-15.2	-4.7	3.7	10.4	16.7	18.9	16.4	11.0	1.0	-10.1	-18.8
2	Үнэмлэхүй их температур	-4.3	2.5	14.1	23.1	27.3	27.0	32.5	29.8	27.4	17.0	8.0	-4.4
3	Үнэмлэхүй бага температур	-31.3	-28.6	-20.6	-10.9	-3.0	2.3	7.0	5.7	-2.5	-11.1	-25.6	-29.7

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, www.1212.mn

Өнгөний тайлбар: Цэнхэр өнгөөр -10°C-аас доош температур, улаан ягаан өнгөөр 0-20°C температур, ногоон өнгөөр 20°C-аас дээш температурыг ялгаж харуулав.

Эрчим хүчний тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Салбарын сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар Улаанбаатар хотын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангах халаалтын хугацааг эмнэлэг, сургууль, орон сууцны айл өрхийн хувьд тухайн оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр эхэлж, дараа оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болохоор, ААНБ-ын хувьд тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр эхэлж, дараа оны 5 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болохоор тус тус тогтоосон байна.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн систем

Улаанбаатар хотын дулаан хангамжийн систем нь дараах 3 хэв загвараас бүрдэж байна. Үүнд:

- **Төвлөрсөн дулаан хангамжийн систем¹:** Дулааны цахилгаан станц, дулааны станцын үйлдвэрлэсэн дулааныг дулаан дамжуулах шугам сүлжээгээр дамжуулан дулаанаар хангах систем;
- **Хэсэгчилсэн буюу бие даасан дулаан хангамжийн систем:** Гэр хорооллын болон төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хэсэгт тусдаа бага чадлын эх үүсвэрээс дулаанаар хангах систем;
- Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжид холбогдоогүй гэр, амины орон сууцанд амьдардаг айл, өрхийн дулаан хангамж.

Улаанбаатар хотод 2025 онд 490.5 мянган өрх, 1,673.3 мянган хүн ам оршин сууж байгаа нь өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад өрхийн тоо 50.9 мянга буюу 11.6 хувиар, хүн амын тоо 82.6 мянга буюу 5.2 хувиар нэмэгджээ. 2025 оны байдлаар нийт өрхийн 284.7 мянга буюу 58.0 хувь нь, хүн амын 986.1 мянга буюу 58.9 хувь нь төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжид холбогдсон орон сууцанд амьдарч байгаа бол үлдсэн хэсэг нь гэр болон амины орон сууцанд амьдарч байна.

Төвлөрсөн инженерийн байгууламжгүй хэсэгт амьдардаг өрхийн тоо өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 2.7 мянгаар нэмэгдсэн ч, хүн амын тоо 6.0 хувиар буурсан нь төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хэсгээс өрх тусгаарлаж, орон сууцанд шилжин амьдарч байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын өрх, хүн амын тоо дулаан хангамжийн хэлбэрээр, мянган нэгж

№	Үзүүлэлт	Хэм-жих нэгж	2020	2021	2022	2023	2024	Өмнөх 5 жилийн дундаж	2025	Өөрчлөлт (нэмэгдсэн +, хасагдсан -)
---	----------	--------------	------	------	------	------	------	-----------------------	------	-------------------------------------

¹ Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д "төвлөрсөн дулаан хангамж гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагааг" гэж заажээ.

										Тоо	Хувь
1	Нийт өрх	Тоо	414.3	412.5	431	465.1	475.1	439.6	490.5	50.9	11.6
2	Нийт хүн ам	Тоо	1,499.1	1,539.3	1,596.3	1,640.8	1,677.9	1,590.7	1,673.3	82.6	5.2
Үүнээс	<i>Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжид холбогдсон орон сууцанд амьдардаг</i>										
		Тоо	206.3	212.1	229.7	260.4	273.8	236.5	284.7	48.2	20.4
	Өрх	Дүнд эзлэх хувь	49.8	51.4	53.3	56	57.6	53.8	58.0	4.2	7.8
		Тоо	748	790.6	858.6	925.7	976.4	859.9	986.1	126.2	14.7
	Хүн ам	Дүнд эзлэх хувь	49.9	51.4	53.8	56.4	58.2	54.1	58.9	4.8	8.9
	<i>Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжид холбогдоогүй гэр, амины орон сууцанд амьдардаг</i>										
		Тоо	208	200.4	201.3	204.7	201.3	203.1	205.8	2.7	1.3
	Өрх	Дүнд эзлэх хувь	50.2	48.6	46.7	44	42.4	46.2	42	-4.2	-9.1
		Тоо	751.1	748.7	737.7	715.1	701.5	730.8	687.2	-43.6	-6.0
	Хүн ам	Дүнд эзлэх хувь	50.1	48.6	46.2	43.6	41.8	45.9	41.1	-4.8	-10.5

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжид холбогдоогүй айл өрхүүд хүйтний улиралд дулааны хэрэгцээгээ хангах зорилгоор нүүрс, түлээ зэрэг хатуу түлш, шатах материал хэрэглэж байгаа нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын үндсэн шалтгаануудын нэг болж байна.

Хууль эрх зүйн орчин

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үйл ажиллагааг Эрчим хүчний тухай 2001 оны хуулиар зохицуулж байна. Уг хуулийн 2 дугаар бүлэгт төрийн байгууллагуудын бүрэн эрхийг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- Улсын Их Хурлын бүрэн эрхийг 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт;
- Засгийн газрын бүрэн эрхийг 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт;
- Эрчим хүчний яамны чиг үүргийг 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт;
- Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт;
- Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрхийг 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт;
- ДҮТ ТӨХХК-ийн бүрэн эрхийг 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт;
- Нийслэлийн зохицуулах зөвлөлийн бүрэн эрхийг 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт тус тус зохицуулсан байна.

Мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай 2021 оны хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.8-д нийслэлийн цахилгаан эрчим хүч, дулааны төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн хангамж; 8.3.16-д ус, дулаан, цахилгаан хангах, түгээх, дамжуулах үйл ажиллагааг нийслэл хотын чиг үүрэг болгон хуульчилсан байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.17², 12.1.19³, 12.1.20⁴-д зааснаар хот нь дулааны төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн хангамж, дулаан түгээх сүлжээний барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт, дулаанаар хангах, түгээх, дамжуулах үйл ажиллагаа нь хотын нийтлэг чиг үүрэгт хамаарч байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2020 оны хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.14⁵-т зааснаар дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналтын чиг үүргийг нийслэл

2 хотын цахилгаан эрчим хүч, дулааны төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн хангамж;

3 харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;

4 ус, дулаан, цахилгаан хангах, түгээх, дамжуулах үйл ажиллагаа;

5 харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;

хэрэгжүүлэхээр, 27 дугаар зүйлийн 27.5.16⁶-д зааснаар нэгжийн удирдлага дулааны шугамын ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг эрхлэхээр, 61 дүгээр зүйлийн 61.1.10⁷-т зааснаар хороодын Засаг дарга нар дулаан хангамжийн зохион байгуулалт, хүртээмжид хяналт тавьж, иргэдээс гарсан санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах чиг үүрэгтэй байна.

Дулаан хангамжтай холбоотой бодлого, хөтөлбөрүүд

Дэлхийн түвшинд эрчим хүчний салбарын бодлого нь боломжийн үнэтэй, найдвартай эрчим хүчний үйлчилгээгээр хүн амыг бүрэн хангах, сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үр ашгийг хоёр дахин нэмэгдүүлэх зорилтыг хамарч байна. Мөн цэвэр эрчим хүчний технологи, инновацийн чиглэлд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, холбогдох дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээг тусгасан байна.

Дэлхийн эдийн засгийн форум нь дэлхийн улс орнуудын эрчим хүчний шилжилтийн бодлого, түүний хэрэгжилтийн үр дүнг илэрхийлэх эрчим хүчний шилжилтийн индексийг жил бүр тооцон нийтэлдэг. Монгол Улсын эрчим хүчний шилжилтийн индекс 2025 онд 44.2 хувь болж дэлхийн 118 орноос 115 дугаар байранд орж, 2020 оноос 2.1 нэгж хувиар нэмэгдэж 7 байраар урагшилсан хэдий ч 2024 оноос 1.2 нэгж хувиар буурч (116-р байр) 1 байраар ухарсан байна. Дэлхийн түвшинд эрчим хүчний шилжилтийн индекс 2025 оны байдлаар 56.9 хувь байгаагаас манай улс 12.7 хувиар доогуур байна.

Хүснэгт 3. Улс орнуудын эрчим хүчний шилжилтийн индекс

№	Үзүүлэлт	2020	2021	2022*	2023	2024	2025
1	Хамрагдсан улсын тоо	115	115	120	120	120	118
2	Дэлхийн эрчим хүчний шилжилтийн индекс	55.1	59	-	56.3	56.5	56.9
3	Монгол Улсын эрчим хүчний шилжилтийн индекс (ETI)	42.1	44	43.6	45.4	45.4	44.2
4	Системийн гүйцэтгэл (SP)	45.0	51.5	53.4	56.3	55.3	53.7
	Шилжилтийн бэлэн байдал (TR)	39.0	37.0	29.0	29.0	30.5	29.9
5	Монгол Улсын эзэлж буй байр	108	113	117	111	116	115

Эх сурвалж: *Fostering Effective Energy Transition report, World economic forum*

Тайлбар: * - [World Economic Forum](https://www.weforum.org/publications/energy-transition-report/)


Монгол Улсын эрчим хүчний системийн гүйцэтгэл 2025 онд 53.7 хувь байгаа нь харьцангуй дундаж түвшнийг илтгэх ба тус салбарын үндсэн үйл ажиллагаа тогтворжиж буйг харуулж байна. Эрчим хүчний тэгш байдал 69.8 хувь буюу бусад бүрэлдэхүүн индексээс өндөр байгаа нь хүртээмжтэй байдал, тэгш боломжийг хангах тал дээр систем ахиц гаргаж байгааг харуулна. Аюулгүй байдал 42.1 хувь, Тогтвортой байдал 49.2 хувь байгаа нь эрсдэлийг удирдах, системийн найдвартай, аюулгүй ажиллагааг бэхжүүлэх шаардлагатайг харуулна.

2025 оны байдлаар шилжилтийн бэлэн байдлын түвшин 29.9 хувь байгаа нь хангалтгүй түвшин бөгөөд цаашдын шинэчлэл, өөрчлөлтөд дасан зохицох, шилжих чадамж сул байгааг харуулж байна. Энэ үзүүлэлтэд санхүү, хөрөнгө оруулалт, инновац, хүний нөөцийн чадавх, дэд бүтцийн дэд индексүүд 24.3-25.9 хувь байгаа нь голлон нөлөөлж байна. Харин хууль тогтоомжийн үзүүлэлт 57.7 хувьд хүрсэн нь тухайн бүлэг доторх хамгийн өндөр буюу харьцангуй боломжийн түвшин юм.

6 эрчим хүч, өндөр хүчдэлийн болон цахилгаан, дулааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагаа

7 хүн амын хүнс, худалдаа, үйлчилгээ, цахилгаан, дулаан хангамжийн зохион байгуулалт, хүртээмжид хяналт тавьж, түүнийг сайжруулах талаар иргэдээс гарсан санал, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах

График 1. Монгол Улсын эрчим хүчний шилжилтийн бэлэн байдлын индекс, бүрэлдэхүүн индекс, 2025 оны байдлаар



Эх сурвалж: [World Economic Forum](https://www.weforum.org/)

Дулаан хангамжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олголт

Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-д зааснаар ЭХЗХ нь дулаан хангамжийн үйл ажиллагаанд дараах тусгай зөвшөөрлийг олгож байна. Үүнд:

- дулаан үйлдвэрлэх;
- дулаан дамжуулах;
- диспетчерийн зохицуулалт хийх;
- дулаан түгээх;
- эрчим хүчээр зохицуулалттай хангах;
- эрчим хүчээр зохицуулалтгүй хангах;
- эрчим хүчний барилга байгууламж барих;
- хийгээр хангах.

Харин улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээний хуульд заасан дээрх тусгай зөвшөөрлийг зөвхөн ЭХЗХ, бусад зөвшөөрлийг Нийслэлийн зохицуулах зөвлөл олгохоор хуульчилсан байна.

Эрчим хүчний тухай хуулиар ЭХЯ тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргахаар заасан боловч Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14⁸-т зааснаар дараах тусгай зөвшөөрлийг олгохоор байна. Үүнд:

- эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт тохируулга хийх;
- даралттай зуух, даралтат савны угсралт, засвар, туршилт тохируулга хийх;
- даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, туршилт тохируулга хийх;
- даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, туршилт тохируулга хийх;
- эрчим хүчний барилга байгууламжийн График төсөл боловсруулах.

2025 оны байдлаар төвлөрсөн дулаан хангамжийн чиглэлээр үйлдвэрлэх 4, түгээх 61, дулаанаар зохицуулалттай хангах 63, нийт 64, хэсэгчилсэн дулаан хангамжийн чиглэлээр үйлдвэрлэх 24, түгээх 15, дулаанаар зохицуулалттай хангах 15, нийт 25 тусгай зөвшөөрөл бүхий ААНБ үйлчилгээ үзүүлж байна.

8. Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Дулаан хангамжийн үйлчилгээний үнэ тариф

Эрчим хүчний үнэ тарифыг⁹ Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4¹⁰, 9.1.14¹¹-т заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хороо эрчим хүч үйлдвэрлэх түлшний үнэ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж, батлан, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоож байгаа хэдий ч үйл ажиллагааны зардалд нөлөөлөх хүчин зүйлсээр индексжүүлэхгүй байна.

Мөн дээрх хуульд Тарифыг эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хангах үйл ажиллагаа тус бүрээр үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхыг алдагдуулахгүй, үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон ашгийн зохих түвшин хангасан байх хэмжээнд тогтоохоор заажээ.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон орон сууцны хэрэглэгчдийн төлж буй халаалтын үнэ 2021-2025 онд 1 төг/м²-д 506.0 төгрөг, хэрэгцээний халуун ус халаасан үнэ 1 төг/хүнд халаалтын улиралд 1,870.0 төгрөг, халаалтын бус улиралд 2,806.0 төгрөг буюу өөрчлөлтгүй тогтмол байсан байна.

Хүснэгт 4. Орон сууцны айл өрхөд борлуулах ДЭХ-ний тарифын мэдээлэл

Ангилал	Хэрэгцээний халуун ус халаасан дулаан						Дулааны үйлчилгээний тариф, төг/сар		
	Хэмжих нэгж		Халаал-тын улиралд	Халаал-тын бус улиралд	Усны зарцуулалт	Хэмжүүрээр			
	төг/м ²	төг/ГЖ	хүн	төг/хүн	төг/м ³	төг/ГЖ	40 м ²	40-80 м ²	81 м ² -аас дээш
Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон	506.0	3,421.0	1,870.0	2,806.0	1,632.0	3,421.0	3,300.0	5,500.0	11,000.0
Налайх	600.0		2,875.0	4,025.0	5,000.0		3,000.0	5,000.0	10,000.0
Багануур	845.0	11,150.0	4,049.0	5,668.0	2,089.0	11,150.0	4,224.0	7,040.0	14,080.0
Багахангай	460.0	3,078.8			1,800.0				
УБТЗ	556.0	3,763.0	2,057.0	3,086.0	1,795.0	3,763.0	3,630.0	6,050.0	12,100.0

Эх сурвалж: ЭХЗХ, Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2025 он

Хүснэгт 5. ААНБ-уудад борлуулах ДЭХ-ний тарифын мэдээлэл

Ангилал	Хэмжих нэгж		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Технологийн уур
	Төг/м ³	Төг/ГЖ	Төг/м ³	төг/хүн	
Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон	604.0	9,314.0	2,637.0		6,908.0
Налайх	1,100-1,651	33,041.0	6,912.0	6,930.0	
Багануур	1,487-1,549	23,767-33,234			
Багахангай	1,200.0	21,718.0	6,500.0	5,040.0	
УБТЗ ХНН	665.0	10,245.0	2,900.0		

Эх сурвалж: ЭХЗХ, Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2025 он

⁹ Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.22-т "тариф" гэж үйлдвэрлэгчийн үнэ, дэмжих тариф диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ, хэрэглэгчийн эрчим хүчний үнэ, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Эрчим хүчний зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнийг гэж тодорхойлжээ.

¹⁰ тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;

¹¹ эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах

БҮЛЭГ 1. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ БОДЛОГЫГ ӨСӨН НЭМЭГДЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, БОДЛОГЫН НЭГДМЭЛ БОЛОН ЗАСАГЛАЛЫН ХАРААТ БУС БАЙХ ЗАРЧМУУД АЛДАГДСАН НЬ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ, СИСТЕМИЙН НАЙДВАРТАЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖЭЭ

Оршил

ҮАГ-аас 2025 онд Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг зардал сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, тайланд НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилт 2030, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр байгуулсан Парисын хэлэлцээр, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын хүрээнд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлого, Эрчим хүчний салбарын бодлого хоорондын уялдаа, тулгамдаж буй асуудлыг дэлгэрэнгүй тайлагнасан.

Аудитаар дараах дүгнэлтийг өгч, шаардлагатай зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тул энэхүү аудитаар эрчим хүчний салбарын нэгдсэн бодлогын уялдаа холбоог орхиж, зөвхөн Улаанбаатар хотын дулаан хангамжтай холбоотой бодлого, зохицуулалтыг авч үзлээ.

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д эрчим хүчний талаар дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгахдаа Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн 244 шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, мэдээллийн бэлэн байдал хангаагдаагүйгээс салбарын хөгжлийг хэмжих боломжгүй;
- Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, байгалийн нөөцийн үр ашигтай менежмент хийх, ногоон санхүүжилт татах зэрэг арга хэмжээг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгаснаар үр дүнг тооцох, хянах нөхцөл бүрдэнэ.
- Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрээс доош чиглэсэн, салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн саналыг нэгтгэн доороос дээш чиглэсэн нэгдмэл уялдаа холбоотой байхаар төлөвлөх шаардлагатай;
- Эрчим хүчний салбарын төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компаниуд нь тайлант хугацаанд эдийн засаг, санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж, зарим аж ахуйн нэгжүүдэд улсын төсвөөс татаас авч байгаа нь компанийн засаглалыг сайжруулах, гүйцэтгэх удирдлагын хариуцлага, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай;
- Дэлхийн эрчим хүчний зөвлөлөөс гаргасан түлш, эрчим хүчний асуудлыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг ахиулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч чадахгүй, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй;
- Засгийн газар бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний зохицуулах хороог байгуулах, дүрмийг батлах, зохицуулагчийг томилж байгаа нь ЭХЗХ чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөл бүрдээгүй гэж дүгнээд холбогдох байгууллагуудад зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд одоогийн байдлаар хэрэгжилт хангаагдаагүй байна.

Эрчим хүчний салбарын бодлогын нэгдмэл байх зарчим алдагдсан нь нэгдсэн төлөвлөлтөд давхардал, хийдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж, засаглалын хувьд Засгийн газраас хараат байгаа нь дулааны эрчим хүчний үнэ тариф бодит өртөгт хүрэхгүй байх нөхцөл болсоор байна

1.1 Эрчим хүчний тухай хуулиар ЭХЯ: дулаан хангамжийн төрийн бодлого боловсруулах, дүрэм, журмыг батлах, аюулгүйн нөөц, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, Нийслэлийн Засаг дарга: нутаг дэвгэрийнхээ хувьд эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулах, хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээж байгаа ч өнөөгийн байдлаар ЭХЯ нь төвлөрсөн дулаан хангамжийн бодлогыг тодорхойлох, харин нийслэл төвлөрсөн бус дулаан хангамжийн бодлогыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь салбарын бодлого нэгдмэл байх зарчим алдагдсаныг харуулж байна.

1.2 Засгийн газрын 2025 оны 07 дугаартай тогтоолоор баталсан Эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн

Яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн 2.2.4¹², 2.2.6¹³ дахь заалт, мөн Үйл ажиллагааны стратегийн зорилтын 2.4.1¹⁴, 2.4.2¹⁵ дэх заалтуудаар эрчим хүчний эх үүсвэрүүдийн хүчин чадлыг өргөжүүлэх, салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, салбарын стратеги, бодлогыг боловсруулах, эх үүсгүүрийн төрлийг нэмэгдүүлэх замаар тасралтгүй, найдвартай, тогтвортой үйл ажиллагааг хангахаар тусгасан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.3 Мөн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.17¹⁶, 12.1.19¹⁷, 12.1.20¹⁸ дахь заалтууд, Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.8¹⁹, 8.3.16²⁰, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.14²¹ дэх заалттай ижил агуулгатай байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1²², 32.2²³-т заасантай тус тус нийцэхгүй байна.

1.4 Эрчим хүчний тухай хуулиар ЭХЗХ-ны бүрэн эрхийг тодорхойлсон ба Засгийн газрын 2016 оны 132 дугаар тогтоолоор ЭХЗХ-ны дүрмийг шинэчлэн баталж, дүрмийн 1.2-т *Хороо чиг үүргээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх зохицуулалтын байгууллага бөгөөд үйл ажиллагаандаа ... энэ дүрмийг баримтална* гэж заажээ.

1.5 Харин Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3²⁴-т гэж зааснаас үзэхэд ЭХЗХ чиг үүргээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйг харуулж байна.

Хүснэгт 6. ЭХЗХ-ны удирдлага, зохицуулагчдын мэдээлэл

№	Албан тушаал	Томилсон огноо	Хугацаа, жилээр	Захирамжийн он, дугаар
1	Зохицуулах хорооны дарга	2022.08.22	4	2022 оны 123
2	Орон тооны зохицуулагч 1	2022.08.22	4	2022 оны 125
3	Орон тооны зохицуулагч 2	2026.03.20	4	2026 оны 48
4	Орон тооны бус зохицуулагч 1	2026.03.05	3	2026 оны 37
5	Орон тооны бус зохицуулагч 2	2025.05.21	2	2025 оны 90

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж


1.6 ЭХЗХ-ны дарга, орон тооны зохицуулагч нарыг салбарын сайдын санал болгосноор Ерөнхий сайд томилж байгаа нь ЭХЗХ-ны үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдалд гүйцэтгэх засаглал шууд нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал,

- Засгийн газрын 2025 оны 132 дугаар тогтоолоор хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг ...
- Засгийн газрын 2025 оны 236 дугаар тогтоолоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний үнэ, тариф, төлбөр, хураамжийг 2026 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхаар тус тус шийдвэрлэсэн.

- 12 эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх
- 13 эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс болон бусад төрөл)-ний салбартшинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- 14 эрчим хүчний салбарын стратеги төлөвлөлтийн бодлогыг боловсруулах, уламжлалт болон сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний түлшний талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцсэн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- 15 эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэлийн ашиглалт, аюулгүй байдлыг хангах, эрчим хүчний нүүрсний хангамжийн тасралтгүй, найдвартай байдал, нүүрсний чанар, нөөцийн тогтвортой үйл ажиллагааг хангах, зохион байгуулах;
- 16 хотын цахилгаан эрчим хүч, дулааны төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн хангамж;
- 17 харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;
- 18 ус, дулаан, цахилгаан хангах, түгээх, дамжуулах үйл ажиллагаа;
- 19 нийслэлийн цахилгаан эрчим хүч, дулааны төвлөрсөн болон төвлөрсөн бус инженерийн хангамж;
- 20 ус, дулаан, цахилгаан хангах, түгээх, дамжуулах үйл ажиллагаа;
- 21 харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;
- 22 Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ.
- 23 Хуульд бусад хуулиас эшлэл хийхдээ тухайн заалтыг эх бичвэрээр нь хуулбарлахыг хориглоно.
- 24 Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно

1.7 Засгийн газрын дээрх шийдвэрүүдээр ЭХЗХ-ны 2024 оны 639 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Үйлдвэр, аж ахуйн нэгж болон бусад байгууллагад борлуулах дулааны үнэ тариф”, “Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ тариф”-ыг мөрдөх хугацааг хойшлуулсан нь нэг талаас айл өрх, ААНБ-д очих санхүү, эдийн засгийн дарамт, ачааллаас хамгаалсан шийдвэр мэт харагдаж байгаа ч нөгөө талаас ДЭХ үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхлэх ТЗЭ-дэд санхүү, эдийн засгийн дарамт болж, үйл ажиллагааны алдагдлыг нэмэгдүүлж, урт, богино хугацаат өр төлбөр шинээр үүсэх, хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

График 2 Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах ТЗЭ-дийн борлуулалтын орлого, зардал, сая төгрөг



Эх сурвалж: ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, АДС ТӨХК-ууд, УБДС ТӨХХК, ОСНААУГ ОНӨААТҮГ, ХОСК-ууд

1.8 Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах ТЗЭ-дийн орлого 2025 онд 268,392.6 сая төгрөг, зардал 471,663.4 сая төгрөгт хүрч, үйл ажиллагааны зардал нь орлогоосоо 203,270.8 сая төгрөгөөр давсан байна.

1.9 Түүнчлэн, улсын төсөвт тусгагдсан дулааны эрчим хүчний алдагдлын татаасын хэмжээ ирэх онуудад өсөх хандлагатай байна. Тухайлбал, дулааны эрчим хүчний алдагдлын татаас 2020-2024 онуудад жилд дунджаар 8,422.3 сая төгрөг байсан бол 2025 онд 19,782.0 сая төгрөгт хүрч, өмнөх дундажтай харьцуулахад 11,359.7 сая төгрөг буюу 2.3 дахин нэмэгдсэн байна.

1.10 АДБОУБ-ын дэргэдэх Олон Улсын Хөгжлийн агентлагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд аудит хийх удирдамж “Үндэсний зорилтуудын биелэлтийг хангахад чиглэсэн багц бодлогын хэрэгжилтийг үнэлэх загвар”-ын дагуу хийсэн дулаан хангамжийн системийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах тогтолцооны уялдаа холбооны зураглалаас харахад бодлогыг хэрэгжүүлэх тогтолцооны уялдаа холбоо алдагдсан, хоорондын хамаарал бүрэн хангагдаагүй байна.

Дүрслэл 1. Дулаан хангамжийн системийн бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцооны зураглал

Оролцогч	Хууль эрх зүйн зохицуулалт /Норм, дүрэм, журам г.м/	Бодлогын нэгдмэл, засаглалын хараат бус байдал	Бүтэц чиг үүрэг, зохион байгуулалт, хүний нөөц	Санхүү, хөрөнгө оруулалт	Тоноглол, шугам сүлжээний аюулгүй, найдвартай байдал	Дулааны анхдагч эх үүсвэрийн нөөц, хуваарилалт	Эрчим хүчний хэмнэх арга хэмжээ	Хяналт, шалгалт
УИХ	ЭХЗХ, Нийслэлийн зохицуулах зөвлөл	МУЗГ, ЭХЯ, НЗД						

МУЗГ		ЭХЯ, НЗД, ЭХЗХ	ЭХЯ, НЗД, ДЦС-ууд, ЭХҮТ, ЦДҮС, ЦТС, ДҮТ, ТӨБЗГ	ЭХЯ	ЭХЯ, ДЦС-ууд	ЭХЯ		ЭХЯ
ЭХЗХ	МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ					ЭХЯ	
ДҮТ		УБДС, НЗДТГ						
ЭХҮТ			МУЗГ	МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ			
УБДС	ЭХЯ, ЭХЗХ			МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ			
ДЦС-2, 3, 4, АДС	ЭХЯ, ЭХЗХ			МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ			
ОСНААУГ	ЭХЯ, ЭХЗХ			МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ			
ХОСК	ЭХЯ, ЭХЗХ			МУЗГ, ЭХЯ	МУЗГ, ЭХЯ			
НЗД, ИТХ		ЭХЯ		МУЗГ	МУЗГ	Багануур, Налайх ДЦС		
ТТТ ХХК	МУЗГ	МУЗГ, ЭХЯ		МУЗГ, ТӨБЗГ, ОБЕГ				

Өнгөний тайлбар: ногоон- хангагдсан, улаан-хангагдаагүй, шар- сайжруулах шаардлагатай
Эх сурвалж: Аудитын баг

1.11 Тухайлбал, одоогийн хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд дулаан хангамжийн салбарын бодлогын нэгдмэл байдал, тарифын бодлого тогтооход засаглалын хараат бус байдлыг хангах зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалан дулааны эрчим хүчний үнэ тариф өөрийн өртгөөс доогуур хэвээр байна. Үүнтэй уялдан салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд санхүү, эдийн засгийн алдагдал, техник технологийн хоцрогдолд орж, улмаар хэрэглэгчдийг шаардлагатай дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах боломж хязгаарлагдаж байна.

Салбарын хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, цалин урамшууллыг нэгдсэн зарчмаар зохицуулах механизм бүрдээгүй нь цаашид мэргэшсэн инженер, техникийн ажилтны хомсдол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна

1.12 ЭХЯ нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10²⁵-д заасан эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг өнөөг хүртэл боловсруулаагүй байна.

1.13 ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, АДС ТӨХК-иудын ажиллагсдын тоо 2021-2023 онд 11-16-аар буурч, 2024 онд 2,969 болж өмнөх оноос 1.1 хувиар нэмэгдсэн, харин 2025 онд 2,947 болж өмнөх оноос 22 буюу 0.7 хувиар буурахад инженер-техникийн ажилчид тоо 2.4 хувь буюу 17-оор буурсан нь нөлөөлжээ. Мөн дулаан түгээх, хангах ТЗЭ-дийн ажиллагсдын тоо ч буурах хандлагатай байна.

Хүснэгт 7. Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах байгууллагуудын ажиллагсдын тоо, өөрчлөлтийн хувь

Хүний нөөцийн бүтцийн ангилал	Үйлдвэрлэх ажиллагсдын тоо, өөрчлөлт						Түгээх, хангах ажиллагсдын тоо, өөрчлөлт					
	2020	2021	2022	2023	2024	2025	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт	2,974	2,958	2,947	2,936	2,969	2,947	3,694	2,992	3,159	3,018	2,910	2,834
Удирдлага	15	15	9	5	5	5	229	162	156	125	129	118
Ажилчид	2,308	2,294	2,279	2,221	2,256	2,251	2,149	1,819	1,967	1,911	1,827	1,790
ИТА, АХ*	651	649	659	710	708	691	1,316	1,011	1,035	982	954	926
Өмнөх онтой харьцуулснаар өөрчлөлтийн хувь												
Нийт	-	-0.5	-0.4	-0.4	1.1	-0.7	-	-19.0	5.6	-4.4	-3.6	-2.6
Удирдлага	-	0.0	-40.0	-44.4	0.0	0.0	-	-29.1	-3.8	-19.7	2.7	-8.2
Ажилчид	-	-0.6	-0.7	-2.5	1.6	-0.2	-	-15.4	8.1	-2.8	-4.4	-2.1
ИТА, АХ*	-	-0.3	1.5	7.7	-0.3	-2.4	-	-23.2	2.4	-5.1	-2.9	-2.9

Тайлбар: *- Инженер, техникийн ажилтан, албан хаагчид

²⁵ эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах;

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

1.14 ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, АДС ТӨХК-иудын ажиллагсдын сарын дундаж цалин 2025 онд 4.8 сая төгрөг болж, өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад 1.8 сая төгрөг буюу 1.6 дахин нэмэгдсэн нь удирдах албан тушаалтны цалин 9.3 сая төгрөг буюу 2.2 дахин нэмэгдсэнтэй холбоотой байна. Эрчим хүчний түгээх, хангах ТЗЭ-дийн ажиллагсдын сарын дундаж цалин 2025 онд 2.2 сая төгрөг болж, өмнөх 5 жилийн дунджаас 0.9 сая төгрөг буюу 1.7 дахин нэмэгджээ.

Хүснэгт 8. Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин, сая төгрөг

Хүний нөөцийн бүтцийн ангилал	2020	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт, өмнөх 5 жилийн дундажтай харьцуулснаар	
							Мөнгөн дүн	Өсөлт
Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн дундаж цалин								
Нийт	2.4	2.4	2.8	3.1	4.2	4.8	1.8	1.6 дахин
Удирдлага	5.5	5.4	6.2	9.9	13.2	17.3	9.3	2.2 дахин
Ажилчид	2.2	2.2	2.4	2.9	3.8	4.4	1.7	1.6 дахин
ИТА, АХ*	3.2	3.2	3.5	4.0	5.4	6.1	2.2	1.6 дахин
Түгээх, хангах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн дундаж цалин								
Нийт	1.0	1.1	1.2	1.4	1.8	2.2	0.9	1.7 дахин
Удирдлага	1.2	1.3	1.5	2.0	2.3	3.0	1.3	1.8 дахин
Ажилчид	0.9	1.0	1.1	1.2	1.6	2.1	0.9	1.8 дахин
ИТА, АХ*	1.0	1.2	1.4	1.6	2.1	2.4	0.9	1.6 дахин

Тайлбар: *- Инженер, техникийн ажилтан, албан хаагчид

Эх сурвалж: ЭХЗХ-ний мэдээлэл

1.15 УБДС ТӨХК нь зохион байгуулалтын бүтцээ сүүлийн 6 жилд 9 удаа шинэчилсэн бөгөөд нэг бүтцээр дунджаар 232 хоног буюу 7.7 сарын хугацаанд ажиллаж орон тоогоо 39-өөр буюу 10.1 хувиар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 9. УБДС ТӨХК-ийн бүтэц, орон тоо болон орон тооны дээд хязгаарыг баталсан шийдвэрүүд

№	ТУЗ-ийн тогтоол				Орон тооны өөрчлөлт	Эрх, үүрэг хэрэгжүүлсэн хуанлийн хоног
	Дугаар	Эхэлсэн огноо	Дууссан огноо	Орон тоо		
1	21	2019.11.20	2020.05.20	387	-	182
2	16	2020.05.20	2020.09.11	391	4	114
3	23	2020.09.11	2021.03.25	393	2	195
4	12	2021.03.25	2022.03.14	393	0	354
5	4	2022.03.14	2022.05.17	383	-10	64
6	17	2022.05.17	2023.06.14	390	7	393
7	18	2023.06.14	2024.12.26	395	5	561
8	26	2024.12.26	2025.03.24	397	2	88
9	3	2025.02.12	2025.03.24	425	28	40
10	9	2025.03.24	2026.02.13	426	1	326
11	8	2026.02.13	-	426	0	-
Нийт				-	39	232*

Тайлбар: *- дундаж утга

Эх сурвалж: УБДС ТӨХК-ийн ТУЗ-ийн тогтоол

1.16 Салбарын ажиллагсад, ялангуяа инженер техникийн ажилтнуудын шилжилт хөдөлгөөн их байгаа нь үйл ажиллагааны залгамжлах чанарт нөлөөлж, хөдөлмөрийн хөлсний нэмэгдэл нь ажиллах хүчийг тогтвортой ажиллуулах хэмжээнд хүрээгүйг харуулж байна. Энэ нь эргээд их дээд сургуулиудад дулаан хангамжийн мэргэжлээр инженер техникийн мэргэжлээр суралцагсдын тоо буурахад нөлөөлж байна.


1.17 Удирдах ажилтан, инженер техникийн ажилтны хөдөлмөрийн хөлсний нэмэгдэл харилцан адилгүй, салбарын зарим байгууллага зохион байгуулалтын бүтцийг жилд 1-ээс 2 удаагийн давтамжтайгаар өөрчилж, удирдлагын багийн үйл ажиллагаа тогтворгүй байгаа нь мэргэшсэн ажилтныг тогтвортой ажиллуулах, улмаар ДЭХ-ний үйл ажиллагааны найдвартай байдал, засвар үйлчилгээний чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Дулааны хэрэглээний хэтийн төлөвлөлтөд Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн чиг хандлагыг харгалзаагүй нь ирээдүйн сорилтод тэсвэртэй, тогтвортой дулаанаар хангах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна

1.18 ДҮТ ТӨХХК нь дулааны хэрэглээний хэтийн төлөвлөлт, урьдчилсан таамаглалыг жил бүр тооцох үүрэг²⁶-ийг хэрэгжүүлж, компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 77 дугаар тогтоолоор баталсан Эрчим хүчний төлөвлөлтийг хийх аргачлал-ын дагуу ДЭХ-ний богино (12-24 цаг), дунд (10 хоног, нэг сар, улирал, хагас жил), урт (нэг жил ба түүнээс дээш) хугацааны төлөвлөлтийг УБДС ТӨХК-ийн дулаан түгээлтийн 2035 он хүртэлх төлөвлөгөөний саналд үндэслэн боловсруулсан байна.

1.19 УБДС ТӨХК нь 2024-2035 оны урт хугацааны дулаан түгээлтийн төлөвлөгөөг одоогийн эх үүсвэрүүдийн тооцоот ачаалал, дамжуулах шугам сүлжээний нэвтрүүлэх чадвар, агаарын температурт харгалзах сүлжээний өгөх, буцах температур, өмнөх оны гүйцэтгэлийн нийлбэрээр тооцжээ.

График 3. УБДС ТӨХК-ийн дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлт, мянган.Гкал



Эх сурвалж: ДҮТ ТӨХХК

1.20 Хүн амын 2015 оны завсрын тооллогын дүнд (1,329.2 мянган хүн) үндэслэн гаргасан 2020–2045 оны хэтийн тооцооллоор Улаанбаатар хотын хүн ам тогтвортой өсөх хандлагатай байна. Тодруулбал, нийслэлийн хүн ам 2020 онд 1,581.7 мянгад хүрч, 2015 оноос 19.0 хувиар өссөн бол 2045 он гэхэд 2,779.6 мянга болж, 2015 оныхоос 2.1 дахин нэмэгдэхээр байна.

Хүснэгт 10. Улаанбаатар хотын хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоо, мянган хүнээр

№	Үзүүлэлт	2015	2020	2025	2030	2035	2040	2045
1	Улаанбаатар хотын хүн ам	1,329.2	1,581.7	1,822.5	2,046.7	2,268.0	2,510.5	2,779.6
	2015 онтой	Тоо	-	252.5	493.3	717.5	938.8	1,450.5
2	харьцуулсан өөрчлөлт	Хувь	-	119.0	137.1	154.0	170.6	188.9
								2.1 дахин

Эх сурвалж: УСХ, Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо

1.21 Харин НЗДТГ-аас “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл”-ийг боловсруулсан ч батлагдаагүй, хүн амын өсөлтийн хэрэгцээтэй уялдсан ДЭХ-ний эх үүсвэрүүдийн хүчин чадал болон дамжуулах шугам сүлжээний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх тооцоог багтаасан урт хугацааны иж бүрэн төлөвлөлт хийгээгүй байна.

1.22 Энэ нь Улаанбаатар хотын ДЭХ-ний эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, дамжуулах шугам сүлжээний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр хийгдэх урт хугацааны хөрөнгө оруулалтыг хүн амын өсөлттэй уялдуулан төлөвлөх боломжгүй байх, цаашлаад 2045 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2.1 дахин нэмэгдэх тохиолдолд дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдал алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

²⁶ ДҮТ ХХК-ийн дүрмийн 4.1.5-д Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн цахилгаан, дулааны хэрэглээний хэтийн төлөвлөлт, урьдчилан таамаглалыг жил бүр тооцоолох үүрэгтэй байхаар заасан.

Салбарын байгууллага хоорондын мэдээлэл солилцооны давтамж, уялдаа алдагдаж, өгөгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй нь эрчим хүчний бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах мэдээлэл үнэн, бодитой байх шаардлагыг хангахгүй байна

1.23 Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтаар баталсан “Эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.5.1.4²⁷, Эрчим хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5²⁸-т зааснаар:

- ЭХЯ нь салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах;
- ДҮТ ТӨХХК нь нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

1.24 ДҮТ ТӨХХК нь нэгдсэн сүлжээний холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй ч “Эрчим хүчний салбарт 2026-2030 онд баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг”-ийн төслийг хариуцан боловсруулж, тус төвийн техникийн зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, төслийг ЭХЯ-нд хүргүүлсэн²⁹ боловч батлаагүй байна.

1.25 Салбарын сайдын 2018 оны 335 дугаар тушаалаар баталсан Эрчим хүчний салбарт 2019-2023 онд баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг (2019-2023) хэрэгжиж дууссанаас хойш 3 жил өнгөрсөн боловч дараагийн шатны бодлогын баримт бичгийг 2026 оны 6 дугаар сарын байдлаар батлуулаагүй нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4³⁰-т заасан зарчим алдагдаж, хариуцлагын тогтолцоо сул байгааг илтгэж байна.

1.26 Мэдээллийн технологийн засаглалын үндэсний “Мэдээллийн технологи MNS ISO/IEC 38506:2023”, “Өгөгдлийн засаглал MNS ISO/IEC 38505-1:2023”, “Өгөгдлийн удирдлагын MNS ISO/TR 38505-2:2023” стандартуудыг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдөж байна. Аудитаар өгөгдлийн засаглал болон өгөгдлийн удирдлагын холбогдох стандартад нийцсэн бодлого, стратегийг боловсруулаагүй байна.

1.27 ЭХЯ салбарын байгууллагуудыг мэдээллийн технологийн хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь салбарын мэдээллийн технологийн хөгжил хоцрох, тухайлбал санхүү, хүний нөөцийн болон мэдээллийн систем хөгжүүлэлтийн уялдаа алдагдах эрсдэлтэй байна.

1.28 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050-ын 2030 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 5.3³¹-ын хүрээнд үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхэд их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэх³² арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.29 Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3³³-т заасны дагуу салбарын удирдлагын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор захиргааны статистик мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх үүргүүдийг хүлээсэн ч ЭХЯ нь захиргааны статистикийн анхан шатны бүртгэл, мэдээллийн маягт, заавар болон түүний дагуу цуглуулсан өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сангүй байгаа нь салбарын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох боломж хязгаарлагдаж, ижил төрлийн мэдээллийг давхар гаргах, улмаар мэдээллийн зөрүүтэй байдал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

27 эрчим хүчний хангамжийг найдваржуулах, цахилгаан, дулааны шугам сүлжээ, мэдээллийн технологийг хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах

28 нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх

29 ДҮТ ТӨХХК-ийн 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/93 дугаар албан бичиг

30 тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

31 Зорилт 5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

32 5.3.5-д Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэх иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.

33 салбарын удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор захиргааны статистик мэдээлэл авах, мэдээллийн санг бий болгох;

1.30 Мөн Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8³⁴-д гэж заасны дагуу эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлийн статистик мэдээллийг цуглуулах, үндэсний баланс гаргах үүрэгтэй ба аж үйлдвэрийн албан ёсны мэдээллийн маягт (АҮ-1)-ын дагуу цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн сарын мэдээг ТЗЭ-ээр гаргуулан, ҮСХ-нд сар бүр (цаасан болон файл хэлбэрээр) хүргүүлдэг байна.

1.31 Энэхүү мэдээллийг гаргахад цахим систем ашиглахгүй байгаа нь цаг хугацаа хоцроох, хэмжих нэгжийг буруу оруулах, шивэлтийн бусад төрлийн нийтлэг алдаа гаргах эрсдэлтэй байна.

1.32 ҮСХ нь салбарын хэмжээнд мэдээлэл цуглуулж, нэгтгэн боловсруулж, тархааж байгаа статистикийн мэдээ, эцсийн бүтээгдэхүүний чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам³⁵-ыг мөрдөж байна.

1.33 Монгол Улсын Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын дагуу салбаруудын статистикийг загварчлах удирдамжийг ҮСХ-ны даргын 2017 оны А/205 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь Төрийн нэгдсэн өгөгдлийн санг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой арга зүйн удирдамж болсон байна.

Дүрслэл 2. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ			МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ТАРХААХ				ҮНЭЛЭХ
1 дэх үе шат	2 дахь үе шат	3 дахь үе шат	4 дэх үе шат	5 дахь үе шат	6 дахь үе шат	7 дахь үе шат	8 дахь үе шат
Хэрэгцээг тодорхойлох	Төлөвлөх	Статистикийн үйл ажиллагааны загварыг бий болгох	Мэдээлэл цуглуулах	Мэдээлэл боловсруулах	Дүн шинжилгээ хийх	Тархаах	Үнэлэх

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын дагуу салбаруудын статистикийг загварчлах удирдамж

1.34 Тухайлбал, аливаа статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцыг дээрх дүрслэлд харуулснаар загварчилж, өгөгдөл болон мета (өгөгдөл, мэдээллийн талаарх мэдээлэл) мэдээллийн стандартуудыг нэгтгэхэд, үйл явцын баримт бичгийн загвар болгоход, статистикийн тооцооллын дэд бүтцийг зохицуулахад, түүнчлэн үйл явц бүрийн өгөгдлийн чанарыг үнэлэх, сайжруулах хүрээг тодорхой харуулсан тул эрчим хүчний салбарын захиргааны статистикийн бүртгэл, өгөгдөл, мэдээллийн санг бий болгоход ач холбогдолтой юм.

1.35 ЭХЯ салбарын удирдлагын үйл ажиллагаанд ашиглах захиргааны статистик³⁶-ийн өгөгдлийн бүртгэл, мэдээлэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй нь эрчим хүчний бодлого төлөвлөлт, хэрэгжилт, түүнийг үнэлж, хянах үйл ажиллагаанд ашиглах мэдээлэл үнэн, бодитой байх, шуурхай байх зэрэг үйл ажиллагааны зарчим алдагдсаныг илэрхийлж байна.

Төрийн өмчит компаниудыг удирдлагаар хангах чиглэлээр Засгийн газар, Нийслэлийн удирдлагын гаргасан шийдвэрүүд салбарын компаниудад санхүүгийн нэмэлт дарамт болж, хөрөнгө үргүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлжээ

1.36 Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор төрийн өмчит компаниудыг удирдлага, менежментээр хангах үүрэг бүхий Эрчист Монгол ХХК-ийг үүсгэн байгуулсан байна.

34 эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлийн статистик мэдээллийг авах, эрчим хүчний үндэсний баланс гаргах, нормативын баримт бичгийг батлах, стандарт боловсруулах;

35 ҮСХ-ны даргын 2022 оны А/176 дугаар тушаалын 01 дүгээр хавсралтаар баталсан

36 Статистикийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт "захиргааны статистикийн мэдээлэл" гэж Үндэсний статистикийн хорооноос баталсан, зөвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэрэгцээнд зориулж цуглуулсан мэдээллийг" хэлнэ гэж тодорхойлсон.

Дүрслэл 3. Эрчист Монгол ХХК-ийн зорилго, үйл ажиллагааны чиглэл



Эх сурвалж: Эрчист Монгол ХХК-ийн дүрэм

1.37 Эрчист Монгол ХХК-ийн дүрмийн 7.4-т ...менежментийн гэрээ байгуулан ажиллах бөгөөд гэрээнд нэгдсэн стратеги төлөвлөгөө, зөвлөмжөөр хангах, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих нөхцөлийг тусгана, 7.5-д ...харьяа компаниуд "Эрчист Монгол" ХХК-д менежментийн төлбөр төлнө, төлбөрийн хувь хэмжээ компанийн борлуулалтын орлогын 1 хувь хүртэл байна гэж заажээ.

1.38 Эрчист Монгол ХХК нь Улаанбаатар хотын дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцогч төрийн өмчит 8 компанитай 2025 оны 9-12 сард 2,113.9 сая төгрөгийн Хамтран ажиллах гэрээг, мөн 2026 оны 2-3 сард 6 компани³⁷-тай 1,675.9 сая төгрөгийн Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг тус тус байгуулж, 2025 онд 1,001.4 сая, 2026 оны эхний хагаст 34.0 сая төгрөгийг менежментийн үйлчилгээний төлбөр болгон авсан байна.

1.39 Хамтран ажиллах гэрээний хүрээнд Эрчист Монгол ХХК нь төрийн өмчит компаниудын 2020-2024 оны баримт мэдээлэлд үндэслэн эрсдэлийн болон санхүүгийн шинжилгээг хийсэн ба компанийн дүрмийн 7.4-т заасан стратеги төлөвлөгөө, зөвлөмжөөр хангах үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй боловч 1,001.4 сая төгрөгийг үйлчилгээний төлбөрт авсан байна.

1.40 Менежментийн гэрээ байгуулсны дараа буюу Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Эрчист Монгол ХХК-ийг татан буулгасан ба гэрээний дагуу үйлчилгээ үзүүлээгүй байхад ДҮТ ТӨХХК нь 34.0 сая төгрөгийг Эрчист Монгол ХХК-нд шилжүүлж, бусад төрийн өмчит 5 компаниас 841.4 сая төгрөгийг 2026 оны 01 дүгээр улиралд багтаан авахаар авлагаар бүртгэжээ.

1.41 Эрчист Монгол ХХК-д менежментийн үйлчилгээний төлбөр төлсөн дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцож буй 6 компаниар төлөөлүүлэн санхүүгийн үр дүнг хүснэгтээр харуулбал, санхүүгийн сахилга бат сайжраагүй, тайлант үеийн ашигт ажиллагаа буурсан, өр төлбөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Эрчист Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулсан дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцогч компаниудын санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сая төгрөг

Төрийн өмчит компаниудын нэр	Өр төлбөр		Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		Аудитаар өгсөн дүгнэлт	
	2024	2025	2024	2025	2024	2025
ДҮТ ХХК	104,444.2	235,704.1	103.0	760.1	өөрчлөлтгүй	өөрчлөлтгүй
ДЦС-3 ТӨХК	29,848.5	34,715.2	875.8	(2,601.8)	өөрчлөлтгүй	хязгаар-лалттай
ДЦС-2 ТӨХК	1,276.4	669.6	106.1	1,202.6	өөрчлөлтгүй	хязгаар-лалттай
ДЦС-4 ТӨХК	453,454.8	468,021.8	(1,556.8)	(30,891.6)	хязгаарлалттай	хязгаарлалттай
УБДС ТӨХК	138,525.6	176,139.9	3,934.4	(1,308.9)	өөрчлөлтгүй	өөрчлөлтгүй
АДС ТӨХК	33,378.9	42,960.5	9,865.4	13,670.7	өөрчлөлтгүй	хязгаар-лалттай

³⁷ ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, АДС ТӨХК, УБДС ХХК, ДҮТ ХХК

Эх сурвалж: УАГ, аудитлагдсан санхүүгийн тайлан

1.42 Эрчист Монгол ХХК нь үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардагдаж буй зардлыг санхүүжүүлэх³⁸ агуулгаар 1,900.0 сая төгрөгийн зээлийг 16.2 хувийн хүүтэйгээр 2025 онд багтаан эргэн төлөхөөр Хаан банкнаас авсан³⁹ боловч 2025 онд зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй байна.

1.43 Эрчист Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор Хаан банк ХК болон Эрчист Монгол ХХК-ийн хооронд байгуулсан ЗШГ/25/28 дугаартай Зээлийн шугамын гэрээний хугацааг 7 сараар сунгаж, гэрээний нийт хугацааг 12 сар болгожээ.

1.44 Хаан банк ХК нь 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 2834 дугаартай албан бичгээр үндсэн зээл болох 1,897.0 сая, зээлийн хуримтлагдсан хүү 800.0 мянган төгрөгийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор төлөхийг мэдэгдсэн байна.

1.45 Эрчис Монгол ХХК-ийн өглөг 2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 2,795.7 сая төгрөг байгаагийн 67.9 хувь нь богино хугацаат зээл, 12.4 хувь нь НӨАТ, 5.1 хувь цалин хөлс, 4.3 хувь тэтгэмж, 3.6 хувь НДШ, 2.0 хувь тоног төхөөрөмж, 1.3 хувь нь түрээс байна.

1.46 Засгийн газрын 2026 оны 91 дүгээр тогтоолоор компанийг татан буулгаж компанийн өр төлбөрийг барагдуулах, эд хөрөнгийг шилжүүлэх, архив, баримт бичгийг хүлээлгэн өгөх болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг ЗГХЭГ, ТӨБЗГ-т тус тус даалгажээ.

1.47 Эрчист Монгол ХХК-ийг татан буулгах шийдвэр гарсан өдөр буюу 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар 11 ажилтанд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 52.4 сая, Татан буулгах комиссын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрээр 18 ажилтанд гурван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 278.9 сая, нийт 331.3 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ.

Хүснэгт 12. Эрчист Монгол ХХК-ийн тэтгэмж олгосон албан хаагчдын тоо, тэтгэмжийн дүн сая төгрөг

Шийдвэр гаргасан эрх бүхий субъект	Тэтгэмж авсан ажилчдын тоо	Олгосон хэмжээ	Тэтгэмжийн дүн	Олгосон тэтгэмжид эзлэх хувь
Компанийн гүйцэтгэх захирлын шийдвэрээр (2026.03.18)	11	1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээ	52.4	15.8
Татан буулгах комиссын шийдвэрээр (2026.04.30)	18	3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээ	278.9	84.2
Нийт	29	-	331.3	100.0

Эх сурвалж: ТӨБЗГ-ын мэдээлэл

1.48 Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2⁴⁰-т заасан бөөнөөр халах үеийн зохицуулалтыг үндэслэл болгон тухайн шийдвэрийг гаргах эрхгүй буюу Татан буулгах комиссын шийдвэрээр ажилтанд тэтгэмж олгосон нь хууль зөрчсөн, хүчин төгөлдөр бус шийдвэр болжээ.

1.49 Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тэмдэглэлийн 2 дахь хэсгээр Төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлага, засаглал, хяналтын тогтолцоог сайжруулах, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор засаглал, ил тод байдал, нийцлийн болон гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудитын хяналтын чиг үүрэг бүхий менежер гэх албан тушаалыг бий болгохыг үүрэг болгожээ.

1.50 Улмаар дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчийн 5 компанид 2025 оны 01 дүгээр сараас эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулж эхэлсэн боловч тухайн албан тушаалтнууд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй, ажлын үр дүнгийн тайлан гаргаагүй байна. Энэхүү томилгоо нь компанийн үйл

³⁸ Эрчист Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоол, энэ тогтоолын дагуу Хаан банк ХК болон Эрчист Монгол ХХК нарын хооронд ЗШГ/25/28 дугаартай Зээлийн шугамын гэрээг байгуулжээ.

³⁹ Эрчист Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 44 дүгээр тогтоолоор Хаан банк ХК болон Эрчист Монгол ХХК нарын хооронд ЗШГ/25/28 дугаартай Зээлийн шугамын гэрээний хугацааг 7 сараар сунгахыг зөвшөөрсөн байна. Энэхүү тогтоолын дагуу Хаан банк ХК болон Эрчист Монгол ХХК нарын хооронд ЗШГ/25/28-1 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг байгуулжээ.

⁴⁰ Ажилтныг бөөнөөр халах үед ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийн хэмжээг ажилтны төлөөлөгчидтэй хийх хэлэлцээгээр энэ хуулийн 82.1-д зааснаас доошгүй байхаар тогтооно.

ажиллагаанд бодитой дэмжлэг үзүүлэх зорилгодоо хүрээгүй бөгөөд тэдгээр менежерийн цалин хөлс, тавилга эд хогшил болон тэтгэмжид нийт 1,077.7 сая төгрөг зарцуулсан байна.

1.51 Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр хяналтын болон бүтээмжийн менежерүүдийг чөлөөлж, 2025 оны 12 дугаар сарын 17-ны 217 дугаар тогтоолоор дэд сайд нарыг томилжээ.


1.52 Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий босоо удирдлагатай “бүтээмжийн менежер” гэсэн орон тоо, албан тушаалыг нийслэлийн өмчит ААТҮГ-ын бүтцэд нэмжээ.

1.53 Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Б/121 дүгээр захирамжаар ХИХУГ ОНӨААТҮГ-ын бүтцэд бүтээмжийн менежер-ийг томилж, 6 сарын хугацааны цалинд 15.9 сая, тавилга эд хогшилд 3.0 сая, нийт 18.9 сая төгрөгийг зарцуулжээ.

1.54 Бүтээмжийн менежерийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт (KPI) тодорхойгүй, компанийн өр төлбөр, алдагдал буурахад эерэг нөлөө үзүүлээгүй нь зорилт хангагдаагүй, үйл ажиллагааны үр дүн гараагүйг илтгэж байна.

1.55 Доорх зургаас харахад Засгийн газраас ижил чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудыг бий болгосноор үйл ажиллагаа давхардаж, харьяа байгууллагуудыг удирдан чиглүүлэх үйл ажиллагааны шат дамжлага нэмэгдэж, шийдвэр гаргах явц удааширч, үйл ажиллагаанд бодит үр нөлөө үзүүлээгүй байна.

Дүрслэл 4. Салбарын төрийн өмчит компаниудын удирдлагын тогтолцооны ерөнхий Графиклал



Эх сурвалж: Аудитын баг

1.56 Тооцоо судалгаа, үндэслэлгүй гаргасан төр, захиргааны байгууллагын дээрх 3 шийдвэрээр Улаанбаатар хотын дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлэгч төрийн өмчит 15 компанид богино хугацаанд 2,121.6 сая төгрөгийн үргүй зардал, үйлчилгээ аваагүй 841.4 сая төгрөгийн тооцоолсон төлбөр, төрийн байгууллага төлөх 2,697.0 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн өрийн дарамт учруулсан байна.

Төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй төрийн жинхэнэ албан хаагчид хуульд заасан хязгаарлалтыг зөрчиж, хяналтын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна

Хүснэгт 13. Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн орон тоо

№	Компанийн нэр	ТУЗ-ийн гишүүний тоо		Хасагдсан тоо
		2026 оноос өмнө	2026 оноос хойш	
1	ДЦС-2 ТӨХК	9		
2	ДЦС-3 ТӨХК	9	9	9
3	ДЦС-4 ТӨХК	9		
4	АДС ТӨХК	9	9	9
5	Багануур Зүүн өмнөд бүсийн ЦТС ТӨХК	9		
6	БНДС ТӨХК	9	9	18
7	НДС ТӨХК	9		
8	УБДС ТӨХК	9	9	-
9	ЦДҮС ТӨХК	9	9	9
10	ДҮТ ХХК	9		
11	ЭХҮТ ТӨХХК	9	9	-

1.57 Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Эрчим хүчний төрийн өмчит компаниудын үр ашгийг дээшлүүлэх, зардлыг хэмнэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлүүдийг нэгтгэсэн байна.

Эх сурвалж: ТЗЭ-дийн ТУЗ-ийн хурлын шийдвэр

1.58 ДЦС-3, ДЦС-4, АДС, УБДС ТӨХК-иудын ТУЗ-д 2 хараат бус гишүүн, ДҮТ ТӨХХК-ийн ТУЗ нь 1 хараат бус гишүүн ажиллаж байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4⁴¹-д заасан ТУЗ-ийн гишүүний гуравны нэгээс доошгүй хувь хараат бус байх зохицуулалттай нийцэхгүй, дээрх хуулийн 75 дугаар зүйлийн 75.6⁴²-д заасны дагуу ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй байна.

1.59 Эрчим хүчний салбарын төрийн өмчит 9 компанийн ТУЗ-ийн нийт 81 гишүүний 61 буюу 75.3 хувь нь төрийн албан хаагч байна. Тэдгээрийг албан хаагчдын ажиллаж байгаа байгууллагын харьяаллыг авч үзвэл 60.7 хувь буюу 37 нь ЭХЯ-нд, 29.5 хувь буюу 18 нь ТӨБЗГ-т, 4.9 хувь буюу 3 нь ЗГХЭГ-т, үлдсэн 4.9 хувь буюу 3 нь төрийн бусад байгууллагад тус тус харьяалагдаж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

1.60 ЭХЯ-ны хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч нэгэн зэрэг Нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүнээр томилогдон ажиллаж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3⁴³-т заасан төлөөлөл хэрэгжүүлэхтэй холбоотой хориглосон хязгаарлалтыг зөрчсөн байна.

1.61 Нийслэлийн зохицуулах зөвлөл болон Төрийн өмчит компаниудын ТУЗ-д төрийн албан хаагчид төлөөлөл хэрэгжүүлж байгаа нь зөвхөн хувь хүний ажлын ачааллын асуудал бус, төрийн албаны үндсэн албан үүргийн гүйцэтгэл суларч, бүтээмж буурах, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг нэгдэн холилдох, улмаар хяналтын тогтолцооны үр нөлөө алдагдах зэрэг тогтолцооны түвшинд сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй байна.

1.62 Төрийн болон орон нутгийн өмчит 6 компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 40 хүн байгаагаас 75.0 хувийг (30 хүн) НИТХ-ын төлөөлөгч болон НЗДТГ-ын удирдах албан тушаалтан, 10.0 хувийг (4 хүн) ЭХЯ, БОУАӨЯ-ны удирдах албан тушаалтнууд, үлдсэн 15.0 хувийг (6 хүн) бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн байна.

Хүснэгт 14. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын төлөөллийн бүтцийн мэдээлэл

№	Байгууллагын нэр	Төлөөллийн бүтцийн мэдээлэл				Нийт
		НИТХ-ын төлөөлөгч	НЗДТГ-ын харьяа газар, хэлтсийн дарга	Яамны газар, хэлтсийн дарга	Бусад төлөөлөл	
1	ДЦС-5 ТӨХК	3	2	2	-	9
2	ОСНААУГ ОНӨААТҮГ	4	1	-	2	7
3	ХИХУГ ОНӨААТҮГ	4	1	-	-	5
4	Түлшний хяналтын газар ОНӨААТҮГ	3	2	-	-	5
5	Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ	3	2	-	-	5
6	Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК	3	-	2	4	9
ТУЗ-ийн бүрэлдэхүүний нийт тоо		20	10	4	6	40
Төлөөллийн харьцаа /нийтээс/, хувь		50.0	25.0	10.0	15.0	100

Эх сурвалж: Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ийн мэдээлэл

1.63 Дээрх хүснэгтээс үзэхэд уг 6 компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний 75.0 хувийг НИТХ-ын төлөөлөгч болон НЗДТГ-ын удирдах албан тушаалтнууд эзэлж байгаа нь компанийн засаглалд орон нутгийн оролцоо өндөр байгааг илтгэж байна.

⁴¹ Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

⁴² Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно.

⁴³ албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө

1.64 Харин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан ИТХ-ын төлөөлөгчийн эрх, үүрэгт Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх зохицуулалтгүй байна.

1.65 НИТХ-ын тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг шууд томилж байгаа нь НИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан *Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам*-ын 2.1⁴⁴-т заасныг, зарим орон нутгийн өмчит компаниудад таваас дээш гишүүнийг томилж байгаа нь журмын 2.2⁴⁵-т заасныг зөрчиж, энэхүү зохицуулалт нь дээрх хуулиас давсан шийдвэр болсон байна.


Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн зохицуулах зөвлөлийн хуулийн этгээдийн хэлбэр үйл ажиллагаатайгаа нийцэхгүй байна

1.66 ЭХЗХ (РД:9128808), Нийслэлийн зохицуулах зөвлөл (РД:6033334) нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5⁴⁶-д заасныг зөрчиж хороо, зөвлөлийг “Төрийн байгууллага, албан газар” хэлбэрээр бүртгүүлсэн байна.

1.67 ЭХЗХ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд төрийн байгууллага, албан газар хэлбэрээр бүртгэгдсэн хэдий ч үйл ажиллагааны зохион байгуулалтын хувьд төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хэлбэрт нийцсэн үйл ажиллагаа явуулж байна. Нэг байгууллагад хариуцлагын хоёр өөр хэлбэрийг зэрэгцүүлсэн зохицуулалт нь салбарын бодлого боловсруулах, тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг өөр өөр шинж чанартай чиг үүргүүдийг давхардуулан хэрэгжүүлэхэд хүргэж, зохицуулалтын тогтолцооны цаашдын үр нөлөөг бууруулж байна.

1.68 ЭХЗХ нь Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6⁴⁷-т заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжиж байна.

График 4. ЭХЗХ-ны зохицуулах үйлчилгээний орлого, сая төгрөг



Эх сурвалж: ЭХЗХ

1.69 ЭХЗХ-ны ТЗЭ-дээс авч буй зохицуулалтын үйлчилгээний хөлс⁴⁸ 2025 онд 8,884.8 сая төгрөгт хүрч, 2020 онтой харьцуулахад 2.0 дахин нэмэгдсэн ба цаашид нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал, 2022 онд 16.4 хувь, 2023 онд 11.9 хувь өссөн бол 2024 онд 69.8 хувиар тус тус нэмэгджээ.

1.70 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам⁴⁹-ын 7.3-т заасны дагуу ТӨБЗГ-ын 2023 оны 174 дүгээр тогтоолоор төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлалыг баталсан байна.

⁴⁴Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн Удирдах зөвлөлд ажиллах гишүүний НЗД-ын саналыг үндэслэн НИТХ-н тэргүүлэгчдийн шийдвэрээр томилж чөлөөлнө.

⁴⁵Удирдах зөвлөлийн гишүүн нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч болон төрийн албан хаагч байж болно. Удирдах зөвлөл нь 5-аас илүүгүй гишүүнтэй байна.

⁴⁶Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, **хороо**, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй.

⁴⁷Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжинэ.

⁴⁸ЭХЗХ-ны 2019 оны 494 дүгээр тогтоолоор “Эрчим хүчний үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ыг баталсан.

⁴⁹Засгийн газрын 2023 оны Журам шинэчлэн батлах тухай 84 дүгээр тогтоолоор баталсан

1.71 Аргачлал батлагдсантай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг шинэчлэн батлахыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нарт, мөрдөж ажиллахыг төрийн өмчит компанийн ТУЗ-д үүрэг болгожээ. Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниуд ТУЗ-ийн гишүүдэд 2023-2025 онд жилд дунджаар 1,057.3 сая төгрөгийн цалинг хуралд суусан эсэх, оролцоогоо хангасан эсэхээс үл хамааран олгосон байна.

Хүснэгт 15. Улаанбаатар хотын дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцогч төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингийн мэдээлэл, сая төгрөг

№	Байгууллагын нэр	2023		2024		2025	
		ТУЗ-ийн гишүүний тоо	Олгосон цалин	ТУЗ-ийн гишүүний тоо	Олгосон цалин	ТУЗ-ийн гишүүний тоо	Олгосон цалин
1	ДЦС-2 ТӨХК	10	78.8	10	107.0	10	115.2
2	ДЦС-3 ТӨХК	11	104.0	14	125.0	9	125.4
2	ДЦС-4 ТӨХК	10	100.5	10	123.1	10	121.0
3	АДС ТӨХК	9	94.6	11	117.0	11	127.2
4	НДС ТӨХК	13	73.7	16	128.7	10	127.7
5	БНДС ТӨХК	10	73.7	14	112.6	9	120.0
6	УБДС ТӨХК	17	98.0	11	139.3	12	149.0
7	ДҮТ ТӨХХК	12	110.5	14	136.6	11	145.2
8	ЭХҮТ ТӨХХК	13	109.1	11	133.0	10	176.1
Нийт		105	842.9	111	1,122.3	92	1,206.8

Эх сурвалж: ТӨХК-уудын ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингийн мэдээлэл

Эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл олгох хууль тогтоомжийн хийдэл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 2023-2025 оны байдлаар 4,460.3 сая төгрөгийн санхүүгийн дарамт үзүүлжээ

1.72 ЭХЯ нь Эрчим хүчний тухай хуулиар тусгай зөвшөөрөл олгох үүрэг хүлээгээгүй, харин Зөвшөөрлийн тухай хуулиар эрчим хүчний чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох үүрэг хүлээж байгаа нь хууль хоорондын нийцэлгүй байдлыг харуулж байна. Тус яам нь дээрх хуулиар тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбоотой маргааныг хянаж, дүгнэлт гаргах үүргийг хүлээсэн боловч энэ үүргээ хэрэгжүүлээгүй байна.

1.73 Салбарын сайдын 2023 оны А/55 дугаар тушаалаар Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг олгох эрхээ ЭХҮТ ТӨХХК-д шилжүүлсэн байна.

1.74 ЭХҮТ ТӨХХК-ийн мэдээллээр 2023-2025 оны байдлаар нийт 1,862 тусгай зөвшөөрөл бүртгэлтэйгээс шинээр олгосон 992, сунгалт хийсэн 641, төрөл нэмсэн 229 байна. Үүний 940 буюу 50.5 хувь нь цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын тусгай зөвшөөрөл байна.

Хүснэгт 16. ЭХҮТ ТӨХХК-аас 2023-2025 онд олгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тоо


№	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл			Нийт	Дүнд эзлэх хувь
		Шинээр авсан	Сунгасан	Төрөл нэмсэн		
1	Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	70	50	50	170	9.1
2	Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	552	281	107	940	50.5
3	Даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	83	83	22	188	10.1
4	Даралттай даралтат савны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	60	60	8	128	6.9
5	Даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	108	97	31	236	12.7

6	Даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	23	39	8	70	3.8
7	Эрчим хүчний барилга байгууламжийн График төсөл боловсруулах	96	31	3	130	7.0
Нийт		992	641	229	1862	100

Эх сурвалж: ЭХҮТ ТӨХХК-ийн мэдээлэл

1.75 Эрчим хүчний тухай хуулиар нийслэлийн зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан зардлыг үйл ажиллагааны хөлс болгон авахаар зохицуулсан бол Зөвшөөрлийн тухай хуулиар ЭХЯ-ны тусгай зөвшөөрөл олгох үүргийг хэрэгжүүлж байгаа ЭХҮТ ТӨХХК-д тусгай зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлж хөлс авах зохицуулалтгүй байхад ЭХҮТ ТӨХХК 2023-2025 онд 4,460.3 сая төгрөгийн хөлс авсан нь эрх зүйн үндэслэлгүй байна.

График 5. ЭХҮТ ТӨХХК-ийн олгосон тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн үйлчилгээний хөлсний мэдээлэл, сая төгрөг



Эх сурвалж: ЭХҮТ ТӨХХК

1.76 ЭХЗХ нь тусгай зөвшөөрлийн хугацааг ялгаатай сунгаж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг таван жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно гэж заасныг зөрчиж байна.

1.77 Нийслэлийн зохицуулах зөвлөл 2008-2025 оны байдлаар хэсэгчилсэн дулаан хангамжийн 0.12-12.9 Гкал/цаг дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай болон зохицуулалтгүй хангах үйл ажиллагааг эрхлэх 22 (давхардсан тоогоор) тусгай зөвшөөрлийг олгожээ.

1.78 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд дулаан дамжуулах⁵⁰ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна. УБДС ТӨХК нь дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй хэдий ч дулаан дамжуулах сүлжээний ашиглалт, горим тохируулга, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг.

1.79 Энэ нь дулаан дамжуулах үйл ажиллагааны эрх үүрэг, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэл, үнэ тариф, алдагдал зэрэг найдвартай ажиллагааны хариуцлагыг дулаан түгээх, хангах үйл ажиллагаанаас тусад нь төлөвлөх, үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд дулаан дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, өмчлөл, үнэ тариф, хариуцлагын ялгаатай байдлыг хууль тогтоомжийн хүрээнд тодорхой болгох шаардлагатай байна.

Дулаан хангамжийн бодлогын хэрэгжилтэд тавих хяналтыг төлөвлөх, зөрчил арилгах үйл ажиллагаа үр дүнгүй байна

1.80 ЭХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 3.3.6⁵¹ болон 3.3.5⁵²-д хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал

⁵⁰ Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйл

⁵¹ Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан

⁵² Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолоор баталсан

хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийг дараах дүрслэлд харуулснаар тусгажээ.

Дүрслэл 5. ЭХЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг
ЗАСГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ 94 ДҮГЭЭР
ТОГТООЛ

Хөгжлийн бодлого, хөтөлбөр


3.3.6 Салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх

Хууль тогтоомж

3.3.6. Хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт, дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

3.3.6.... төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;



ЗАСГИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ 07 ДУГААР
ТОГТООЛ

Хөгжлийн бодлого, хөтөлбөр

3.5.5.МУ-ын хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хууль тогтоомж

3.5.5.Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт

ЭХЯ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.5.5.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

3.5.5.Төсөл арга хэмжээ, тусламжийн хөрөнгийн үр ашигтай байдалд хяналт тавих

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны 94, 2025 оны 7 дугаар тогтоолын хавсралт

1.81 ЭХЯ нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ **Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам**⁵³-ыг удирдлага болгожээ.

1.82 Салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн 2024 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тэдгээрийн гүйцэтгэл 59-92 хувьтай байна.

Хүснэгт 17. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, 2024 оны байдлаар

№	Төслийн нэр	Санхүүжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа	Гүйцэтгэлийн хувь			
				2022	2023	2024	2025
1	Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл	ЕСБХБ	2020-2024	42.0	61.0	87.0	87.0
2	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	АХБ	2019-2027	85.0	81.0	65.0	68.0
3	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл	Дэлхийн банк	2021-2025	84.0	92.0	92.0	96.0
4	Эрчим хүчний системд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл	АХБ	2020-2025	0	90.0	91.0	93.0
5	Эрчим хүчний төсөл-2	Дэлхийн банк	2017-2023	0	92.0	90.0	0

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

1.83 Мөн ЭХЯ нь хууль тогтоомжийн биелэлт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох зөвлөмж өгсөн ч түүний хэрэгжилтийг хангуулах замаар зөрчил арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 18. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийн тоо

Агуулга	2021	2022	2023	2024	2025	Нийт
Хууль тогтоомжийн биелэлт	2	3	3	5	4	17
Төсөл, арга хэмжээний биелэлт	1	2	2	3	-	8
ЭХЯ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөө	4	6	4	6	4	24

⁵³Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталж, 2025 оны 43 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

Дулаан хангамжийн системийн хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл олголт, нөхцөл, шаардлагын нийцэл, норм, стандартын хэрэгжилтэд хийсэн хяналтаар илэрсэн зөрчил, түүнийг арилгах үйл явц үр дүнгүй байна

1.84 Засгийн газрын 2020 оны “ЭХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 94 дүгээр тогтоолд Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, ЭХЯ-ны зохион байгуулалтын бүтцэд Салбарын хяналтын асуудал хариуцсан нэгжийг бий болгосон.

1.85 Тус нэгж нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хяналт, шалгалтыг 2024-2025 онд хийж, хууль тогтоомжийн мөрдөлт, тоног төхөөрөмжийн хэвийн байдал, бүртгэл, гэрчилгээжүүлэлттэй холбоотой зөрчлүүдийг илрүүлжээ.

Хүснэгт 19. ЭХЯ-ны Салбарын хяналт хариуцсан нэгжийн хяналт, шалгалтын мэдээлэл

№	Үзүүлэлт	Илэрсэн зөрчил	
		2024	2025
1	Төлөвлөгөөт	Холбогдох норм, дүрэмгүй, холбогдох заалтыг мөрдөөгүй	Техникийн тодорхойлолтод заасан нэр төрлийг зөрүүлэн худалдах, худалдан авсан
		Тоног төхөөрөмжийн хэвийн байдал	-
		Тоног төхөөрөмжийн гэрчилгээжүүлэлт, бүртгэл	
2	Төлөвлөгөөт бус	Шугам хоолойн алдагдал, эвдрэл болон хамгаалалтын зурвасыг зөрчил	
		Холбогдох дүрэм журмыг зөрчсөн	
		График төсөл, материалын чанарыг зөрчсөн	

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

1.86 ЭХЯ-ны Салбарын хяналт хариуцсан нэгж хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах чиглэлд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁴ дугаар зүйлийн 5^{4.1}-д Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна, 5^{4.2}-т Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ” гэж заасныг хэрэгжүүлэх тодорхой төлөвлөлтгүй байгаа нь холбогдох зөрчил, дутагдлуудыг бууруулах арга хэмжээ үр дүнгүй болох эрсдэлтэй юм.

1.87 Нийслэлийн хяналт, шалгалтын газар нь Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 7 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 100кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуухны техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд хяналт, шалгалт хийж, дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Барилгын зориулалт, аюулгүй байдал, хэрэглээнд нь тохируулан цахилгааны чадлыг зөв тооцоолж, ачааллыг хэтрүүлэхгүй байх;
- Өсөн нэмэгдэж буй хэрэглээ, нэмэлт төхөөрөмжид зориулж цахилгааны чадлын нөөцийг урьдчилан төлөвлөх;
- Ухаалаг системээр цахилгаан хангамжийг удирдаж, хэрэглээг хянан, эрчим хүч хэмнэх;
- Цахилгаан шугам, самбар, төхөөрөмжийг аюулгүй байдлын стандартын дагуу суурилуулалт;
- Барилгын цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг бүрэн судалж адна шугам сүлжээний График төслийг иж бүрэн батлуулан угсралтын ажлыг хийх;
- Барилгын дулаан алдагдлыг бууруулах зорилгоор шилэн хана, дулаан тусгаарлагч чанартай материал сонгох;
- Дулаан хангамжийг төвлөрсөн болон хуваарилах системээр зохион байгуулах, шаардлагатай өрөөнүүдэд дулаан хуваарилах, ухаалаг удирдлагын систем ашиглах;
- Байнгын үзлэг, хяналт хийж, эрчим хүчний хангамжийн тогтвортой байдал ажиллагаа, аюулгүй байдалд шаардлагатай арга хэмжээ авах;
- Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн материалыг чанар сайн, гарал үүслийн гэрчилгээтэй материал сонгож угсралтын ажил гүйцэтгэх;
- Аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах, гадна шугамын дараах нөхөн сэргээлтийг чанартай хийх зэрэг илэрсэн зөрчлийг хугацаанд нь арилгуулах нэгдсэн зөвлөмж хүргүүлэх;

- Нийслэлийн харьяа байгууллагууд болох Улаанбаатар орон сууцжуулалт ХХК, Нийслэлийн Орон сууцны бодлогын газруудад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн дулаан, цахилгаан хангамжийн угсралтын ажлыг шинээр хийхдээ эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан График төслийн дагуу угсралтын ажлыг эхлүүлэн хийх, цаашид холбогдох норм, дүрэмд нийцүүлэн ажиллах талаар албан бичиг хүргүүлэх.

1.88 Нийслэлийн хяналт, шалгалтын газар нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁴ дугаар зүйлийн 5^{4.1}⁵⁴, 5^{4.2}⁵⁵ дах заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.89 Салбарын хэмжээнд дулаан хангамжийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах үйл ажиллагааны үр дүн хангалтгүй, хууль дээдлэх, хэрэгжүүлэх зарчим алдагдсан, хариуцлагын тогтолцоо үйлчлэхгүй байгаа нь салбарыг үе шаттайгаар тууштай хөгжүүлэх бодлогыг хэмнэлттэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх, нийслэлийн иргэдийг тогтвортой, найдвартай дулаанаар хангах боломжийг урт хугацаанд алдагдуулсан байна.

⁵⁴ Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна.

⁵⁵ Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ.


БҮЛЭГ 2. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН ҮЙЛДВЭРЛЭХ, ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ ОРГИЛДОО ХҮРЧ ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН БАЙНА

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн талаар ерөнхий мэдээлэл

2.1 Салбарын сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар баталсан Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэмд ДЭХ-ийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх технологийн үйл ажиллагааны нэгдсэн горимыг боловсруулж, хэрэгжүүлэх, төвлөрсөн дулаан хангамжийн бүрэлдэхүүн хэсгүүдийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан байна.

2.2 ДЦС-2, 3, 4 болон АДС ТӨХК-иудын үйлдвэрлэсэн дулааныг УБДС ТӨХК-ийн дамжуулах сүлжээгээр, ДҮТ ТӨХХК зохицуулалт хийж, ОСНААУГ ОНӨААТҮГ, түүний харьяа түгээх 3, хэрэглэгчдэд үйлчлэх 19 төв, хувийн өмчийн 57 компани Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэрэглэгчдийг дулаанаар ханган ажиллаж байна.

Дүрслэл 6. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн үйл явцын Графиклал



Эх сурвалж: ЭХЗХ

2.3 Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүд 2025 онд 9,066.1 мянган.Гкал дулаан үйлдвэрлэсэн нь өмнөх 5 жилийн дунджаас 936.5 мянган.Гкал буюу 11.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 20. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн 2020-2025 онд үйлдвэрлэсэн дулаан, мянган.Гкал

ТЗЭ-дийн нэр	Хамарсан хугацаа					Өмнөх 5 жилийн дундаж	2025	Өөрчлөлт (нэмэгдсэн +, хасагдсан -)	
	2020	2021	2022	2023	2024			Тоо	Хувь
Үйлдвэрлэсэн дулааны эрчим хүч									
ДЦС-2 ТӨХК	245.0	246.9	251.1	276.2	272.0	258.2	255.4	(2.8)	(1.1)
ДЦС-3 ТӨХК	2,406.2	2,503.5	2,642.1	2,564.6	2,695.1	2,562.3	2,701.4	139.1	5.4
ДЦС-4 ТӨХК	4,029.5	4,172.1	4,551.4	4,636.9	4,733.8	4,424.7	5,008.9	584.2	13.2
АДС ТӨХК	761.9	739.5	841.8	1,037.0	1,041.1	884.3	1,100.3	216.0	24.4
Нийт үйлдвэрлэсэн	7,442.6	7,662.0	8,286.4	8,514.7	8,742.0	8,129.5	9,066.0	936.5	11.5
Дамжуулсан дулааны эрчим хүч									
ДЦС-2 ТӨХК	181.1	176.8	180.6	193.3	194.9	185.3	205.2	19.9	10.7
ДЦС-3 ТӨХК	2,109.3	2,184.0	2,343.6	2,285.5	2,343.1	2,253.1	2,421.0	167.9	7.5
ДЦС-4 ТӨХК	3,662.9	3,772.8	4,124.2	4,186.3	4,292.2	4,007.7	4,571.9	564.2	14.1
АДС ТӨХК	748.0	725.4	826.9	1,023.2	1,025.9	869.9	1,081.7	211.8	24.4
Нийт дамжуулсан	6,701.3	6,859.0	7,475.3	7,688.3	7,856.1	7,316.0	8,279.8	963.8	13.2
Үйлдвэрлэсэн, дамжуулсан зөрүү	Биет	(741.3)	(803.0)	(811.1)	(826.4)	(885.9)	(813.5)	(786.2)	
	Хувь	(10.0)	(10.5)	(9.8)	(9.7)	(10.1)	(10.0)	(8.7)	
Түгээсэн дулааны эрчим хүч									
ОСНААУГ	2,044.0	2,031.1	2,126.8	2,228.2	2,369.0	2,159.8	2,487.3	327.5	15.2
ХОСК	1,868.3	2,013.6	2,228.1	2,450.2	2,461.9	2,204.4	2,597.3	392.9	17.8
Гэрээт хэрэглэгч	1,469.8	1,573.9	1,738.5	1,619.9	1,648.3	1,610.1	1,738.7	128.6	8.0
Нийт түгээсэн	5,382.1	5,618.6	6,093.4	6,298.3	6,479.2	5,974.3	6,823.3	849.0	14.2
Дулаан дамжуулах сүлжээний алдагдал	Биет	(1,319.2)	(1,240.4)	(1,381.9)	(1,390.0)	(1,376.9)	(1,341.7)	(1,456.5)	
	Хувь	(19.7)	(18.1)	(18.5)	(18.1)	(17.5)	(18.4)	(17.6)	

Эх сурвалж: ЭХЗХ, статистикийн эмхэтгэл

2.4 Дулааны эх үүсвэрүүдийн өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан болон аж ахуйн нэгжүүдэд борлуулсан дулааны эрчим хүч 2025 онд нийт үйлдвэрлэлийн 8.7 хувийг эзэлж, өмнөх таван жилийн дунджаас 1.3 нэгж хувиар буурсан бол дулаан дамжуулалтын алдагдал 17.6 хувь болж 0.8 нэгж хувиар буурсан байна.

2.5 Нийслэлийн статистикийн газрын тайлангаар 2025 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод 284.7 мянган өрх төвлөрсөн инженерийн байгууламжтай орон сууцанд амьдардаг бол төвлөрсөн дулаан хангамжийн гэрээг ОСНААУГ ОНӨААТҮГ-тай байгуулсан 155.0 мянга, ХОСК-тай байгуулсан 184.2 мянга, УБДС ТӨХК-тай байгуулсан 0.8 мянга, нийт 340.0 мянган айл өрх төвийн 6 дүүрэгт амьдарч байгаа нь статистик мэдээ 55.3 мянган өрхөөр дутуу илэрхийлэгдсэнийг харуулж байна.

Хүснэгт 21. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хэрэглэгч, хангагчийн мэдээлэл, 2025 оны жилийн эцсийн байдлаар

№	ТЭЗ-дийн нэр	Байр-ны тоо	Хэрэглэгчдийн тоо		Дулааны тооцоот ачаалал, Гкал/цаг			Дамжуулах сүлжээ, км	НС, УДДТ-ийн тоо	Түгээх сүлжээ, км
			Айл өрх	Үйлдвэр, ААНБ	Халаалт	Хэрэглээ-ний халуун ус	Нийт дүн			
1	ОСНААУГ	2,449	12,406	12,406.0	975.6	265.5	1.4	1,242.5	61.8	743.0
2	ХОСК-иуд	3,570	6,101	6,101.0	965.6	295.8	12.7	1,274.0	273.8	877.0
3	УБДС ТӨХК	5,310	4,279	4,279.0	859.0	179.2	55.1	1,093.2	376.0	12.0
Нийт		11,329	340,034	22,786	22,786.0	2,800.2	740.4	69.1	3,609.7	711.6

Эх сурвалж: УБДС ТӨХК

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийг түүхий эдээр хангаж буй Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхгүйгээр шинээр эх үүсвэр нэмсэн ч түүхий эдээр хангах боломжгүй байна

Багануурын нүүрсний уурхайн талаар:

2.6 Роял майнинг ХХК болон Багануур ХК-ийн инженер техникийн багийн 2024 онд батлуулсан Багануурын хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах дунд хугацааны ТЭЗҮ-ийн тодотголоор тус орд баттай (А) зэрэглэлийн 325,693.6 мянга, бодитой (В) зэрэглэлийн 431,054.6 мянга, боломжтой (С) зэрэглэлийн 55,312.4 мянга, нийт **812,060.1** мянган тонн геологийн нөөцтэй байна.

2.7 Тодотголоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар баттай (А) зэрэглэлийн 300,022.51, бодитой (В) зэрэглэлийн 422,665.72, боломжтой (С) зэрэглэлийн 55,312.36, нийт **778,000.6** мянган тонн нүүрсний нөөцөөр тооцож дунд хугацааны төлөвлөлтийг хийсэн байна.

2.8 Багануурын нүүрсний уурхай 2020 онд 4,050.5 мянган тонн нүүрс борлуулсан бол 2025 онд 4,844.8 мянган тонн болж 794.3 мянган тонн буюу 19.6 хувиар, харин Улаанбаатар хотын төвлөрсөн хангамжид 2020 онд 3,559.1 мянган тонн нүүрс нийлүүлсэн бол 2025 онд 4,211.0, мянган тонн болж, нийлүүлэлт 651.9 тонн буюу 18.3 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 22. Багануур ХК-ийн 2020-2025 онд борлуулсан нүүрс, мянган тонноор

№	Хэрэглэгчийн нэр	2020	2021	2022	2023	2024	2025
1	ДЦС-4 ТӨХК	1,903.6	2,088.8	2,127.0	2,240.6	2,388.3	2,433.6
2	ДЦС-3 ТӨХК	1,318.9	1,436.9	1,413.8	1,496.9	1,581.8	1,390.2
3	ДЦС-2 ТӨХК	217.0	250.4	243.2	261.5	281.9	258.3
4	АДС ТӨХК	119.6	44.2	30.8		45.3	128.9
Төвлөрсөн хангамжид нийлүүлсэн дүн		3,559.1	3,820.3	3,814.8	3,999.0	4,297.3	4,211.0
5	ДДЦС ТӨХК	122.3	127.3	145.0	164.6	152.9	188.8
6	НДС ТӨХК	33.0	31.6	31.8	29.3	37.2	34.1
7	БНДС ТӨХК	66.7	62.2	75.0	72.5	67.6	68.6
8	Вагоноор бусад	67.6	104.5	146.5	139.0	120.6	118.6
9	Автомашин	201.8	201.8	205.0	223.6	240.4	223.7
Нийт дүн		4,050.5	4,347.7	4,418.1	4,628.0	4,916.0	4,844.8

Эх сурвалж: Багануур ХК

2.9 Уурхайн дунд хугацааны ТЭЗҮ-ийн тодотголд 2028 оноос жилд 8.5 сая тонн нүүрс олборлохоор тусгасан ч шинэ хэрэглэгч ДЦС-5, Налайх дүүрэгт баригдах дулааны

станцад шаардлагатай нүүрсний хэрэгцээг тооцож, төлөвлөгөөнд оруулаагүйгээс харахад шинэ эх үүсвэрүүд хаанаас түлшээр хангагдах нь тодорхойгүй байна.

Хүснэгт 23. Нүүрс нийлүүлэлтийн дунд хугацааны төлөвлөгөө, мянган тонноор

№	Хэрэглэгчийн нэр	2024	2025	2026	2027	2028	Нийт
Үүнээс: Үндсэн хэрэглэгчид							
1	ДЦС-4 ТӨХК	2,285.0	2,300.0	2,300.0	2,300.0	2,300.0	11,485.0
2	ДЦС-3 ТӨХК	1,532.0	1,550.0	1,550.0	1,550.0	1,875.2	8,057.2
3	ДЦС-2 ТӨХК	266.0	266.0	266.0	266.0	266.0	1,330.0
4	ДДЦС ТӨХК	162.0	160.0	160.0	160.0	180.0	822.0
5	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	50.0	50.0	50.0	50.0	50.0	250.0
6	АДС ТӨХК	76.1	79.5	79.0	79.0	79.0	392.6
7	БНДС ТӨХК	74.0	78.1	70.0	70.0	70.0	362.1
8	НДС ТӨХК	31.2	31.4	40.0	40.0	42.0	184.6
9	Орон нутгийн станц	55.8	67.0	110.0	110.0	110.0	452.8
10	Бусад хэрэглэгчид	212.0	212.0	260.0	260.0	260.0	1,204.0
Үндсэн хэрэглэгчийн дүн		4,744.1	4,794.0	4,885.0	4,885.0	5,232.2	24,540.3
Шинэ хэрэглэгчид							
11	БНДС ТӨХК				950.0	1,900.0	2,850.0
12	Нүүрс химийн үйлдвэр		600.0	1,200.0	1,200.0	1,200.0	4,200.0
Шинэ хэрэглэгчдийн дүн			600.0	1,200.0	2,150.0	3,100.0	7,050.0
НИЙТ ДҮН		4,744.1	5,394.0	6,085.0	7,035.0	8,332.2	31,590.3

Эх сурвалж: Багануур ХК

2.10 Багануурын нүүрсний уурхай нь 1978 онд байгуулагдаж, төвийн бүсийн нүүрсний хэрэглээг 48 дахь жилдээ ханган үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар 4.0-4.9 сая тонн нүүрсийг олборлон 20.0-22.0 сая шоо метр хөрс хуулалтын ажил хийж байна. Уурхайн санхүүгийн бүртгэлд уулын 30 техник бүртгэлтэй байгаагаас 13 нь хэвийн, 6 нь зогсоох шаардлагатай, 11 нь ашиглах боломжгүй болсон байна. Харин технологийн 85 машин механизмаас 56 нь хэвийн, 27 нь ашиглах боломжгүй, 2 нь сэлбэггүй зогссон байдалтай байна. Тухайлбал,

- Ухаж ачих зориулалттай 2010 онд авсан экскаватор 1 ширхэг, ОХУ-д үйлдвэрлэсэн ЭКГ 10 болон 4-5 метр.куб хутгуурын багтаамжтай бага оврын гидравлик экскаватор, 2021 онд авсан Komatsu PC-1250 экскаваторыг эс тооцвол ихэнх техник 30-аас дээш жилийн ашиглалттай, үйл ажиллагааны шаардлага хангахгүй, хэт хуучирсан, эвдрэл, сул зогсолт ихтэй;
- Алхагч экскаватор нь ЗХУ-д (тухайн үеийн нэршлээр) үйлдвэрлэсэн, үйлдвэрлэгчээс 20 жил ашиглах нормтой ч дунджаар 37 жил буюу 17 жилээр илүү, Хөрсний экскаваторууд ЗХУ-д (тухайн үеийн нэршлээр) үйлдвэрлэсэн, үйлдвэрлэгчээс 15 жил ашиглах нормтой ч дунджаар 28 жил буюу 13 жилээр илүү, нүүрсний 2 экскаватор ЗХУ-д (тухайн үеийн нэршлээр) үйлдвэрлэсэн, үйлдвэрлэгчээс 15 жил ашиглах нормтой ч дунджаар 34 жил буюу 19 жилээр илүү, өрмийн машинууд 15 жил ашиглахаас 33 жил буюу 18 жил илүү ашигласан;
- Хөрс тээврийн 90-100 тонны даацтай 24 автосамосвалын ашиглалтын хугацаа дууссан, дунджаар 40,827 мото цаг ажилласан, харин нүүрсний 60 тонны 9 автосамосвалуудын дундаж ашиглалт 5 жил буюу 3 жил дутуу, дунджаар 21,174 мото цаг ажилласан;
- Нүүрс олборлолт хөрс ялгалтад ажилладаг гидроэкскаваторууд дунджаар 28,708 мото цаг буюу 8 жил ашигласан, үүнээс солих хугацаа нь болсон экскаватор 2, дугуйт ачигчид болон зам засварын зам усалгааны машинуудын ашиглалтын хугацаа нормоос 4-12 жилээр хэтэрсэн.

2.11 Компани нь дээрх техник тоног төхөөрөмжүүдийг өөрийн санхүүгийн боломждоо тулгуурлан шинэчлэх бодлого барьж байгаа ч төрөөс нүүрсний үнийг тогтоож улмаар компани зах зээлийн зарчмаар ажиллах боломжгүй, мөнгөн хөрөнгийн дутагдалд орж, нормативт хугацаанд нь солих эд ангийг сольж чадахгүйд хүрч, энэ нь ТЭЗҮ-д заасан хэмжээгээр нүүрс олборлолтыг хийж чадахгүйд хүргэж, төвийн эрчим хүчний хангамжид нөлөөлөх эрсдэлтэй байна.

Хүснэгт 24. Багануур ХК-ийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024	2025
1	Нүүрс олборлолт	мянган тонн	4,050.1	4,341.6	4,404.5	4,648.4	4,957.4	4,830.7
2	Нүүрс борлуулалт	мянган тонн	4,050.5	4,347.7	4,418.1	4,628.1	4,916.1	4,844.8
3	Нийт орлого	тэрбум төгрөг	143.1	153.8	162.8	212.6	242.4	268.2
4	Нийт зардал	тэрбум төгрөг	144.5	151.0	196.4	222.2	240.2	265.5
5	Татварын өмнөх ашиг/ алдагдал	тэрбум төгрөг	(1.4)	2.9	(33.7)	(9.6)	2.5	2.8
6	ААНОАТ-ын зардал	тэрбум төгрөг	0.002	1.4	0.0	-	0.6	0.8
7	Татварын дараах ашиг/ алдагдал	тэрбум төгрөг	(1.4)	1.5	(33.7)	(9.6)	1.7	1.9

8	1 тонн нүүрсний өртөг	төгрөг	35,678.9	34,768.2	44,601.4	47,792.2	48,462.4	54,958.0
9	Ажиллагсдын тоо	хүн	1,128	1,139.0	1,123.0	1,123.0	1,118.0	1,122.0
10	Сарын дундаж хөлс	мянган төгрөг	2,927.4	2,848.6	3,238.1	3,922.2	4,578.1	5,352.4
11	Борлуулалт 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.99	1.02	0.83	0.96	1.01	1.01

Эх сурвалж: Багануур ХК

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн талаар:

2.12 ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн болон Шивээ-Овоо ХК-ийн инженер техникийн ажилтнуудын хамтран боловсруулж, 2019 онд батлуулсан *Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг ашиглах ил уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-тодотголд* MV-013311, MV-013312, MV-000901 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордын нөөцийг 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн АМГ-ын даргын н/59, н/60, н/61 тушаалаар цэвэр нүүрсний нийт нөөц нь 617,871.1 мянган тонн, Монгол Улсын эрдэс баялгийн санд бүртгүүлсэн ордын баттай (А) зэрэглэлийн 27,010.0, бодитой (В) зэрэглэлийн 272,578.1, боломжтой (С) зэрэглэлийн 318,283.0, нийт 617,871.1 мянган тонн геологийн нөөцөд үндэслэжээ.

2.13 Шивээ-Овоогийн уурхай нь 2020 онд 1,988.6 мянган тонн нүүрс борлуулсан бол 2025 онд 2,428.7 мянган тонн болж 440.1 мянган тонн буюу 22.1 хувиар, харин Улаанбаатар хотын төвлөрсөн хангамжид 2020 онд 1,773.1 мянган тонн нүүрс нийлүүлсэн бол 2025 онд 2,176.4, мянган тонн болж 403.3 тонн буюу 22.7 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт 25. Шивээ-Овоо ХК-ийн 2020-2025 онд борлуулсан нүүрс, мянган тонноор

№	Хэрэглэгч байгууллага	2020	2021	2022	2023	2024	2025
1	ДЦС-4 ТӨХК	1,670.7	1,799.1	1,861.4	1,956.3	2,057.7	1,961.6
2	АДС ТӨХК	102.4	43.2	105.4	261.8	291.3	214.8
Төвлөрсөн хангамжид нийлүүлсэн дүн		1,773.1	1,842.3	1,966.8	2,218.1	2,349.0	2,176.4
3	УБТЗ ХНН	45.7	29.0	41.7	48.1	68.7	61.6
4	Бор-Өндөр УБҮ	36.8	32.5	29.5	40.4	36.2	37.4
5	Чандмань-Илч ОНӨХХК	37.7	48.1	43.7	51.2	58.6	49.8
6	Замын-Үүд ДС ТӨҮГ	-	31.8	17.9	20.1	27.4	28.0
7	Энержиплас ХХК	11.2	12.3	14.5	20.2	22.2	16.3
8	Бусад хэрэглэгч	55.1	15.4	31.3	39.0	16.0	14.3
9	Автожин	28.9	38.4	36.8	40.3	45.5	44.9
Нийт дүн		1,988.6	2,049.8	2,182.3	2,477.5	2,623.6	2,428.7

Эх сурвалж: Шивээ-Овоо ХК

2.14 Дээрх ТЭЗҮ-ээр эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах, Төвийн эрчим хүчний системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөн 4.5 сая тоннд хүргэхээр төлөвлөжээ.

2.15 Уурхайн техникийн бэлэн байдлын коэффициент 2025 онд 76.9 хувьтай байхаар төлөвлөсөн боловч техник ашиглалтын коэффициент 69.8 хувьтай байна. Нийт 64 техник бүртгэлтэйгээс 56 нь ашиглагдаж, 8 нь ашиглах боломжгүй зогссон байна. Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 56 техникийн хувьд, Уурхайн уул тээврийн технологийн 22 автомашины 10 нь ашиглалтын хугацаа дуусчээ. Тухайлбал,

- Уулын тоног төхөөрөмж болох цахилгаан 7 экскаватораас 5 нь ашиглалтын хугацаа 13-25 жил;
- 2 өрмийн машинаас DM45E тэсэлгээний цооног өрөмдлөгийн машин ашиглалтын нормт хугацаа 18 жил;
- Хүнд машин механизм урвуу хутгуурт 8 гидроэкскаватораас 2 нь ашиглалтын хугацаа 4-8 жил;
- Дугуйт 7 ачигчаас 2 нь ашиглалтын хугацаа 3-4 жил;
- Гинжит 4 бульдозероос 1 нь ашиглалтын хугацаа 9 жил;
- Зам арчилгааны 3 автогрейдерээс 2 нь ашиглалтын хугацаа 3 жил;
- Зам усалгааны 3 машинаас 1 нь ашиглалтын хугацаа 11 жилээр тус тус хэтэрсэн байна.

Хүснэгт 26. Шивээ-Овоо ХК-ийн шинэчилсэн дунд хугацааны ТЭЗҮ-ээр олборлох нүүрс, мянган тонноор

№	Хэрэглэгч байгууллага	I-III жил	IV жил	V жил	VI жилээс эхлэн
1	ДЦС-4 ТӨХК	1,690.0	1,750.0	1,600.0	1,650.0
2	АДС ТӨХК	120.0	120.0	120.0	120.0
Төвлөрсөн хангамжид нийлүүлсэн дүн		1,810.0	1,870.0	1,720.0	1,770.0
3	УБТЗ ХНН	60.0	60.0	20.0	60.0
4	Бор-Өндөр УБҮ	50.0	50.0	20.0	40.0
5	Сайншанд ДС	50.0	50.0	30.0	50.0

6	Сүхбаатар ДС		10.0	10.0	10.0
7	Зуунмод ДС	20.0	20.0	10.0	20.0
8	Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээ		440.0	2,200.0	2,550.0
Нийт дүн		2,000.0	2,500.0	4,000.0	4,500.0

Эх сурвалж: Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг ашиглах ил уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ

2.16 Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхайд үүссэн хөрс хуулалтын хоцрогдлын хэмжээг Эрдэнэс Монгол ХХК, Шивээ Овоо ХК-ийн хооронд 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн баталгаажуулсан актаар дараах байдлаар дүгнэсэн байна. Үүнд:

- Шивээ-Овоо ХК-ийн уурхай нь 2025 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6.26 сая м.куб хөрс хуулалтын хоцрогдолтой байгаа нь уурхайн ерөнхий налууугийн өнцгийг 32-42 градус хүртэл нэмэгдүүлж, улмаар хажуугийн тогтворжилт алдагдах, гулсалт нуралт үүсэх зэрэг хүндрэлүүд үүсэж болзошгүй байгаад анхааралд хандуулах шаардлагатай.
- Уулын тоног төхөөрөмж, машин, механизмын шинэчлэлийг хийж ажилласны үр дүнд хөрс хуулалтын хоцрогдлыг бууруулан ажиллаж байсан хэдий ч сүүлийн жилүүдэд эрчим хүчний нүүрсний хэрэглээ өсөж, хэрэглэгч станцуудад захиалгат нүүрсний хэмжээгээ хүйтний улиралд эрс нэмэгдүүлж төлөвлөгөөнд тусгаадаагүй нүүрсийг худалдан авах зайлшгүй шаардлага үүссэний улмаас төлөвлөгөөнөөс илүү нүүрс олборлож мөн уурхайн хөрсний зузаан нэмэгдэж 116.0 м хүрсэн нь хөрс хуулалтын хоцрогдлыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болсон байна. (Шивээ-Овоогийн уурхайн суурилагдсан хүчин чадал 2 сая тонн боловч төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээнээс шалтгаалж сүүлийн жилүүдэд 2.6 сая тонн нүүрс олборлосон байна)

Нүүрсний уурхайнуудад техник, технологийн шинэчлэл хийхгүйгээр цаашид өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах боломжгүй байна

2.17 Шивээ-Овоогийн нүүрсний уурхай нь техник, тоног төхөөрөмж хуучирснаас гадна хөрс хуулалтын хоцрогдолтой, мөн суурилагдсан хүчин чадлаас давсан захиалга хангаж байгаа нь цаашид Улаанбаатар хотын болон бусад өсөн нэмэгдэж байгаа эх үүсвэрүүдийн хэрэгцээг хангах боломжгүйд хүрэх эрсдэлтэй байна.

Хүснэгт 27. Шивээ-Овоо ХК-ийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2020	2021	2022	2023	2024	2025
1	Нүүрс олборлолт	мянган тонн	2,007.3	2,040.2	2,169.1	2,479.1	2,633.3	2,464.2
2	Нүүрс борлуулалт	мянган тонн	1,988.6	2,049.8	2,182.3	2,477.5	2,623.6	2,428.7
3	Нийт орлого	тэрбум төгрөг	57.9	59.6	67.5	97.2	112.3	125.9
4	Нийт зардал	тэрбум төгрөг	60.2	68.2	86.5	108.2	126.5	123.6
5	Татварын өмнөх ашиг/ алдагдал	тэрбум төгрөг	(2.3)	(8.6)	(19.0)	(11.0)	(14.3)	2.2
6	ААНОАТ-ын зардал	тэрбум төгрөг	0.0004	0.001	0.002	0.001	0.002	0.4
7	Татварын дараах ашиг/ алдагдал	тэрбум төгрөг	(2.3)	(8.6)	(19.0)	(11.0)	(14.3)	1.8
8	1 тонн нүүрсний өртөг	төгрөг	29,990.1	33,434.2	39,870.8	43,651.8	48,046.8	50,175.0
9	Ажилчдын тоо	хүн	560.2	526.0	434.2	435.6	428.8	433.0
10	Сарын дундаж хөлс	мянган төгрөг	1,275.5	2,057.8	2,801.4	3,365.1	3,970.9	4,086.6
11	Борлуулалт 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.01	1.12	1.21	1.11	1.13	0.96

Эх сурвалж: Шивээ-Овоо ХК

2.18 Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд дээрх хүндрэлүүд үүссэнээс гадна нүүрсний борлуулалтыг ЭХЗХ-оос тогтоосон тарифаар буюу өөрийн өртгөөс доогуур үнээр борлуулж байгаагаас санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүй, хуучирсан техник, тоног төхөөрөмжөө шинэчлэх, суурилагдсан хүчин чадлаа нэмэгдүүлэх боломжгүй байдалд хүрсэн тул төрөөс урт, дунд хугацааны цогц арга хэмжээг авч Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэгцээг хангахад анхаарах зайлшгүй шаардлагатай болсон байна.

Хүснэгт 28. ЭХЗХ-оос Багануур ХК, Шивээ-Овоо ХК-ийн эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоосон байдал

Шийдвэр гаргагч	ЭХЗХ	Багануур ХК-ийн ТҮЗ	ЭХЗХ	ЭХЗХ	ЭХЗХ	ЭХЗХ	ЭХЗХ
Огноо	2019.07.09	2019.07.26	2022.11.25	2024.09.25	2024.09.25	2024.12.06	2025.04.02
Дугаар	373	26	588	593	593	694	167
Тогтоосон тариф	33,500.0	33,500.0	43,310.0	54,091.0	43,310.0	54,091.0	51,386.0
Мөрдсөн огноо	2019.07.09		2022.11.25	2024.09.01	2024.11.01	2024.12.01	2025.04.01

Эх сурвалж: Шивээ-Овоо ХК, Багануур ХК

2.19 Өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахын тулд Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,

- Багануурын уурхайг түшиглэн байгуулах Хүрэн нүүрснээс хагас кокс, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэнэс ҮТП ХХК-ийн захиалгаар Сэдин Энжинээринг Монголиа ХХК боловсруулжээ. Уг төслийн зорилго нь үйлдвэрлэлийн зардал багатай, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар Багануурын ордын хүрэн нүүрсийг гүн боловсруулж, хагас кокс үйлдвэрлэн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах нүүрсний пиролизийн үйлдвэр байгуулах бөгөөд жилд 600.0 мянган тонн хагас кокс үйлдвэрлэх хүчин чадалтай уг үйлдвэрийн хүрэн нүүрсний хэрэгцээ жилд 1,867.7 мянган тонн;
- Шинэ ДЦС-5-ыг ДЦС-2-ын ашиглаж байгаа үнсэн сангийн талбайд барихаар ТЭЗҮ-ийг Пауэрчайна группын Хэбэй эрчим хүчний судалгаа, График төслийн хүрээлэн боловсруулсан байна. Уг станц нь эргэлтэт буцламтгай үет шаттай 2 зуух, завсрын халаалттай өндөр даралтын 2 турбин генератортай, станцын хүчин чадал $2 \times 150 = 300$ МВт, дулаацуулгын хэрэгцээг хангах станцын тооцоот чадал 340 Гкал/цаг, нүүрсийг Багануурын болон Шивээ-Овоогийн нүүрсийг хольж гаргаж авах ба хэрэглээ жилд 1,745.1 мянган тонн;
- БНХАУ-ын Эрчим хүчний инженеринг групп guangdong цахилгаан станцын График төслийн институт ХХК-ийн 2019 онд боловсруулсан Багануурын дулааны цахилгаан станцын (700МВт-ын нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станц) төсөл ТЭЗҮ 44-FC10081K-A01 эцсийн тайланаар Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг жилд 4 сая тонн хүртэл өргөтгөснөөр 2×200 МВт-ын хүчин чадалтай блоккийн жилийн нүүрсний хэрэглээ буюу 1,900.0 мянган тонн нүүрсийг хангах ба урт хугацаандаа 2×200 МВт + 300 МВт-ын хүчин чадалтай блок ашиглалтад ороход шаардагдах нүүрсний хэрэглээ буюу жилд 4,000.0 мянган тонн;
- Улаанбаатар хотын гэр хорооллын дэд төвийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд хэрэгжиж байгаа Сэлбэ дэд төвийн 28 МВт-ын хүчин чадалтай дулааны станцын Ричвелл инженеринг ХХК-ийн 2018 онд боловсруулсан ТЭЗҮ-ээр жилд бүрэн хүчин чадлаараа 49.8 мянган тонн нүүрс хэрэглэх ба нүүрсийг Багануурын уурхайгаас төмөр замаар Тавантолгой өртөөгөөс автомашинаар татаж авахаар тусгажээ.
- Улаанбаатар хотын гэр хорооллын дэд төвийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд хэрэгжиж буй Дамбадаржаа дэд төвийн 63 МВт-ын хүчин чадалтай дулааны станцын ТЭЗҮ-ийг “Мон Энержи Консалт” ХХК 2020 онд боловсруулсан байна. Тус ТЭЗҮ-ийн тооцоогоор станц бүрэн хүчин чадлаар ажиллах үед нүүрсний хэрэглээ цагт 19.2 тонн, хоногт 461 тонн, жилийн турш тасралтгүй ажилласан тохиолдолд 168.3 мянган тонн байхаар тооцсон байна. Станцын нүүрсийг Багануурын уурхайгаас авто замаар татан авах, мөн төмөр замаар Улаанбаатар хотод хүргэсэн нүүрсийг авто машинаар дулааны станцад тээвэрлэх боломжтой байхаар тусгажээ.
- Нийслэлийн Налайх дүүргийн дулаан хангамжийн шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ-ээр үндсэн хэрэглээг Шивээ-Овоо уурхайн нүүрсээр, нөөцөд Багануурын уурхайн нүүрс түлэхээр ордын нүүрсний техникийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцсон, хэрэглэгчдийн дулааны тооцоот ачаалал буюу оргил ачаалал (185 МВт)-ын үед QXF58-166/70-AII 3 зуух 85 хувь (147.9 МВт)-ийн ачаалалтайгаар ажиллахаар тооцоолоход жилдээ Багануурын нүүрсээр 240.1 мянган тонн ($Q^{H_p} = 3360$ ккал/кг), Шивээ-Овоогийн нүүрсээр 269.7 мянган тонн ($Q^{H_p} = 3000$ ккал/кг) нүүр түлэхээр тооцоо гарч байна. Тээвэрлэлтийн хувьд хуучин ашиглагдаж байсан Налайхын төмөр замыг сэргээн ашиглахаар тооцсон тул төмөр замын тээврийг сонгосон. Хэрэв УБТЗ-аас энэхүү чиглэлийн төмөр замыг сэргээн ашиглах боломжгүй гэсэн шийдвэр гарвал автомашинаар тээвэрлэх хувилбарыг ашиглахаар байна.

2.20 Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай санхүүгийн хүндрэлд орж, техник, технологийн бодлогоо бие даан, цаг тухайд нь хэрэгжүүлэх боломжгүйгээс уурхайн үндсэн техникүүд 20-оос дээш жилийн насжилттай, хэт хуучирч, хөрөнгө оруулалт хийж хүчин чадлыг нэмэгдүүлээгүй тохиолдолд эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг тасралтгүй, найдвартай хангах боломжгүй болжээ.

Төвлөрсөн дулаан хангамжийн системийн барилга, байгууламжийн үндсэн тоноглол, тоног төхөөрөмжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоосон норм, дүрэм байхгүй нь засвар, шинэчлэл, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх үйл явц бодит хэрэгцээнд үндэслэхгүй байх эрсдэлтэй байна

2.21 Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9⁵⁶-д барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасны дагуу “Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа тогтоох дүрэм”-ийг БХБС-ын (хуучин нэрээр) 2023 оны 60 дугаар тушаалаар баталжээ.

2.22 Дүрмээр барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг дараах байдлаар тооцож, тогтоосон байна. Үүнд:

⁵⁶Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

- Барилгын норм, дүрэм⁵⁷ болон тухайн барилга байгууламжийн ашиглалтын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага тогтоох (дүрмийн 1.2 заалт);
- Өмчлөгч, ашиглагчийн хүсэлтээр барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын жишиг хугацаа (БД 13-104-20) барилгын дүрмийн "барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа" дахь хугацаатай уялдуулж, хуулийн этгээд ашиглалтын үе шатанд тооцож, тодорхойлох (Дүрмийн 3.2 заалт).

2.23 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын жишиг хугацаа (БД 13-104-20) барилгын дүрэмд заасан хугацаа нь барилгын суурь, хана, шат, хучилтын эдэлгээний хугацааг зохицуулсан ба барилгын дулаан хангамжийн шугам сүлжээний ашиглалтын хугацааг тусгаагүй, өөрөөр хэлбэл, барилгын дулаан хангамжийн шугам сүлжээний элэгдэл, хорогдлын жишиг хугацааг зохицуулаагүй байна.

2.24 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэр, дулаан дамжуулах, түгээх, хангах байгууллагуудын тоноглол, шугам, сүлжээний элэгдэл, хорогдлыг тооцоход ЭХЗХ-ны баталсан Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам⁵⁸ болон Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал⁵⁹-д заасан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцоход баримтлах хугацааг жишиг болгон мөрдөж байна.Үүнд:

- Төмөр бетон, угсармал байшин, төмөр сараалжтай ердийн, тоосгон болон блокон барилга 60 жил;
- Бүх төрлийн зуух, зуухны тоног төхөөрөмж, халах гадаргуу 20-30 жил;
- Бүх төрлийн турбин, турбины тоног төхөөрөмж 30-40 жил;
- 100 МВт хүртэл хүчин чадалтай бүх төрлийн генератор, дагалдах тоноглолууд 20-30 жил;
- 100 МВт буюу түүнээс дээш хүчин чадалтай генератор, дагалдах тоноглолууд 30-35 жил;
- Өндөр даралтын уурын болон дулааны шугамын хаалт 15 жил;
- Ф500 мм ба түүнээс дээш голчтой дулааны шугам, хоолой (газар доогуур болон ил байрлалтай) 30 жил;
- Ф500 мм хүртэл голчтой дулааны шугам, хоолой 25 жил;
- Халаалтын болон хэрэглээний усны шугам, хоолой 25 жил.

2.25 Барилгын тухай хуулиар барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан ч баталсан баримт бичигт байгууламжид хамаарах хэсгийг бүрэн тусгаагүйгээс орхигдсон хэсгийн эдэлгээний жишиг хугацааг ЭХЗХ-ны тогтоолоор баталж байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг харуулж байна.

2.26 Дулаан хангамжийн эх үүсвэрийн тоноглол, дамжуулах, түгээх, хангах байгууллагуудын шугам сүлжээний насжилт, ашиглалтын хугацааг бүлэглэн тогтоож, мөрдөж байгаа нь техник технологийн шинэчлэл хийх, засвар үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт бодитой мэдээлэлд суурилахгүй байх эрсдэлтэй байна.

Дулааны болон дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолуудын эдэлгээний хугацаа дуусаж, шинэчлэлт хийхэд ихээхэн хэмжээний хөрөнгө шаардахаар байна

2.27 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн доорх эх үүсвэрийн ДЭХ үйлдвэрлэх боломжит хүчин чадал 2,534 Гкал/цаг бөгөөд дулааны 2, 3, 4 дүгээр цахилгаан станцууд нь 40-өөс дээш жил ажиллаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын нөөц хугацаа дууссан, хамгийн сүүлд 2015 онд АДС ашиглалтад орсон байна.

Хүснэгт 29. Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийн ашиглалтын хугацаа, хүчин чадлын мэдээлэл

№	Эх үүсвэр	Ашиглалтад орсон он	Ажилласан жил	Хүчин чадал		Төвлөрсөн дулаан хангамжид эзлэх хувь
				Цахилгаан, МВт	Дулаан, Гкал	
1	ДЦС-2 ТӨХК	1961	65	24	60	2.4
2	ДЦС-3 ТӨХК	1968	58	198	649	25.6
3	ДЦС-4 ТӨХК	1983	43	772	1,525	60.2
4	АДС ТӨХК	2015	11		300	11.8
ДҮН				994	2,534	100.0

⁵⁷Барилгын бүтээц ба буурийн найдваршил-Ерөнхий шаардлага (БНБД 20-01-11), Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын жишиг хугацаа (БД 13-104-20)

⁵⁸ЭХЗХ-ны 2016 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар батлагдаж, ЭХЗХ-ны 2024 оны 504 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.

⁵⁹ЭХЗХ-ны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан.

Эх сурвалж: АДС, ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4 ТӨХК-ууд

2.28 ЭХЗХ-ноос баталсан аргачлалаар эрчим хүчний тариф тооцоход ашиглаж буй үндсэн хөрөнгийн эдэлгээний хугацаагаар тооцоход төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн 30 зуухны 73.3 хувь, 18 турбины 66.7 хувь, 19 генераторын 63.2 хувь нь ашиглалтын хугацаа дууссанаас аваарын байдалд ажиллахад хүрсэн байна. (Станцуудын үндсэн тоноглолын ашигласан жил, ажилласан цагийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-оос харна уу)

Хүснэгт 30. Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийн үндсэн тоноглолын насжилтын мэдээлэл, 2025 оны жилийн эцсийн байдлаар

№	Эх үүсвэр	Зуух			Турбин			Генератор		
		Нийт тоо	Үүнээс: 40 хүртэл жил	40 ба түүнээс дээш жил	Нийт тоо	Үүнээс: 30 хүртэл жил	30 ба түүнээс дээш жил	Нийт тоо	Үүнээс: 30 хүртэл жил	30 ба түүнээс дээш жил
1	ДЦС-2 ТӨХК	5	1	4	3		3	3	1	2
2	ДЦС-3 ТӨХК	13	-	13	8		8	9	1	8
3	ДЦС-4 ТӨХК	8	3	5	7	6	1	7	5	2
4	АДС ТӨХК	4	4		-	-	-	-	-	-
Нийт		30	8	22	18	6	12	19	7	12

Эх сурвалж: АДС, ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4 ТӨХК-ууд

2.29 Дулааны болон ДЦС-уудын үндсэн тоноглолуудын ажиллах цагийн нормтой харьцуулбал, зуухны хувьд ДЦС-2 ТӨХК-ийн 4, 5, ДЦС-3 ТӨХК-ийн 1, 2, 5, ДЦС-4 ТӨХК-ийн 1, 2, 7 дугаар зуухны ажиллах нормчилсон хугацаа 5.0-80.7 мянган цагаар хэтэрсэн, турбины хувьд ДЦС-2 ТӨХК-ийн 1, 3 дугаар турбин 138.4-185.3 мянган цагаар илүү ажилласан, генераторын хувьд ДЦС-2 ТӨХК-ийн 3 генератор 37.7-185.3 мянган цагаар норматив хугацааг хэтрүүлэн ажиллаж байна.

2.30 ДЦС-3 ТӨХК-ийн хамгийн насжилт багатай 9 дүгээр турбогенератор 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдөр аваарын улмаас зогссоноос хойш ажиллагаагүй тул шинэчилж засварлах ажлыг хийж, 2026 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

2.31 ДЦС-4 ТӨХК-ийн тэжээлийн халуун, хүйтэн усны коллекторын 1, 2 дугаар секцүүд 1983-1985 онд ашиглалтад орж, 40-42 дахь жилдээ ажиллаж байна. Эдгээр тоноглолд 2021 онд хийсэн үнэлгээний тайлан⁶⁰- аар цаашид ашиглах боломжтой гэх дүгнэлт гарч, шугам хоолойн гагнааснуудад тогтмол давтамжтайгаар эвдрэл, гэмтлийн сорил хийж байхыг зөвлөсөн ба энэ дүгнэлтэд тулгуурлан мэргэжлийн хяналтын улсын байцаагч ашиглалтын нөөц хугацааг 2025 оны 11 дүгээр сар хүртэл сунгажээ.

2.32 Металл судлал, гагнуурын лабораторийн 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Техникийн магадлалаар ДЦС-4 ТӨХК-ийн тэжээлийн халуун, хүйтэн усны коллекторын 1, 2 дугаар секцүүд нь ашиглалтын явцад зэвэнд идэгдэж, зууванжилт, овойлт болон атираа үүссэн байгаа нь MNS 6967:2022 стандартын зөвшөөрөгдөх хэмжээний дээд хязгаарт хүрсэн тул тэдгээрийг цаашид ашиглах зөвшөөрөл сунгах боломжгүй, бүхэлд нь сольж, аюулгүй, найдвартай байдлыг хангах шаардлагатай гэжээ.

2.33 ДЦС-4 ТӨХК нь 2020-2025 онд алдагдалтай ажилласны улмаас дээрх коллекторын 1, 2 дугаар секцүүдийг бүрэн солих боломжгүйгээс 2026 онд хэсэгчлэн солих засварт шаардагдах 3,180.1 сая төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн тендер шалгаруулалтыг зохион байгуулжээ.

2.34 Тоноглолын насжилт нэмэгдэхийн хэрээр засвар үйлчилгээний давтамж болон зардал өсөхөөс гадна халаалтын оргил ачааллын үед буюу жил бүрийн 11 дүгээр сарын дунд үеэс 02 дугаар сарын дунд үе хүртэл өндөр ачааллаар тасралтгүй ажиллуулж байгаа нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж, төлөвлөгөөт бус зогсолт, гэмтэл саатал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

⁶⁰Герман улсын Штутгарт их сургуулийн Материалын туршилтын институт үнэлгээг хийсэн.

2.35 ДЦС-2, 3, 4 дүгээр станцуудад 2020-2025 онд зуух, турбинд нийт 418 удаагийн гэмтэл, саатал бүртгэгдсэний 61.7 хувь буюу 258 нь зуухтай холбоотой, 38.3 хувь буюу 160 нь турбинтай холбоотой аваарын зогсолт эзэлж байна. ДЦС-4 ТӨХК-ийн 2020-2025 оны зуухны аваарын зогсолтыг гэмтлийн төрлөөр нь авч үзвэл халах гадаргуугийн гэмтэл 75, цахилгаан тоноглолын гэмтлээс 27, хаалт арматурын гэмтэл 13, эргэх механизмын гэмтлээр 8, хүний буруутай үйл ажиллагаанаас 6, хэмжүүрийн гэмтлээр 1 удаагийн аваарын зогсолт гарсан гэж бүртгэгдсэн байна.

Хүснэгт 31. ДЦС-уудын тоноглолд гарсан аваарын зогсолтын мэдээлэл

№	Эх үүсвэр	Тоног- лол	2020	2021	2022	2023	2024	2025	Дүн	Дүнд эзлэх хувь
1	ДЦС-2 ТӨХК	Зуух	9	10	0	4	4	4	31	12.0%
		Турбин	10	7	7	19	7	2	52	32.5%
2	ДЦС-3 ТӨХК	Зуух	13	13	22	14	16	19	97	37.6%
		Турбин	1	8	6	12	1	9	37	23.1%
3	ДЦС-4 ТӨХК	Зуух	12	31	23	19	19	26	130	50.4%
		Турбин	21	16	5	5	10	14	71	44.4%
	Дүн	Зуух	34	54	45	37	39	49	258	61.7%
		Турбин	32	31	18	36	18	25	160	38.3%
Нийт			66	85	63	73	57	74	418	100%

Эх сурвалж: ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК-ийн мэдээлэл

2.36 Аваарын зогсолтын 61.7 хувийг зуухны гэмтэл эзэлж байгаа нь өндөр температур, даралт, оргил ачааллын нөхцөлд удаан хугацаанд ажиллуулснаас металлын бүтэц өөрчлөгдөж, элэгдэл үүссэнтэй холбоотой байна. Тухайлбал, ДЦС-4 ТӨХК-ийн К-1 зуух нь БКЗ-420-140-10С маркийн, 450 тн/цаг хүчин чадалтай, 13.8 МПа даралттай, 560°C температуртай хэт халсан уур үйлдвэрлэх зориулалттай ба 2020–2025 онд нийт 34.2 мянган цаг буюу жилд дунджаар 5.7 мянган цаг ажиллажээ.

2.37 ДЦС-4 ТӨХК-ийн 1-8 дугаар зуухны нийт зогсолтын 20.8 хувийг цахилгаан тоноглолын гэмтэл эзэлж байгаа нь цахилгаан хангамж, тоноглолын найдвартай ажиллагаа хангалтгүй, өндөр ачааллын горимоор тасралтгүй ажиллаж байгаатай холбоотой ба энэ нь аваарын зогсолтын үндсэн шалтгаан болж засвар үйлчилгээний давтамж, зардлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, ДЦС-4 ТӨХК-ийн нэг зуухны засварын ажилд дунджаар 63,051.1 сая төгрөг шаардагдаж байгаа нь өндөр насжилттай үндсэн тоноглолын хэвийн, найдвартай ажиллагааг хангахад их хэмжээний зардал, боловсон хүчний болон техникийн нөөц шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 32. ДЦС-4 ТӨХК-ийн зуухны төлөвлөгөөт засварын ажлын зардлын төлөвлөгөө, 2026 он

№	Үзүүлэлт	Хамрах хүрээ	Нэг зуухны дундаж төсөвт өртөг	Нийт өртөг	Засварын хугацаа	Шаардлагатай ажиллах хүч
1	Засварт хамрагдах зуух	1-8 дугаар зуух	63,051.1 сая төгрөг	504,409.0 сая төгрөг	249 ажлын хоног	432–525 хүн

Эх сурвалж: ДЦС-4 ТӨХК

Эрчим хүчний шинэ эх үүсвэр нэмэгдээгүй байхад хүчин чадлаас давсан хэрэглээнд техникийн нөхцөл олгосоор байгаа нь төвлөрсөн дулаан хангамжийн системд доголдох үүсэх эрсдэлийг бий болгож байна

2.38 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийг ДЭХ-ээр хангаж буй 4 эх үүсвэрийн нийт суурилагдсан хүчин чадал 2,520.4 Гкал/цаг байна. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон нийт хэрэглэгчдийн тооцоот ачаалал 2025 оны 12 дугаар сарын байдлаар 3,650.2 Гкал/цагт хүрч, нийт 14.5 мянган барилга байгууламж төвлөрсөн дулааны эх үүсвэрт холбогдож, эх үүсвэрүүд 1,129.8 Гкал/цаг чадлын дутагдалтай ажиллаж байна.

Хүснэгт 33. Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн хүчин чадал, холбогдсон болон хүлээгдэж байгаа хэрэглээ, 2025 оны байдлаар, Гкал/цаг

№	Эх үүсвэр	Дамжуулах сүлжээний нэр	Суурилагдсан хүчин чадал	Холбогдсон тооцоот ачаалал	Техникийн нөхцөлийн хүлээгдэж буй ачаалал	Нийт ачаалал	Хүчин чадлын дутагдал
1	АДС	урд хойд	400	286.7 327.5	45.6 29	332.3 356.5	-288.7
2	ДЦС-2	-	60	109.1	8.3	117.4	-57.4
3	ДЦС-3	ДДХ	160	641.8	62	703.8	-543.8

	ӨДХ	425	415.9	37.7	453.6	-28.6
	9а		239.4	108.5		
	10а		533.6	70.4		
	11а	1,373.0	540.5	33.1	2,109.3	-736.3
4	ДЦС-4		185.4	53.2		
	16а (210МВт)		329.7	15.5		
	Баянгол	87.6	28.5	68.5	97.0	-9.4
	Өмнөд	14.8	12.2	11.9	24.1	-9.3
	Нийт дүн	2,520.4	3,650.2	543.7	4,193.9	-1,673.5

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.39 Төвлөрсөн дулаан хангамжид 2025 оны 12 дугаар сарын байдлаар техникийн нөхцөл авч холбогдохоор хүлээгдэж байгаа ачаалал 543.7 Гкал/цаг байгаа нь эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлаас 1,673.5 Гкал/цаг буюу 66.4 хувиар хэтрэх төлөвтэй байна.

2.40 Дулааны эрчим хүчний хэрэглэх дүрэм⁶¹-ийн 1.2⁶²-т Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө гэж заасан боловч дүрмийн 1.4⁶³ дэх заалтаар ЭХЯ техникийн нөхцөл олгох зохицуулалтыг оруулжээ.

2.41 Гэтэл ЭХЯ дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч биш, техникийн нөхцөл олгох чиг үүрэггүй боловч 2020-2025 онд 725 хэрэглэгчид 253.3 Гкал/цагийн техникийн нөхцөлийг олгож, эрх бүхий албан тушаалтан өөртөө давуу байдал бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.42 Мөн УБДС ТӨХК нь дулаан дамжуулах тусгай зөвшөөрөлгүйгээр дамжуулах үйл ажиллагааг явуулж, 2020-2025 онд 2,727 хэрэглэгчид 376.3 Гкал/цагийн техникийн нөхцөлийг олгосон нь Засгийн газрын 97 дугаар тогтоолоор баталсан Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 1.4 дэх заалтыг зөрчиж байна.

2.43 Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдохоор иргэн, ААНБ-аас 2020 онд 1,044, 2021 онд 1,076, 2022 онд 1,573, 2023 онд 1,117, 2024 онд 1,462, 2025 онд 1,953, нийт 8,225 хүсэлт ирүүлснээс 3,452-д техникийн нөхцөл олгосны 88 хувийг УБДС ТӨХК, 12 хувийг ЭХЯ шийдвэрлэжээ (Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу).

Хүснэгт 34. Иргэн, ААНБ-аас 2020-2025 онд ДЭХ-ний техникийн нөхцөл хүссэн байдал, Гкал/цагаар

Агуулга	2020	2021	2022	2023	2024	2025
Ачаалал нэмүүлэх	59.9	55.1	96.7	83.2	12.8	39.4
Сунгуулах	213.6	487.5	536.4	203.0	28.5	85.2
Холболтын цэг өөрчлөх	8.6	60.9	16.4	6.6	8.5	6.7
Шинээр техникийн нөхцөл авах	814.0	1,062.9	1,837.0	1,193.0	998.3	1,222.1
Нийт дүн	1,096.1	1,666.4	2,486.5	1,485.8	1,048.0	1,353.4

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.44 Хэрэглэгчдийн техникийн нөхцөл хүссэн агуулгаас харахад шинээр ачаалал нэмэх хүсэлт 78.0 хувийг эзэлж байна.

2.45 Техникийн нөхцөл олголтоос харахад жилд дунджаар 1,371 хүсэлт хүлээн авч, 575 буюу гаргасан хүсэлтийн 41.9 хувьд зөвшөөрөл олгож, 2020-2025 онд нийт 9,275.87 Гкал/цаг дулааны техникийн нөхцөл хүссэнээс 2,382.12 Гкал/цагийн холболт хийх зөвшөөрөл олгосон байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу)

2.46 Техникийн нөхцөл олгосон 2,382.12 Гкал/цагийн хэрэглээнээс 2020-2025 онд 629.6 Гкал/цаг буюу 26.4 хувь нь төвлөрсөн сүлжээнд холбогдсон байна.

Хүснэгт 35. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрт холбогдсон ачаалал, Гкал/цаг

Техникийн нөхцөлөөр холбогдсон ачаалал	2020	2021	2022	2023	2024	2025	Өссөн дүнгээр
ЭХЯ	42.7	58.4	54.8	57.8	12.8	26.8	253.3
УБДС	50.1	47.5	62.6	65.2	92.1	58.9	376.3

⁶¹ Засгийн газрын 2020 оны Дүрэм шинэчлэн батлах тухай 97 дугаар тогтоолоор баталсан.

⁶² Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

⁶³ Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл хүссэн хүсэлтээ цахим системээр гаргах бөгөөд 1 Гкал/цаг болон түүнээс дээш дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 1 Гкал/цагаас доош дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг үйлдвэрлэгч эсхүл дамжуулагч, түгээгч, хангагч тус тус шийдвэрлэнэ.

Нийт холбогдсон ачаалал	92.7	105.9	117.4	123.0	104.9	85.7	629.6
-------------------------	------	-------	-------	-------	-------	------	-------

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.47 Эрчим хүчний тухай хуулиар эрчим хүчний цөмийн эх үүсвэр барих асуудлыг УИХ шийдвэрлэхээр, Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шинэ эх үүсвэрийн талаар судалгаа хийх, ТЭЗҮ-ийг баталгаажуулах, магадлал хийх эрхийг олгож, Засгийн газрын тухай хуулиар Эрчим хүчний сайд эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлогын асуудлыг эрхлэхээр тус тус заасан байна.

2.48 Хуульд заасны дагуу эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах олон тооны ТЭЗҮ-г боловсруулж, их хэмжээний хөрөнгө зарцуулсан ч 2026 оны 6 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотод дулааны эрчим хүчний шинэ үүсвэр нэмэгдээгүй байна. Тухайлбал,

- 2021 оноос Төвдугаар цахилгааны станцын ТЭЗҮ-г боловсруулж эхэлсэн.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн:

- 2021 онд Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах дулааны эх үүсвэр шинээр барих ТЭЗҮ;

- 2024 онд Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн эс үүсвэрийн ТЭЗҮ, тодотгол;

Нийслэл:

- 2024 онд Төвдугаар цахилгаан станцын ТЭЗҮ;

- 2025 онд 10МВт-ын нарны станц, батарей системийн ТЭЗҮ

- ДЦС-4-ийн уурын хүчин чадлыг 500 тн/ц-аар нэмэгдүүлэх төсөл

Төвлөрсөн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид санхүүгийн хүндрэлд орж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болох хэмжээнд хүрчээ

2.49 Төвлөрсөн дулаан хангамжийн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий дулааны 2, 3, 4 дүгээр болон АДС ТӨХК-ийн сүүлийн 5 жилийн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээгээр хэдийгээр хөнгөлөлттэй үнээр авсан түүхий эдээр үйл ажиллагаа явуулж байгаа ч тарифын зохицуулалтаас хамаарч санхүүгийн үзүүлэлтүүд зохистой түвшнээс доогуур түвшинд байна. Тухайлбал,

- Дулаан үйлдвэрлэлийн компаниудын үндсэн болон нийт хөрөнгийн ачаалал зохистой түвшнээс доогуур байгаа нь өндөр хөрөнгө оруулалттай боловч тарифын зохицуулалтаас шалтгаалан хөрөнгийн өгөөж багасаж, санхүүгийн үр ашиг сул байгааг;

- ДЦС-4 ТӨХК болон АДС-ын эргэлтийн хөрөнгийн болон түргэн хөрвөх чадварын харьцаа 2022 оноос хойш 1-ээс доогуур байгаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөр бүрэн барагдуулах чадвар хангалтгүй байгааг;

- Мөнгөн хөрөнгийн харьцаа болон хамгаалалтын мужийн харьцаа буурсан нь мөнгөн хөрөнгийн хүрэлцээ муу, богино хугацаат өр төлбөрийн дарамт өндөр, үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдал сул байгааг;

- ДЦС-4-ийн нийт хөрөнгийн 46.9 хувь нь өр төлбөрөөр санхүүжигдсэн байгаа нь өрийн дарамт харьцангуй өндөр байгааг илтгэдэг бол АДС-ын өрийн хамаарал бага, санхүүгийн эрсдэл харьцангуй тогтвортой байгааг;

- ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4-ийн нийт ашиг, үйл ажиллагааны ашиг болон цэвэр ашгийн түвшин сүүлийн таван жилд бага, зарим жилүүдэд алдагдалтай байгаа нь үйлдвэрлэлийн өндөр өртөг, зардлын дарамтаас шалтгаалан үндсэн үйл ажиллагаанаас тогтвортой ашиг бий болгож чадахгүй байгааг;

- Нийт хөрөнгийн өгөөж (ROA) болон эздийн өмчийн өгөөж (ROE) бага, зарим жилүүдэд сөрөг байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг хангалтгүй байгааг, эздийн өмчийн өгөөж (ROE) бага болон сөрөг үзүүлэлттэй байгаа нь хувь нийлүүлэгчдийн /Засгийн газар/ оруулсан хөрөнгийн өгөөж хангалтгүй, зарим тохиолдолд хөрөнгийн үнэ цэнэ буурч байгааг;

- Мөнгөн гүйлгээ ба орлогын харьцаа бага түвшинд байгаа нь орлого бодит мөнгөн урсгал болж хөрвөх чадвар сул, хэрэглэгчдийн төлбөрийн хоцрогдол болон салбарын онцлогоос шалтгаалсан мөнгөн гүйлгээний хүндрэл байгааг тус тус харуулж байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд дулаан дамжуулах сүлжээний горим, тохируулга, ашиглалт болон техникийн нөхцөл олгох нэгдсэн зохицуулалт байхгүй байна

2.50 ДҮТ ТӨХХК нь төвлөрсөн дулаан хангамжийн ажиллагааны хоногийн горимын дулааны ачааллыг 0-8, 9-17, 18-24 цагуудад гадна агаарын дундаж температуртай уялдуулан дулаан зөөгч усны температур, сүлжээний шууд усны зарцуулалт, сүлжээний нэмэлт усны зарцуулалт, сүлжээний усны даралт, дулааны ачааллын график гэсэн


үзүүлэлтээр горим, тохируулгыг төлөвлөж, эх үүсвэрүүд, дамжуулах, түгээх сүлжээнд өгнө⁶⁴. Мөн өвлийн оргил ачааллын хувилбарыг боловсруулах, ачаалал шилжүүлэх, сэлгэн залгалт хийдэг.

2.51 УБДС ТӨХК нь эх үүсвэрүүдийн боломжит ачааллаас хэрэглээ давсан үед дулааны сүлжээний ачааллыг бууруулж, түгээлт хэрэглээг тэнцвэржүүлэх арга хэмжээ авч ажилладаг байна.

2.52 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем нь 4 эх үүсвэрээс гарах сүлжээний 12 гол шугамаар ДЭХ-ийг дамжуулж байгаагаас ДЦС-4 ТӨХК-ийн Баянголын ам чиглэлийн өөрийн эзэмшлийн шугам болон УБДС ТӨХК 210МВт шугам нь 1 коллектор станцаас дулаан дамжуулж байна.

2.53 ДЦС-4 ТӨХК нь Баянголын ам чиглэлд 65 хэрэглэгчийг 28.7 Гкал/цагийн ДЭХ-ээр хангахаас гадна техникийн нөхцөл авч, холбогдохоор хүлээгдэж буй хэрэглэгчдийн нийт тооцоот ачаалал 68.5 Гкал/цаг байна.

Дүрслэл 7. ДЦС-4 ТӨХК-ийн эх үүсвэрээс шууд холбогдсон ачаалал, хэрэглэгчийн тоо



Эх сурвалж: ДЦС-4 ТӨХК

2.54 Эх үүсвэрүүдтэй шууд холбогдсон хэрэглэгчийн ачаалал нь дулааны сүлжээний нийт ачаалал, хэрэглээ, горим тохируулгад нэгдсэн байдлаар бүртгэгдэж, төлөвлөгдөхгүй байгаа нь төвлөрсөн дулаан хангамжийн системийн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлох, өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг оновчтой төлөвлөх, ачаалал шилжүүлэх, сэлгэн залгалтыг шуурхай зохион байгуулахад хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна.

2.55 Иймд эх үүсвэрээс шууд холбогдсон хэрэглээ болон УБДС ТӨХК-иар дамжуулан түгээж буй хэрэглээний зааг, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, хэрэглэгчийн ачааллыг нэгдсэн байдлаар бүртгэх, төлөвлөх, горим тохиргоонд тусгах нэгдсэн зохицуулалт шаардлагатай байна.

Эх үүсвэрүүдийн хүчин чадал дутагдлаас шалтгаалж өвлийн оргил ачааллын үеийн горимын төлөвлөлт дутуу хийгдэж, хэрэглэгч шаардлагатай хэмийн дулаанаа авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна

2.56 Сүүлийн 6 жилийн хугацаанд буюу 2020-2025 оны халаалтын улиралд дамжуулах сүлжээний усны нийт зарцуулалт 6,428 тн/цаг-аар өссөн байна. Харин 2024–2025 оны халаалтын улирлын сүлжээний усны зарцуулалт өмнөх оны түвшинтэй ойролцоо байгаа нь тухайн жил гадна агаарын температур өмнөх оноос 3°C-аар дулаан байсантай холбоотой байна.

2.57 Сүүлийн жилүүдэд өвлийн оргил ачааллын үеийн гадна агаарын температурын тооцоот утга (-39°C)-аас 10 гаруй хэмээр дулаан байсан нь Улаанбаатар хотын хэмжээнд эх үүсвэрийн дутагдалд оролгүйгээр хэрэглэгчдийг ДЭХ-ээр хэвийн хангаж өвлийн их ачааллыг доголдолгүй давахад нөлөөлсөн байна.

Хүснэгт 36. 2025-2026 оны халаалтын улирлын гидравлик тооцооны дүн, эх үүсвэрүүдийн сүлжээний усны зарцуулалт

Эх үүсвэр	Дулааны тооцоот ачаалал		Усны зарцуулалтын тооцоот ачаалал		(-24°C)-ийн үед тооцсон зарцуулалт
	Шинээр холбогдох	Халаалтын улирлын	(-39°C)-ийн үед	(-24°C)-ийн үед	
Хэмжих нэгж	Гкал/цаг	Гкал/цаг	тонн/цаг	Гкал/цаг	тонн/цаг

⁶⁴ Төвлөрсөн дулаан хангамжийн дүрмийн 2.2.3.4 дэх хэсэг

АДС ТӨХК	Хойд	12.2	327.5	4,093.0	236.0	2,894.0
	Урд	10.0	286.7	3,583.0	206.0	2,464.0
АДС ТӨХК-ийн дүн		22.2	614.2	7,676.0	442.0	5,358.0
Дүн ДЦС-2 ТӨХК		7.9	109.1	1,407.0	79.0	942.0
ДЦС-3 ТӨХК	ДДХ	16.5	641.8	7,926.0	462.0	5,484.0
	ӨДХ	15.9	415.9	5,199.0	299.0	3,612.0
Дүн ДЦС-3 ТӨХК		32.4	1,057.7	13,125.0	761.0	9,096.0
ДЦС-4 ТӨХК	9a/ ф1000	24.8	239.4	2,993.0	172.0	2,115.0
	10a/ ф1200	18.7	533.6	6,768.0	384.0	4,572.0
	11a/ ф1200	8.6	540.6	6,756.0	389.0	4,742.0
	15a/ ф700	22.7	185.4	2,317.0	133.0	1,606.0
	16a/ ф800	17.4	329.7	4,079.0	237.0	2,829.0
Дүн ДЦС-4 ТӨХК		92.2	1,828.7	22,913.0	1,315.0	15,864.0
НИЙТ ДҮН		154.7	3,609.7	45,121.0	2,597.0	31,260.0

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.58 Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон нийт хэрэглэгчдийн тооцоот ачаалал 2025-2026 оны улиралд 3,609.7 Гкал/ц, харгалзах сүлжээний усны зарцуулалт 45,121 тн/ц байхаар байна. Харин гадна агаарын температур (-24°C)-ийн үеийн харьцангуй ачаалал нь 2,597.0 Гкал/ц, сүлжээний усны зарцуулалт 31,260 тн/ц байхаар горимын тооцоолол гарсан байна.

2.59 Өнгөрсөн 2025-2026 оны халаалтын улирлын тооцоогоор харьцангуй тооцоот зарцуулалтыг 31,260 тн/ц-аар байхаар горимын тооцоолол хийсэн боловч оргил ачааллын үед эх үүсвэрүүдийн авч ажиллах боломжит сүлжээний усны зарцуулалт 30,650 тн/ц байхаар горимыг баталсан байна.

Хүснэгт 37. УБДС ТӨХК-ийн 2025-2026 оны халаалтын улирлын тооцооны дүн, горим ажиллагааны хэрэгжилт


“ХАМГИЙН ИХ ЗАРЦУУЛАЛТ” эх үүсвэрүүдийн параметрууд											
Эх үүсвэр	2025-2026 оны халаалтын улирлын тооцоот ачааллаар тооцсон сүлжээний зарцуулалт				“ХАМГИЙН ИХ ЗАРЦУУЛАЛТ” эх үүсвэрүүдийн параметрууд						Өдөр
	Даралт (Ата)		Напор (метр)	Нийт зарцуулалт, тн/ц	Даралт (Ата)		Напор (метр)	Өгөх усны температур	Буцах усны температура	Нийт зарцуулалт, тн/ц	
	Шууд	Буцах									Шууд
АДС ТӨХК	9	2.5	65	5,100.0	9	2	70	122	55/69	5,196.0	2026.01.19
ДЦС-2 ТӨХК	9.5	2.5	70	950.0	8.8	2.3	65	120	56	1,014.0	2026.01.20
ДЦС-3 ТӨХК	ДДХ	11.5	1.8	97	5,500.0	11	2.2	88	122	51	5,310.0
	ӨДХ	11.5	1.8	97	3,600.0	10.2	2.2	80	122	54	3,800.0
ДЦС-3 нийт				9,100.0	ДЦС-3 нийт					9,110.0	2026.01.28
ДЦС-4 ТӨХК	Ф1000 9a/			2,115.0				120	53	2,230.0	2026.01.21
	Ф1200 10a/			4,472.0				120	53	4,700.0	
	Ф1200 1a/	12.5	2	105	4,607.0	12	2	100	120	54	4,490.0
	Ф700 15a/			1,506.0				120	54	1,560.0	
	Ф800 16a/			2,800.0				120	54	3,000.0	
	ДЦС-4 нийт				15,500.0	ДЦС-4 нийт					15,930.0
Сүлжээний усны нийт зарцуулалт				30,650.0	Сүлжээний усны нийт зарцуулалт					31,250.0	

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.60 Гэвч бодит нөхцөл дээр 100-600 тн/ц-ийн зарцуулалтыг илүү авч ажилласан нь цахилгаан эрчим хүчний дутагдлаас шалтгаалж ДЦС-4 ТӨХК температурын горимыг 2°C дутуу барьсан байна.

2.61 Халаалтын оргил ачааллын үед эх үүсвэрүүдийн авч ажиллах боломжит сүлжээний усны зарцуулалтыг өвлийн горимд 30,650 тн/ц-аар баталж байгаа нь бодит тооцооллын хэмжээнд хүрэхээргүй буюу дутуу байгаа нь гадна агаарын температур (-24°C)-ээс дээш хэмээр урт хугацаанд хүйтэрсэн тохиолдолд хэрэглэгч шаардлагатай дулаанаа авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна.

График 6. 2020-2026 оны сүлжээний усны тооцоот зарцуулалт, тонн/цаг



Эх сурвалж: УБДС ТӨХК

2.62 Дулаан үйлдвэрлэлийн эх үүсвэрүүдэд 2025-2026 оны халаалтын улиралд даралт, температурын горим барилтаас шалтгаалж зуух, турбин зогссон зэрэг зөрчлүүд гарсан байна. Тухайлбал,

- Даралтын горимын хувьд дулааны эх үүсвэр дээр 10 удаагийн 217 цагийн зөрчил гарснаас АДС ТӨХК-ийн сүлжээнд 1, ДЦС-2 ТӨХК-ийн сүлжээнд 1, ДЦС-3 ТӨХК-ийн сүлжээнд 3, ДЦС-4 ТӨХК-ийн сүлжээнд 5 удаа;
- Температур горим барилтын хувьд 35 удаагийн 271 цагийн зөрчил гарснаас ДЦС-2 ТӨХК-ийн сүлжээнд 3, ДЦС-3 ТӨХК-ийн сүлжээнд 14, ДЦС-4 ТӨХК-ийн сүлжээнд 18 удаагийн температурын горим зөрчигдсөн байна.

2.63 Энэ нь төвлөрсөн дулаан хангамжид холбогдох хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа ч дамжуулах сүлжээ гадна температур -24°C орчимд систем хязгаарт хүрч, -25°C-аас доош температурт дулаан хангамж хүрэлцэхгүй болсон буюу эрсдэл үүсэж эхэлсэн, дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэн найдвартай байдал хангагдах хүртэл нэмэлт чадлын зөвшөөрөл олгохгүй байх нөхцөл үүссэнийг харуулж байна.

Дулааны эрчим хүч дамжуулах сүлжээ холбогдсон ачааллаа дийлэхээргүй болж, ачаалал оргилдоо хүрчээ

2.64 Улаанбаатар хотын дулаан хангамжийн систем хүчин чадлын дутагдалд орсон, шинээр эх үүсвэрийг бий болгох ажил хийгдээгүй байхад суурилагдсан хүчин чадлаас давсан зөвшөөрөл олгож, ачааллыг нэмэгдүүлсээр байгаа нь дулаан үйлдвэрлэгч, дамжуулах, түгээх, хэрэглэх нэгдсэн системийн аюулгүй найдвартай байдал алдагдах эрсдэлийг дагуулж байна.

2.65 Төвлөрсөн дулаан хангамжид дулааныг ф150-ф1200 мм голчтой, 376.0 км урт 16 магистраль шугам, 1,640 худаг, павильоноор дамжуулах түгээх сүлжээнд нийлүүлж байна.

2.66 Төвлөрсөн дулааны хангамжийн 4 эх үүсгүүрийн 12 дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадварын суурилагдсан хүчин чадал хэмжээ 6 коллекторт 12.6-65.1 хувиар хэтэрсэн, 1-д хэмжээндээ тулсан (ДЦС-4 ТӨХК-ийн 16а), 5-д нь хэвийн хэмжээндээ байж, дамжуулах сүлжээ хэтэрсэн ачааллаар ДЭХ-ийг тээвэрлэж байна.

Хүснэгт 38. ДЭХ-ийг дамжуулах шугамын суурилагдсан болон бодит хүчин чадлын мэдээлэл

Эх үүсвэр	№	Коллекторын нэр	Шугамын голч	Норматив хүчин чадал, тн/цаг	Тооцоот ачаалал, тн/цаг	Ачааллын хэтрэлт	
						Тн/цаг	Хувь
АДС ТӨХК	1	Хойд	Ф700	3,000	4,093	-1,093	36.4

	2	Урд	Ф700	3,000	3,583	-583	19.4
ДЦС-2 ТӨХК	3		Ф1000	3,000	1,407	1,593	-53.1
ДЦС-3 ТӨХК	4	ӨДХ	Ф800	4,800	7,926	-3,126	65.1
	5	ДДХ	Ф1000	4,000	5,199	-1,199	30.0
ДЦС-4 ТӨХК	6	9a	Ф800	4,800	2,993	1,807	-37.6
	7	10a	Ф1200	6,000	6,768	-768	12.8
	8	11a	Ф1200	6,000	6,756	-756	12.6
	9	15a	Ф700	3,000	2,317	683	-22.8
	10	16a	Ф800	4,000	4,079	-79	2.0
	11	Баянгол	Ф800	4000	220	3780	-94.5
	12	Өмнөд	Ф200	250	170	80	-32.0

Эх сурвалж: УБДС ТӨХК

Дулаан дамжуулах шугам хоолойн нэвтрүүлэх чадвар зарим чиглэлд хүрэлцэхгүй байна

2.67 УБДС ТӨХК-ийн 2020-2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний 2020-2025 оны гүйцэтгэлээс харахад 2020 онд 6,701.4 мянган Гкал дулаан эрчим хүч худалдан авч байсан бол 2025 онд 8,279.8 мянган Гкал дулаан эрчим хүч болж 23.5 хувиар нэмэгдсэн байхад 1 Гкал/цагийн орлогыг өөрийн өртөгтэй харьцуулсан харьцаа 2020 онд 0.98 байсан бол 2025 онд 0.96 болж буурсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу)

2.68 Санхүүгийн мэдээллээс харахад үйлдвэрлэн борлуулж байгаа дулааны хэмжээ нэмэгдсэн боловч ашиг орлогын хэмжээ буурч байгаа нь цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулж ашигтай ажиллаж, насжилт өндөртэй үндсэн тоноглолоо засварлах нөөц бүрдүүлж чадахааргүй болсон байна.

2.69 Мөн тус компанийн урт хугацаат өр төлбөр 2020 онд 20.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 162.0 тэрбум болж 8 дахин нэмэгдсэн байна. Энэ нь үндсэн тоноглол болох дулаан дамжуулах системийг гаднын зээл тусламжаар шинэчилсэнтэй холбоотой үүссэн байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 4-өөс харна уу)

2.70 Дээрх зээлийн үндсэн болон хүүний төлбөрт 2026-2031 онуудад 118.3 тэрбум төгрөг төлөөд, 107.4 тэрбум төгрөгийн үндсэн зээл үлдэж байгаа нь УБДС ТӨХК шинэчлэх шаардлагатай үндсэн тоноглолоо өөрийн санхүүгийн эх үүсвэрээр шийдвэрлэх боломж хязгаардлагдмал байгааг харуулж байна.

2.71 УБДС ТӨХК-ийн эзэмшилд буй нийт 376.0 км урт дулааны шугамын 48.2 км буюу 12.8 хувь нь 40 ба түүнээс дээш жил, 13.0 км буюу 3.5 хувь нь 30-39 жил, 19.5 км буюу 5.2 хувь нь 20-29 жил, 148.6 км буюу 39.5 хувь нь 10-19 жилийн, 146.8 км буюу 39.0 хувь нь 9 хүртэлх жилийн насжилттай байна.

Хүснэгт 39. УБДС ТӨХК-ийн ДЭХ дамжуулах, түгээх шугамын насжилтын судалгаа, 2025 оны байдлаар

Хүлээн авч үзэх 1-Эхний дүрэмтэй байгууллага, туслах агуулгын насжилтын бүрэлдэх, 2020 онд байгуулаар							
№	Шугамын хэмжээ буюу голч (мм)	Шугамын урт, км, насжилтаар					Нийт
		9 хүртэлх жил	10-19 жил	20-29 жил	30-39 жил	40 ба түүнээс дээш жил	
1	150	3.0	0.6	0.1	0.1	1.3	5.0
2	200	3.9	5.0	1.9	0.0	0.0	10.7
3	250	5.9	9.0	1.6	0.1	1.3	17.9
4	300	5.6	14.8	3.0	0.4	0.7	24.5
5	350	1.8	4.0	1.4	0.8	0.0	8.0
6	400	27.9	26.6	3.9	2.1	3.5	64.1
7	500	20.4	29.7	1.5	0.4	3.0	54.9
8	600	26.6	12.6	0.4	0.0	0.0	39.6
9	700	25.0	22.9	0.0	9.1	0.0	57.0
10	800	11.8	20.7	0.2	0.0	23.8	56.5
11	1000	14.8	0.3	5.5	0.0	6.6	27.3
12	1200	0.0	2.5	0.0	0.0	8.0	10.5
Нийт	Урт, км	146.8	148.6	19.5	13.0	48.2	376.0
	Эзлэх хувь	39.0	39.5	5.2	3.5	12.8	100

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.72 Төвлөрсөн дулаан хангамжийн 4 эх үүсвэрийн 12 дамжуулах сүлжээний 7 нь суурилагдсан нэвтрүүлэх чадвараас 65.1 хүртэл хувиар хэтэрсэн нь дулаан хангамжийн эх үүсвэрээс гарах дамжуулах сүлжээний ачааллын хуваарилалт жигд бус байгааг харуулж байна. Тухайлбал, ДЦС-3 ТӨХК-ийн Ø1000 мм-ийн голчтой ДДХ коллектор шугамын ачаалал нь норматив хүчин чадлаас 3,126 тн/ц буюу 65.1 хувь, АДС-ийн Ø700 мм-ийн голчтой урд шугам нь 1,093 тн/ц буюу 36.4 хувиар тус тус хэтэрчээ.

2.73 УБДС ТӨХК-ийн 2020–2025 оны гэмтлийн судалгаагаар зэврэлт, ханын зузааны нимгэрэлт, гагнуурын цууралт зэрэг шалтгаант гэмтэл зонхилж, эдгээр нь 30-аас дээш жилийн насжилттай шугам хоолойд голлон илэрч сүлжээний гэмтлийн 44.4 хувийг буюу **“хамгийн өндөр”** хувийг эзэлж байна.

Хүснэгт 40. УБДС ТӨХК-ийн дамжуулах, түгээх шугам сүлжээний гэмтлийн судалгаа, ашигласан жилээр

Ашигласан жил	2020	2021	2022	2023	2024	2025	Нийт дүн	Дүнд эзлэх хувь
0–9 жил	4	-	-	-	1	1	6	3.3
10–19 жил	25	5	7	-	7	6	50	27.8
20–29 жил	2	8	10	9	2	6	37	20.6
30-аас дээш жил	11	25	16	8	13	7	80	44.4
Насжилт тодорхойгүй	-	4	-	-	1	2	7	3.9
Нийт	42	42	33	17	24	22	180	100.0

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.74 Эдгээр гэмтлийг нөхөж гагнах, оруулга хийх зэргээр түр зуур аргацаан засварлаж байгаа нь үндсэн шалтгааныг бүрэн шийдвэрлэж чадахгүй тул тухайн хэсэгт гэмтэл дахин давтагдах, улмаар системийн найдвартай ажиллагаа алдагдах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

СОТ-3 магистралийн Ø400 мм-ийн өгөх шугамын гагнуурын цууралтыг бүслүүрэн хомуутаар засварласан байдал, 2025 он



3/6холбоос магистралийн ДХ-609-3 дугаар худагт байрлах Ø400 мм голчтой буцах шугамын отводны гагнуур цуурсан гэмтлийг хуучин цонхыг авч, 30х30 см хэмжээтэй шинэ цонхыг 2 үе гагнаж засварласан байдал



2.75 УБДС ТӨХК-ийн тооцоолсноор шугамуудыг шинэчлэхэд урьдчилсан байдлаар 572.7⁶⁵ тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд насжилт өндөртэй Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв шугамуудын байршлын дүрслэлд улаанаар будаж харууллаа.

⁶⁵УБДС ТӨХК-ийн ерөнхий захирлын 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталсан 2026-2028 онд компанийн өөрийн хөрөнгөөр болон улс, нийслэл, төсөл хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн солихоор төлөвлөж буй дулааны шугам, тоноглолын ажлын төлөвлөгөө

Дүрслэл 8. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв шугамуудын байршил



Эх сурвалж: УБДС ТӨХК

2.76 Дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээний эвдрэл гэмтэл болон хэрэглэгчийн сүлжээний усны зүй бус хэрэглээ зэргээс шалтгаалж УБДС ТӨХК нь эрчим хүчний эх үүсвэрүүдээс сүлжээний усыг дүүргэх нэмэлт усыг худалдан авч, 2024 онд 844.2 сая, 2025 онд 423.2 сая, 2026 оны эхний хагаст 572.7 сая төгрөгийг төлж, нэмэлт усны төлбөр нь УБДС ТӨХК-ийн дулааны алдагдлын 2.5 хүртэл хувийг эзэлдэг тооцоолол хийсэн байна.

2.77 УБДС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/97 дугаар тушаалаар “хэрэглэгчийн системийн нэмэлт усанд агуулагдах дулааны энерги болон усны алдагдлыг тооцох журам”-ыг баталсан байна. Дээрх аргачлалын дагуу Хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах гэрээний 4.3, дулаанаар зохицуулалттай хангах ТЗЭ-дийн “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.2.9-д “...нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэлт устай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчээс тооцож авах” -аар заалт оруулж, төлбөрийг эх үүсвэрүүдэд төлөх нэмэлт усны дундаж үнээр буюу 1 м.куб тутамд 562.5 төгрөгөөр тооцож авахаар төлөвлөсөн байна.

2.78 ЭХЗХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор “Дулаанаар зохицуулалттай хангах ТЗЭ, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийг шинэчлэн баталж, дүрмийн 5.2.9-д “хэрэглэгчдийн дулааны тоног төхөөрөмж дээр суурилсан нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэлт устай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчээс тооцож авна” гэсэн заалтыг нэмж оруулан, УБДС ТӨХК нь нэмэлт усны төлбөрөө хэрэглэгчдээс авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.79 Түүнчлэн ЭХЗХ-оос харилцан адилгүй тариф тогтоож, мөрдүүлж байгаа нь хэрэглэгч болон хангагч байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж, тэгш бус байдлыг бий болгож байна.

Хүснэгт 41. УБДС ТӨХК-ийн 2020-2025 оны борлуулалтын орлогын гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024	2025
1	ААНБ	мянган.Гкал	1,806.6	1,801.4	2,029.6	1,970.5	2,073.7	2,100.3
		Нэгжийн үнэ, төгрөг.Гкал	25,626.7	27,547.8	28,064.2	34,105.1	33,088.7	34,468.1
		сая төгрөг	46,297.9	49,624.8	56,959.6	67,205.3	68,617.1	72,394.6
2	ОСНААУГ-ын харъяа ХҮТ	мянган.Гкал	2,568.9	2,498.4	2,634.5	2,727.0	2,992.9	3,026.3
		Нэгжийн үнэ, төгрөг.Гкал	11,854.5	13,615.7	14,011.3	13,434.8	12,132.3	9,082.9

3	ТЗЭ ХОСК	сая төгрөг	30,452.7	34,017.2	36,913.2	36,636.6	36,310.3	27,487.5
		мянган.Гкал	2,325.9	2,559.1	2,811.1	2,990.7	3,101.1	3,153.2
		Нэгжийн үнэ, төгрөг.Гкал	14,001.7	15,167.9	16,207.5	14,636.8	13,776.2	11,653.9
		сая төгрөг	32,566.3	38,816.3	45,561.2	43,774.4	42,721.5	36,747.0
Нийт дүн	Нэгжийн дундаж үнэ, төгрөг.Гкал	мянган.Гкал	6,701.4	6,858.9	7,475.3	7,688.2	8,167.7	8,279.8
		сая төгрөг	109,317.0	122,458.4	139,434.0	147,616.3	147,648.9	136,629.0
		Нэгжийн дундаж үнэ, төгрөг.Гкал	16,312.6	17,853.9	18,652.7	19,200.2	18,077.2	16,501.5
		сая төгрөг	109,317.0	122,458.4	139,434.0	147,616.3	147,648.9	136,629.0

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.80 ЭХЗХ-оос ДЭХ-ний үнэ тарифыг бодит өртөгт нь хүргэх зорилгоор нэгдсэн сүлжээнд холбогдсон Улаанбаатар хотын хэрэглэгчдэд (үйлдвэр, ААНБ, айл өрх) борлуулах дулааны үнийн тарифыг 2025 оны 5 дугаар сарын 16-наас мөрдөхөөр ЭХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 639 дүгээр тогтоолоор баталсан. Засгийн газраас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих⁶⁶, иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний үнэ, тариф, төлбөр, хураамжийг нэмэгдүүлэхгүй байх⁶⁷ гэсэн шийдвэрүүдийг 2025 онд гарсны улмаас дээрх шинэчлсэн тарифыг мөрдүүлээгүй байна.

2.81 Энэ нь ЭХЗХ-ны баталсан ашгийн зохих түвшнийг хангасан цахилгаан, ДЭХ-ний үнэ, тарифыг мөрдөж ажиллахад хөндлөнгөөс нөлөөлж, үнийг хэт доогуур барьснаас салбар техник технологийн хоцрогдолд орж, цаашид хөгжих боломжгүй байгааг харуулж байна.

Төвлөрсөн дулаан хангамжийн системийн өмчлөгч, эзэмшигч нь тодорхойгүй 59.4 км урт шугамд гэмтэл саатал гарсан үед шуурхай засварлах, ашиглалтыг хариуцах эзэнгүй байна

2.82 ДЭХ-ийг дамжуулахад нийт 771.0 км шугам сүлжээ ашиглаж байгаагаас 648.5 км буюу 84.1 хувь нь 200 мм ба түүнээс дээш голчтой, 122.5 км буюу 15.9 хувь нь 200 мм хүртэл голчтой шугам байна. Үүнээс хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй, дундын эзэмшилд ашиглаж байна.

Дүрслэл 9. Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км дулааны шугамын байршил



Эх сурвалж: ЭХЗХ

⁶⁶Засгийн газрын 2025 оны 132 дугаар тогтоолоор хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

⁶⁷ Засгийн газрын 2025 оны 236 дугаар тогтоолоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний үнэ, тариф, төлбөр, хураамжийг 2026 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

2.83 Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм⁶⁸-ээр 200 мм болон түүнээс дээш голчтой төв болон салаа шугамыг төрийн өмчид шилжүүлэх⁶⁹ тухай, энэ дүрмийн 1.5 дахь хэсэгт шугам сүлжээг барихад гаргасан хөрөнгийн эх үүсвэрээр өмчийн харьяаллыг тодорхойлохоор зохицуулсан нь хувийн өмчийн хөрөнгөөр баригдсан шугам сүлжээг төрийн өмчид шилжүүлэх тухай нарийвчилсан зохицуулалтгүй байна.

2.84 Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан гадна дулааны 59.4 км урттай шугам сүлжээг төрийн өмчид шилжүүлэх тухай тодорхой зохицуулалтгүйгээс уг шугам сүлжээний засвар, үйлчилгээ, шинэчлэлийн ажлыг хариуцах эзэнгүй, диспетчерийн нэгдсэн удирдлага, аюулгүй ажиллагааны хяналтгүй байх эрсдэл үүссэн байна.

Хүснэгт 42. ДЭХ дамжуулах шугам, хоолойн эзэмшил, өмчлөл 2025 оны жилийн эцсийн байдлаар

№	ТЗЭ-дийн нэр	Өмч, эзэмшлийн байдал	Шугамын урт (км)		Нийт /км/	Дүнд эзлэх хувь
			Голч /км/			
			200 мм хүртэл	200 мм-ээс дээш		
1	ОСНААУГ ОНӨААТҮГ	Нийслэлийн өмчид бүртгэлтэй	23.7	14.4	38.1	61.7
		Нийслэлийн өмчид бүртгэлгүй боловч засвар үйлчилгээг нь хариуцдаг	16.1	7.6	23.7	38.3
		ОСНААУГ-ын дүн	39.8	22.0	61.8	8.0
2	ХОСК-иуд	Өмчид бүртгэлтэй	56.6	217.2	273.8	35.5
3	УБДС ТӨХК	Төрийн өмчид бүртгэлтэй	5.0	371.0	376.0	48.8
4	Дундын эзэмшил	Өмчийн эзэн тодорхойгүй	21.1	38.3	59.4	7.7
Нийт			122.5	648.5	771.0	100

Эх сурвалж: УБДС ТӨХК

2.85 Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан өмчийн эзэн нь тодорхойгүй гадна дулааны 59.4 км урттай шугам сүлжээнд сүүлийн 3 жилийн байдлаар нийт 85 удаагийн гэмтэл бүртгэгдэж, 43 гэмтлийг ОСНААУГ ОНӨААТҮГ, 7 гэмтлийг УБДС ТӨХК, 4 гэмтлийг ХОСК, 31 гэмтлийг дээрх байгууллагууд хамтран засварлажээ.

Хүснэгт 43. Дулааны шугам сүлжээний 2023-2025 онд гарсан гэмтлийг засварласан тоо

№	Гэмтэл засварласан байгууллага	2023	2024	2025	Нийт
Нийт гэмтэл		28	29	28	85
Үүнээс	ОСНААУГ ОНӨААТҮГ	19	17	7	43
	УБДС ТӨХК	0	3	4	7
	ХОСК	0	0	4	4
	Хамтран засварласан	9	9	13	31

Эх сурвалж: Улаанбаатар хотын захирагчийн албаны Хотын инженерийн дэд бүтцийн газар

2.86 Иймд хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан дулааны шугам сүлжээний өмчлөлийг хэрхэн шилжүүлэх, засвар үйлчилгээг хариуцах асуудлыг тодорхой болгож, төрийн өмчид шилжүүлэх зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгайлан тусгах шаардлагатай байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн суурилагдсан хүчин чадал, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүй, системийн чадлын дутагдал өндөр хэвээр байна

2.87 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх болон үр ашгийг сайжруулахад чиглэсэн төсөл арга хэмжээг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, Нийслэлийн хөрөнгө оруулалт болон салбарын байгууллагын өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

2.88 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон дулааны эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал 2025 оны байдлаар 1,129.8 Гкал/цаг буюу 44.8 хувиар хэтэрсэн, цаашид 1,673.5 Гкал/цаг буюу 66.4 хувиар нэмэгдэх хүлээлттэй байна.

⁶⁸ Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор баталсан.

⁶⁹ 5.1.20. дулаан дамжуулах 200 мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлэх;

2.89 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төвлөрсөн дулаан хангамжийн системийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, үр ашгийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах зорилгоор дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- АХБ-ны зээлээр хэрэгжсэн Эрчим хүчний хэмнэлтийн (1997.08.11) төсөл;
- АХБ-ны зээлээр хэрэгжсэн Дулааны үр ашгийг нэмэгдүүлэх (1997.12.09) төсөл;
- ЕСБХБ-ны 4.5 сая еврогийн буцалтгүй тусламж, 10.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамж төсөл (УИХ-аас 2020.05.14-ний өдөр соёрхон баталж, 2020.04.27-ны өдөр Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан, хэрэгжих хугацаа 2020.04.27-ны өдрөөс 2025.12.31-ний өдрийг хүртэл байсан бол цар тахлын улмаас хугацааг 2026.12.31-ний өдрийг хүртэл сунгасан);
- Дэлхийн банкны 29.9 сая зээлжих тусгай эрх, 10.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл (УИХ-аас 2019.09.12-ны өдөр соёрхон баталж, 2020.01.10-ны өдөр EBRD-49511 дугаар зээлийн хэлэлцээр байгуулсан).


Эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар:

2.90 Засгийн газрын шийдвэрээр төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор АДС-ын төслийг 2022-2025 онд хэрэгжүүлж, хүчин чадлыг 100 Гкал/цагаар нэмэгдүүлж, суурилагдсан хүчин чадлыг 400 Гкал/цаг болжээ.

2.91 ЭХЯ дээрх төслийг 2022 онд баталсан ТЭЗҮ-ийн хүрээнд зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гүйцэтгүүлэхээр 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр ЭХЯ/2022001 дугаартай тендер шалгаруулалтыг зохион байгуулж, Хунан индустриал экүипмент инсталейшн ХХК шалгарч, 65.7 тэрбум төгрөгийн ЭХА-024/2022 дугаартай гэрээг 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдөр байгуулж, барилга байгууламжийг Улсын комиссын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 07/2025 дугаартай дүгнэлтээр хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.

2.92 Дээрх төслийг Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм Лизинг ХХК санхүүжүүлсэн бөгөөд 2026 оны 10 дугаар сарын 28-ны өдөр ЭХЗХ, ДҮТ ТӨХХК, УБДС ТӨХК нарын хооронд Санхүүгийн түрээсийн гэрээг байгуулсан нь зээлийн эргэн төлөлтийг тогтвортой байлгах, санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилготой бөгөөд ЭХЗХ-ны 2022 оны 444 дүгээр тогтоолоор АДС ТӨХК-ийн УБДС ТӨХК-д худалдах дулааны тарифын шинэчлэн баталсан нь зээлийн баталгаа болсон байна.

График 7. АДС-ын ДЭХ-ний үйлдвэрлэл, өртөг, борлуулалтын судалгаа



Эх сурвалж: АДС ТӨХК-ийн 2020-2025 оны санхүүгийн тайлан

2.93 Дулаан хангамжийн эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтээс харахад:

Цэцэрлэгт хүрээлэн 1 хийн дулааны станцын төсөл:

- Төслийг 4 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөж, Салбарын сайдын 2023 оны А/181 дүгээр тушаалаар 4 байршилд газрын асуудал шийдвэрлэх ажлын хэсэг байгуулсан ч үр дүн гараагүй. Харин 2025 оны 8 дугаар сард НЗД-ын А/1215 дугаартай захирамжаар 40,198 м.кв газрыг дэд бүтцийн зориулалтаар

15 жилийн хугацаатай УБДС ТӨХК-д эзэмшүүлсэн байна. Үүний дараа ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЭХЯ-ны ТНБД-ын 2025 оны А/128 дугаар тушаалаар дахин ажлын хэсэг байгуулж, ажлыг хэсгээс төслийн цахилгаан хангамжийн График төслийг дахин боловсруулах 2025/26-62 ажлын даалгаврыг баталсан байна.

- ЭХЯ-аас 2024 онд тендер зарлаж, 1 оролцогч санал ирүүлснийг шалгаруулан, 2024.11.04-ний өдөр УТ24030000752 дугаартай гэрээг “ДИ АР-АИ ЗИ ГРУПП” ХХК-тай байгуулсан боловч төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө газрын байршлыг шийдвэрлээгүй, зураг төслийг эцэслэн боловсруулж, магадлал хийлгээгүйгээс төсөл хэрэгжээгүй, гүйцэтгэгч ажлыг өөрчлөлттэй уялдуулан гэрээний үнийг 18.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх санал ирүүлсэн.
- ЭХҮТ ТӨХК-өөс 2026 оны 1 дүгээр сард гүйцэтгэгч компанид 1/95 дугаар албан бичгээр байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан төслийг дахин боловсруулж, баталгаажуулах, гэрээний хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэх талаар мэдэгджээ.
- Гүйцэтгэгч хариу арга хэмжээ аваагүй үндэслэлээр ЭХЯ-ны 2026.04.09-ний өдрийн в/1276 дугаар албан бичгээр хууль биелүүлээгүй, гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон талаар болон дахин тендер шалгаруулалт зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах талаар мэдэгдсэн байна.
- Гүйцэтгэгчээр шалгаруулсан “ДИ АР-АИ ЗИ ГРУПП” ХХК нь эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авч байгаагүй байна.

ДЦС-3 ТӨХК-ийн 300 МВт-ын өргөтгөл, шинэчлэлийн төсөл:

- УИХ-аас МУЗГ, ОХУ-ын Засгийн газар хоорондын “...станцын өргөтгөл, шинэчлэлтийн төсөл боловсруулах тухай хэлэлцээр”-ийг 2024.12.26-ны өдөр соёрхон баталсан. Уг санамж бичгийн 4.2 дах хэсэгт⁷⁰ зааснаар зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглосон тул аудитын баг уг мэдээллийг хүлээн аваагүй бөгөөд аудитад ашиглаагүй болно.
- Төслийг 2 үе шаттай хэрэгжүүлж, эхний шатанд хүчин чадлыг нэмэх, 2 дугаар шатанд хуучныг буулгаж, шинэ станц барих ажлыг Интер РАО экспорт компанитай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
- Төсөл боловсруулах гэрээний үнэ 20.0 сая ам.доллар бөгөөд үүнээс 27.3 тэрбум төгрөгийг 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан, төсвийн тодотголоор хасагдсан.

ДЦС-4 ТӨХК-ийн уурын хүчин чадлыг 500 тн/ц-аар нэмэгдүүлэх төсөл:

- Өвлийн улиралд үүсдэг уурын дутагдлыг нөхөх, станцыг суурилагдсан хүчин чадлаар нь ажиллуулах, суурилагдсан хүчин чадлыг 150 Гкал/цагаар нэмэгдүүлэх зорилготой уг төслийг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-д тусгаж, УИХ-ын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд бусад эх үүсвэрээр санхүүжүүлж хэрэгжүүлэхээр тусгасан.
- ДЦС-4 ТӨХК-ийн МУХБ-нд төлөх “ТА №1-4-ийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн эргэн төлөлт хүндэрсэнтэй холбогдуулан өрийн хэмжээ зээлжих чадварыг сулруулж, Олон Улсын донор байгууллагын хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжгүйд хүрч төслийн санхүүжилт шийдэгдээгүй.
- Төслийн ТЭЗҮ-г Ричвелл инженеринг ХХК, БСД эрчим хүчний хэмнэлт ХХК хамтран хийсэн. Тус ТЭЗҮ-гээр нийт өртөг 90.4 сая ам.доллар, хэрэгжих хугацаа 1.5 жил, хэрэгжүүлэх хугацаанд сар бүр 1 зуухыг нэмж ажилд оруулснаар жилд 650.0 сая кВт/ц цахилгаан эрчим хүч, 350.0 мянган Гкал ДЭХ-ийг сүлжээнд нийлүүлэхээр тооцсон.

Дулааны тавдугаар цахилгаан станц төсөл:

- Төсөл хэрэгжсэнээр 300МВт цахилгаан, 340 Гкал ДЭХ үйлдвэрлэх хүчин чадалтайгаар ажиллаж, жилд төвийн системд 2.2 тэрбум кВт/ц цахилгаан, 1.1 сая Гкал ДЭХ нийлүүлнэ.
- Төслийг ДЦС-2, ДЦС-4-ийн дунд байрлах үнсэн сангийн талбайд барьж, Улаанбаатар хотын баруун хэсгийн 40 мянган айл өрхийг дулаанаар хангана, нийт өртөг 658.6 сая ам.доллар, өртгийн 80.0 хувийг хэвийн хэвшил, 20.0 хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.
- НИТХ-ын 2025.02.26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” ОНӨААТҮГ-ыг (цаашид ДЦС-5 ОНӨААТҮГ гэх) байгуулж, 2025.05.26-ны өдрийн 25/84 дүгээр тогтоолоор төслийг ТХХТ-ээр хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.
- Төслийн тендерийг зарлаж, 2025.08.06-ны өдөр 2 оролцогч санал ирүүлснийг үнэлж, 2025.08.27-ны өдөр оролцогчдод мэдэгдэж, НЗД-ын 2025.08.29-ний өдрийн А/1223 захирамжаар хэлэлцээр хийх ажлыг хэсгийг байгуулж, 2025.11.13-ны өдөр 01/121 дугаартай гэрээг Митайн интернэйшнл ХХК-тай төслийг ТХХТ-ээр “График төсөл, төсөв боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр байгуулсан.
- НИТХ-ын 2025.12.26-ны өдрийн 25/154 дүгээр тогтоолоор ДЦС-5 ОНӨААТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулж, төслийн барилгын үе шатны ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг нэмж, 2026.01.15-ны өдрийн НЗД-ын “Түншлэлийн төсөлд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх тухай” А/40 дүгээр захирамжийг баталсан.
- Төслийн хүрээнд станцын барилга барих талбайг 26.4 га, үнсэн сангийн талбайг 39.0 га байхаар тооцож, нийт 65.4 га талбайг ашиглуулахаар гэрээнд зааж, НЗД-ын 2025.04.09-ний өдрийн А/457 дугаар захирамжаар 10.2 га газрыг 60 жилийн хугацаатай эзэмшүүлэх, 2025.11.05-ны өдрийн А/1547

⁷⁰МУЗГ, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан санамж бичгийн 4 дүгээр бүлэг (Мэдээлэл ашиглах)-ийн 4.2 дахь хэсэгт “Санамж бичгийн хүрээнд олж авсан мэдээллийг талууд нууцлах үүрэгтэй. Энэ нь нээлттэй эх үүсвэрээс авсан мэдээлэлд хамаарахгүй. Санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно” гэж заасан.

дугаар захирамжаар үнсэн сангийн зориулалтаар 39.0 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрхийг тус тус олгосон.

- Мөн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ДЦС-2 ТӨХК-ийн ТУЗ-ийн 2026.04.24-ний өдрийн 12 дугаар тогтоолоор үнсэн сангийн далангийн 5.1 га газрыг нийслэлд шилжүүлж, ДЦС барих зориулалтаар ашиглахыг дэмжсэн.
- Станц барихад шаардлагатай гэх үлдэх 11.1 га газрын талаар шийдвэр гараагүй.
- Түншилэлийн гэрээний хугацаа 27.5 жил ба 2.5 жилд барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, үлдсэн 25 жилд ашиглах бөгөөд БУА-ыг 2025 оны 11 дүгээр сард эхэлж, 2028 оны 5 дугаар сард дуусгаахаар төлөвлөсөн.
- Төслийн хүрээнд гадаадын 1600 хүртэлх инженер, техникийн ажилтныг татан оролцуулж, тэдгээрийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх эрхийг МУЗГ-ын 2026 оны 68 дугаар тогтоолоор ДЦС-5 ОНӨААТҮГ-т олгожээ. Энэ квотыг тусгай зориулалтын компанид шилжүүлэх зорилгоор НЗДТГ-аас 2026.04.21-ний өдрийн 03/2445 дугаар албан бичгээр ЭХЯ-нд хандаж, ЭХЯ-аас 2026.04.23-ны өдрийн 6/1581 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хамтран ажиллах санал хүргүүлсэн.
- Митайн интернэйшнл ХХК эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл аваагүй байна.

2.94 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч нэгдсэн бодлогоор төлөвлөөгүй, эрэмбэ дарааллаар төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаагүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулж байгаа нь холбогдох байгууллагуудын тухайн үеийн удирдах албан тушаалтны ашиг сонирхол нөлөөлсөн байх магадлалтай байна.

2.95 Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж, шат дараалалтайгаар хэрэгжүүлэх талаар сэдэл санаачилгагүй ажиллаж, ажил хийсэн нэр хүлээн ажлын даалгавар баталж, өндөр үнээр дахин дахин ТЭЗҮ, График төсөл хийлгэж байгаа нь хийгдсэн хөрөнгө оруулалт үр нөлөөгүй байх, хүчин чадлын дутагдал хэвээр байх нөхцөл болж, дулаан хангамжийн системийн тогтвортой, найдвартай байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

2.96 Эрчим хүчний эх үүсвэр нэмэх чиглэлээр хийсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх явцад эрчим хүчний салбарт ажиглагдсан сайн туршлагыг нийтэд мэдээлэх, энэ нь хувийн хэвшлийн санаачилгаар хэрэгжиж, үр дүнгээ үзүүлж байгааг тэмдэглэж, мэдээлэл болгон аудитын тайланд тусгалаа. Үүнд:

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.2 дахь хэсэгт “Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд төрийн болон хувийн секторт тодорхой арга хэмжээг бодитой хэрэгжүүлж, сайн туршлага бий болгожээ. Үүнд:

АДС-ын сайн туршлага:

- М-СИ-ЭС Кока-Кола ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд усыг зохистой ашиглах, усны бохирдлыг бууруулах зорилгоор цэвэршүүлсэн хаягдал усыг АДС-д нийлүүлэх, үүнтэй холбоотой шугам хоолой, ус нөөцлөх, шүүх төхөөрөмжүүдийг өөрийн 3,508.1 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлэх хандивын гэрээг 2025 онд байгуулан ажлыг гүйцэтгэж, тус станцад 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 05 дугаар актаар хүлээлгэн өгсөн байна. Түүнчлэн хандивласан төхөөрөмжүүдэд ашиглах засвар үйлчилгээнд зориулж 350.8 сая төгрөгийг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор АДС-д олгохоор гэрээнд заасан байна.

ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК:

- МУЗГ, АНУ хооронд Мянганы сорилын компакт гэрээг 2018 оны 7 дугаар сарын 27-нд байгуулж УИХ-аар 2019 оны 01 дүгээр сарын 03-нд соёрхон баталж, “Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх компакт хөтөлбөр” хэрэгжиж, 2026 оны 3 дугаар сард албан ёсоор хэрэгжиж дууссан байна. Уг гэрээний хүрээнд үйлдвэрийн хаягдал усыг дахин боловсруулж ДЦС-3, ДЦС-4-ийн үйл ажиллагаанд нийлүүлж байна.
- ДЦС-3 ТӨХК-ийн туршлага: ДЦС-3 нь жилд 5-6 сая м.куб ус хэрэглэдгээс 3–3.5 сая м.куб³-ыг дахин боловсруулсан усаар хангах боломж бүрдсэн бөгөөд энэ нь нийт хэрэгцээний ойролцоогоор 50.0–70.0 хувьтай тэнцэнэ. Харин ДЦС-4 ТӨХК нь жилд 8 сая м.куб ус хэрэглэдэг ба бүх хэрэглээг дахин ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. Ингэж дахин боловсруулсан усны хэрэглээг нэмэгдүүлсэн нь гүний усны ашиглалтыг бууруулж, усны нөөцийг хамгаалах чухал гарц болж байна.

Төвлөрсөн дулаан хангамжийн шугам хоолойг өргөтгөх чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар:

2.97 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойг шинээр барих, шинэчлэн өргөтгөх чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтын

ажлын гүйцэтгэлийг жишээ болгон санхүүжилтийн эх үүсвэрээр харуулбал дараах байдалтай байна. Тухайлбал,

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр:

- Дэлхийн банк болон ЕСБХБ-ны зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийг хотын өсөн нэмэгдэж буй дулааны эрэлт хэрэгцээг хангах, шинээр баригдаж буй орон сууцны хороолол болон нийгмийн барилга байгууламжийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, хуучирсан инженерийн шугам сүлжээг шинэчлэх чиглэлээр хэрэгжүүлж, 34 байршилд 182.3 тэрбум төгрөгийн 24.1 км шугам хоолойн өргөтгөл, шинэчлэл хийж, дулаан шугамын нэвтрүүлэх чадварыг 1,874.2 Гкал-аар нэмэгдүүлсэн.
- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслөөр хийгдсэн шугамд 245 хэрэглэгчийг дулаан хангамжид шинээр холбосон;
- ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамж төслөөр хийгдсэн шугамд 327 хэрэглэгчийг дулаан хангамжид шинээр холбосон;
- Зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулсан дулааны шугам сүлжээний хөрөнгөд зээлийн хүү, шимтгэлийг тооцон капиталжуулж, ТӨБЗГ-ын шийдвэрээр УБДС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд шилжүүлсэн байна.

АНУ-ын Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр хэрэгжсэн Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд 9Б магистраль шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд:

- Төслийн хүрээнд “Цэвэрлэх салаа ДХ935–ДХ935-9 хүртэлх 2Ф300 мм голчтой, 745 хос метр шугамыг 2Ф400/500 мм болгон өргөтгөөн шинэчлэх ажил”-ын төсөвт өртгийг 3,176.2 сая төгрөгөөр ЭХХТ (хуучин нэрээр) 2021 онд 411/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан боловч тухайн үеийн тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болж, 2024 онд үлдэх ажлын 4,585.8 сая төгрөгийн төсөвт өртгийг 634/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, 2025 онд нэгтгэн 8,663.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр ХАА-г зохион байгуулж, ЧММ ХХК-тай 8,315.7 сая төгрөгийн гэрээ байгуулж, улсын комиссын 2025 оны 39/2025 дугаартай актаар ашиглалтад оруулсан байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар:

- 2020-2026 онд нийт 38.4 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс 25 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 34.1 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 25 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хэрэгжиж байна.
- Үргэлжлэн хэрэгжиж буй төслийн гүйцэтгэгчээр ажиллаж буй Эм Би Би Си ХХК-ийн эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл 2015.10.06-ны өдрөөр, Си Эйч Си И Кей ХХК-ийнх 2018.06.24-ний өдрөөр, Өрнөх гэгээ ХХК-ийнх 2018.08.18-ны өдрөөр тус тус дуусгавар болсон, харин Эхлэл шинэчлэлт прожект ХХК, Магма-Од ХХК, Илч-Орд ХХК-ууд тусгай зөвшөөрөл аваагүй байна.
- Си Эйч Си И Кей ХХК 2019 онд, Эхлэл шинэчлэлт прожект ХХК 2020 онд гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан боловч ажлаа бүрэн дуусгаагүй, гэрээний хугацааг 9 удаа сунгасан, захиалагч гэрээ цуцлахыг саналыг 2025.12.11-ний өдөр НЗДТГ-т хүргүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- 2020-2025 онд нийт 390.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээг хуульд батлуулснаас 3 нь эс үүсвэр нэмэхтэй холбоотой, 15 нь шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажил байна. Эдгээр төсөл, арга хэмжээнээс 10-ыг ЭХЯ хэрэгжүүлснээс 7 арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна.
- Монгол Улсын төсвийн тухай 2022 оны хуулиар батлагдаж, НХОГ-аас хэрэгжүүлсэн “Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний барилгажилтын төслийн эхний ээлжийн барилга, байгууламжийн дулаан дамжуулах төв” /Улаанбаатар, Багануур дүүрэг/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Билгүүн од контрактин ХХК болон Хэмжил зүй ХХК-ийн түншлэл шалгарч, 2022.04.04-ний өдөр 4,593.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЭХЯ/202211023/01 дугаартай гэрээ байгуулж, ажлыг 2022-2023 онд гүйцэтгэж, Улсын комисс 2023.12.18-ны өдөр ШС-022/2023 акт үйлдэж, ТӨБЗГ-ын 2024.03.21-ний өдрийн 115 дугаар тогтоолоор БНДС-д шилжүүлэн өгсөн ч төслийн хүрээнд баригдах 2 дугаар контурын түгээх сүлжээний угсралтын ажил хийгдээгүйгээс өнөөг хүртэл ашиглалтгүй байна. Уг ажлыг 2026 оны Төсвийн тухай хуулиар ХББОСС-ын багцад 4,265.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Багануур дүүрэг/ нэрээр баталсныг ХАА-г зохион байгуулж, Сан ХХК-д 2026.04.15-ны өдөр гэрээ байгуулах эрх олгосон байна. Төсөл, арга хэмжээг иж бүрэн, шат дараалан төлөвлөж, хэрэгжүүлээгүйгээс 3 жилийн өмнө оруулсан хөрөнгө оруулалт үр ашгийг бууруулсан ч хариуцлага хүлээх эзэнгүй байна.

Дулаан хангамжийн үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын өөрийн хөрөнгө оруулалтын талаар:

2.98 Төвлөрсөн дулаан хангамжийн үйл ажиллагаанд оролцож буй төрийн өмчийн зарим байгууллагын 2023-2025 оны өөрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төлөөлөл болгон харуулбал, 2025 онд ААНБ-ын өөрийн хөрөнгө оруулалт жил дараалан 21.4-40.3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 44. Төвлөрсөн дулаан хангамжийн үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчит ААНБ-ын 2023-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг

Он	Агуулга	ДЦС-4	ДСЦ-3	ДЦС-2	АДС	УБДС	Нийт
2023	Төлөвлөгөө	36,311.1	20,651.2	3,530.1	2,683.8	7,957.1	71,133.3

	Гүйцэтгэл	34,031.5	18,200.5	2,609.7	2,522.6	7,772.1	65,136.4
	Гүйцэтгэл хувь	93.7	88.1	73.9	94.0	97.7	91.6
	Төлөвлөгөө	53,945.4	31,858.9	3,313.5	1,714.6	8,130.1	98,962.5
2024	Гүйцэтгэл	43,732.6	22,069.8	2,215.2	1,716.6	9,334.9	79,069.1
	Гүйцэтгэл хувь	81.1	69.3	66.9	100.1	114.8	79.9
	Төлөвлөгөө	66,684.0	96,078.4	3,919.6	2,487.0	12,119.8	181,288.8
2025	Гүйцэтгэл	55,311.7	38,264.8	3,503.1	2,417.0	11,437.3	110,933.9
	Гүйцэтгэл хувь	82.9	39.8	89.4	97.2	94.4	61.2

Эх сурвалж: ЭХЯ

2.99 Өөрийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь үндсэн тоноглол, шугам хоолой хуучирч зайлшгүй засвар, сайжруулалт шаардах болсонтой холбоотой байна.

2.100 Төвлөрсөн дулаан хангамжид төрөл бүрийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийгдэж байгаа ч хөрөнгө оруулалтыг нэгдсэн журмаар үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлээгүй, зөвхөн тухайн үед үүссэн асуудлыг зохицуулах байдлаар шийдвэрлэж ирснээс системийн хэмжээнд техник, технологийн хоцрогдолд орсон байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хэрэглэгчдийн 1.7 хувь нь хэрэглээнд суурилсан төлбөрийн тогтолцоонд шилжсэн байна

2.101 Төвлөрсөн дулаан хангамжийн системд хэрэглээнд суурилсан төлбөр, тооцооны зохицуулалтыг бий болгох хүрээнд дараах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллажээ. Үүнд:

- Барилга байгууламжийн дулааны бодит хэрэглээнд суурилсан төлбөр тооцооны системд халаалтын зардал хуваарилагч хэрэгсэл (аллокатор)-ыг судлан дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг (ЭХЗХ-ны 2021 оны А/29 дүгээр тушаал);
- Дулааны төлбөр тооцоог хэрэглээнд суурилсан тогтолцоонд шилжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, барилгын норм, дүрэм болон дулаан ашиглах журам, холболтын зохицуулалт, аж ахуйн харилцааны холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг (ЭХЗХ-ны 2025 оны А/04 дүгээр тушаал).

2.102 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн нийт 343.3 мянган хэрэглэгчийн зөвхөн 5.9 мянга буюу 1.7 хувь нь дулааны тоолууртай ба үүнээс айл өрхийн хэрэглэгч 1.2 мянга буюу 0.4 хувийг эзэлж байна

Хүснэгт 45. ДЭХ хэрэглэгчдийн тоолууржуулалтын мэдээлэл, 2025 оны байдлаар


Ангилал	ААНБ		Айл өрх		Нийт	
	Тоо (мянга)	Дүнд эзлэх хувь	Тоо (мянга)	Дүнд эзлэх хувь	Тоо (мянга)	Дүнд эзлэх хувь
Нийт хэрэглэгчийн тоо	21.7	100.0	321.6	100.0	343.3	100.0
Тоолууртай хэрэглэгч	4.7	21.7	1.2	0.4	5.9	1.7
Тоолуургүй хэрэглэгч	17	78.3	320.4	99.6	337.4	98.3
Тоолуургүй хэрэглэгчийн тоолуур суурилуулах боломжит судалгаа						
Тоолуур шууд суурилуулах	8.9	52.4	22.4	7.0	31.3	9.3
Нэмэлт өргөтгөл хийж тоолуур суурилуулах			148.9	46.5	148.9	44.1
Аллокатор суурилуулах	8.1	47.6	79.9	24.9	88	26.1
Тоолуур суурилуулах боломжгүй (1 хоолойтой)			69.2	21.6	69.2	20.5

Эх үүсвэр: ЭХЗХ-ны 2025 оны А/04 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсгийн судалгааны үр дүн

2.103 ЭХЗХ-ны 2025 оны А/04 дүгээр тушаалаар байгуулагдаж, ажилласан ажлын хэсгийн тайлангаар дулааны тоолуур суурилуулах техникийн боломжтой айл өрхүүдийг бүрэн тоолууржуулахад 288.5 тэрбум төгрөг, халаалтын зардал хуваарилах хэрэгсэл суурилуулахад 55.2 тэрбум төгрөг, барилга байгууламжид ерөнхий тоолуур суурилуулахад 10.1 тэрбум төгрөг, нийтдээ 353.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах тооцоог гаргасан байна.

2.104 ДЭХ-ний борлуулалтын дундаж үнэ 2025 онд бодит өртгөөс 27,718.2 төгрөг буюу 43.1 хувиар бага түвшинд байгаа нь салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд санхүү, эдийн засгийн дарамт болж, техник, тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлийн хөрөнгө оруулалтыг хойшлуулах, улмаар дулаан хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааны зарчим алдагдах нөхцөлийг бүрдүүлэх шалтгааны нэг болж байна.

График 8. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн ДЭХ-ний бодит өртөг, борлуулсан дундаж үнийн харьцуулалт, 2025 он



Эх сурвалж: ЭХЗХ, Төвлөрсөн дулаан хангамжийн ТЗЭ-дийн санхүүгийн тайлан

2.105 Хэрэглээнд суурилсан зохицуулалтад шилжихэд шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлаар Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг, ЕСБХБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын донор байгууллагатай хамтран ажиллах үндэс тавигдсан хэдий ч салбарын байгууллагуудын төлбөрийн чадамжаас шалтгаалан зээлжих зэрэглэл буурах, зээлийн эргэн төлөх чадвар хангалтгүй гэж үнэлэгдэх эрсдэлтэй байгаагаас хөрөнгө оруулалт татаж чадаагүй байна.

2.106 Дулаан эрчим хүчний хэрэглээнд суурилсан төлбөрийн тогтолцоонд шилжих нь НҮБ-ын ТХЗ-ын 7.3 дахь зорилт эрчим хүчний үр ашгийг сайжруулах, хэмнэлттэй, зохистой ашиглах үндсэн зорилттой нийцэж байна. Гэсэн хэдий ч энэхүү тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тодорхойгүй байдал нь хэрэгжилтийг удаашруулах хүчин зүйл болж байна.

2.107 Иймд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1⁷¹ Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13⁷² зааснаар ЭХЯ холбогдох төрийн өмчит байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэглээнд суурилсан төлбөрийн тогтолцоонд шилжихэд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлаар санал боловсруулж, дэмжлэг үзүүлж, зохион байгуулах шаардлагатай байна.

Эрчим хүч хэмнэх үүрэг хүлээсэн хэрэглэгчид үүргээ биелүүлж, хэмнэлт гаргасан байна

2.108 Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1⁷³-д зааснаар МУЗГ нь эрчим хүчний хэмнэлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, 6 дугаар зүйлийн 6.1.3⁷⁴-д зааснаар ЭХЯ нь эрчим хүчний хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, түүний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн үр дүнг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд тогтмол хүргүүлэх, 8 дугаар зүйлийн 8.1⁷⁵-д зааснаар ЭХЗХ нь эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээжээ.

2.109 Засгийн газрын 2023 оны 67 дугаар тогтоолоор Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгч⁷⁶-ийн жилийн хэрэглээний босго хэмжээг шинэчлэн баталсан байна.

2.110 ЭХЗХ үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 2024 оны хэрэглээний мэдээлэлд үндэслэн тус хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 482 дугаар тогтоолоор хэрэглэгчдийн

⁷¹ Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна.

⁷² Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

⁷³ Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

⁷⁴ Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.

⁷⁵ Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

⁷⁶ Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 3.1.8-д "Үүрэг хүлээсэн хэрэглэгч" гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон.

бүртгэлд өөрчлөлт оруулж, нийт 226 хэрэглэгчид үүрэг хүлээлгэсэн байна. Эдгээр хэрэглэгчид нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна⁷⁷.

Хүснэгт 46. Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн мэдээлэл

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн бүртгэл		2020	2021	2022	2023	2024	2025
1. Барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн хуулийн этгээд:	1.1 Төрийн, орон нутгийн төсөвт байгууллага, хуулийн этгээд	64	57	47	13	2	2
	1.2 Худалдаа, оффис	33	25	27	47	18	21
	1.3 Үйлчилгээ	-	-	-	5	5	4
	Дүн	97	82	74	65	25	27
2. Эрчим хүч хэрэглэгч иргэн, хуулийн этгээд:	2.1 Уул уурхай	26	25	25	31	41	38
	2.2 хүнд үйлдвэр	16	15	15	31	20	14
	2.3 Дунд/хүнсний үйлдвэр	0	19	19	46	43	44
	2.4 Хөнгөн үйлдвэр	38	16	16	42	37	39
	2.5 Мэдээлэл, холбоо	0	0	0	6	6	5
	2.6 Бусад	15	14	14	16	28	17
	Дүн	95	89	89	172	175	157
3. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд:	3.1 Эрчим хүч үйлдвэрлэгч	11	11	11	25	9	25
	3.2 Эрчим хүч дамжуулагч	3	3	3	3	3	3
	3.3 Эрчим хүч түгээгч, хангагч	20	20	20	14	14	14
	Дүн	34	34	34	42	26	42
Нийт ҮХХ-ийн тоо		226	205	197	279	226	226

Эх сурвалж: ЭХЗХ

2.111 Үүрэг хүлээсэн хэрэглэгчид эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол тайлагнах, мөн эрчим хүчний аудит хийлгэж, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг.

2.112 ЭХЗХ-ны мэдээллээр 2020-2025 онд үүрэг хүлээсэн хэрэглэгчид 5,703 арга хэмжээ хэрэгжүүлэхэд 324.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 175.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 247.3 мянган.Гкал ДЭХ хэмнэсэн гэжээ.

Хүснэгт 47. Эрчим хүч хэмнэх үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хөрөнгө оруулалтын судалгаа

Он	ҮХХ-ийн тоо	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Зарцуулсан хөрөнгө оруулалт (сая төг)	Эрчим хүчний хэмнэлт		Хэмнэсэн мөнгөн дүн (сая төг)	CO2 бууралт (мян.тн)
				ЦЭХ (сая кВт.ц)	ДЭХ (мян.Гкал)		
2020	226	925	41,657.7	69.5	1.4	11,984.0	78.1
2021	205	1,075	44,582.3	38.4	28.2	27,797.8	67.6
2022	197	947	39,530.4	18.7	41.3	10,829.0	31.0
2023	279	768	61,011.7	16.9	60.8	4,422.9	37.3
2024	226	990	85,761.0	19.5	57.4	5,365.6	38.0
2025	226	998	51,864.6	12.6	58.2	7,720.4	33.1
Нийт	1,359	5,703	324,407.7	175.6	247.3	68,119.7	285.1

Эх сурвалж: ЭХЗХ

Эрчим хүчний зөв зохистой хэрэглээг сурталчлах ажил хийж байгаа ч үр нөлөөг тооцож, бүртгэж чадахгүй байна

2.113 Салбарын сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалаар Эрчим хүчний зөв зохистой хэрэглэх сурталчлах замаар эрчим хүчний хэрэглээг бууруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, мөн сайдын А/119 дүгээр тушаалаар 2023-2026 оны өвлийн их ачааллын үеийн эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэрэгцээг удирдах хөтөлбөрийн боловсруулж, төлөвлөгөөг баталжээ.

2.114 Төлөвлөгөөний хүрээнд Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллыг бууруулахад чиглэсэн сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх, Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулахад чиглэсэн сургалт, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах, үр дүн тооцох, тайлагнах, урамшуулах ажлыг зохион

⁷⁷ Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчид нь Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 3-р хавсралт -д заасан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.9⁷⁷-д заасны дагуу эрчим хүчний зохистой, үр ашигтай хэрэглээг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй.

байгуулах арга хэмжээг хэрэгжүүлж, 2025 оны байдлаар 88.7 хувийн биелэлттэйгээр тайлагнажээ.

Хүснэгт 48. Эрчим хүчний хэрэглээг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

Арга хэмжээ	2023		2024		2025	
	Арга хэмжээ-ний тоо	Хэрэгжил-тийн хувь	Арга хэмжээ-ний тоо	Хэрэгжил-тийн хувь	Арга хэмжээ-ний тоо	Хэрэгжил-тийн хувь
Зорилт 1 ⁷⁸ :	7	68.6	16	48.0	16	79.0
Зорилт 2 ⁷⁹ :	6	73.3	31	87.0	31	91.0
Зорилт 3 ⁸⁰ :	3	68.3	30	89.0	30	96.0
Биелэлтийн дундаж хувь		70.1	-	74.7	-	88.7

Эх сурвалж: ЭХЗХ

2.115 Төлөвлөгөөнд суурь болон зорилтот түвшнийг тодорхойлоогүй нь бодит үр нөлөөг тоон болон чанарын үзүүлэлтээр үнэлэх боломжийг хязгаарлаж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нийгмийн хэсэг, бүлгийг оновчтой сонгож үйл ажиллагаа явуулсан эсэх, эрчим хүч хэмнэсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

Дулаан хангамжийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид санхүүгийн хүндрэлд орж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байна

2.116 ДЭХ-ний салбарт үйл ажиллагаа явуулж буй 101 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 40.6 хувь нь санхүүгийн хүндрэлд орж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болох бодит эрсдэлтэй байна. Тухайлбал,

- ДЦС-3,4, АДС-ийн хувьд үндсэн хөрөнгийн ачаалал болон нийт хөрөнгийн ачаалал нь зохистой түвшнээс доогуур байгаа нь технологийн хоцрогдол, тоног төхөөрөмжийн зогсолт, засвар үйлчилгээний үр ашиггүй байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан байх боломжтой бөгөөд энэ нь хөрөнгийн ашиглалтыг бууруулж, зардлыг нэмэгдүүлдэг. Улмаар орлогын түвшин хангалтгүй үед тогтмол зардлын дарамт нэмэгдэж, байгууллагуудын санхүүгийн үр ашиг доройтох, мөнгөн гүйлгээний хүндрэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) болон эздийн өмчийн өгөөж (ROE) 3.0 хувиас бага эсвэл сөрөг байгаа нь хөрөнгө оруулалт татах боломжийг хааж байна. Мөн төлбөрийн чадвар ба өр төлбөрийн хувьд 2022 оноос эхлэн эргэлтийн хөрөнгө болон түргэн хөрвөх чадварын харьцаа 1-ээс бага болсон нь богино хугацаат өрөө барагдуулах чадваргүй байгаа, харин мөнгөн хөрөнгийн дутагдал болж банкны зээлээс хамааралтай болох эрсдэлтэй байна. Тухайлбал, ДЦС-4-ийн нийт хөрөнгийн 46.9 хувь нь өр төлбөрөөс бүрдэж байна. Үйлдвэрлэлийн өртөг (түлш, засвар, цалин) өндөр боловч тариф нь өртгөө нөхдөггүй тул үйл ажиллагааны ашгийн хувь 2.0 хувиас бага буюу зарим аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж байна.
- Төвлөрсөн дулаан түгээх, хангах байгууллагуудын 90 гаруй хувь нь хөрөнгөө идэвхтэй ашиглаж байна. Хөрөнгийн ачаалал өндөр байх нь байгууллагуудын хөрөнгийн нөөц хангалтгүй, хүчин чадлаа дээд хэмжээнд ашиглаж байгаа, цаашид ачаалал нэмэгдвэл засвар үйлчилгээний ачаалал өсөх, тоног төхөөрөмжийн элэгдэл түргэсэх, тасалдал гарах эрсдэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Мөн эдгээр байгууллагуудын 84.7 хувь нь түргэн хөрвөх чадваргүй, мөнгөн гүйлгээний байнгын хомсдолтой, 32.2 хувь нь 40-өөс дээш хувийн өрийн хамааралтай байгаа бөгөөд 64.4 хувь нь цэвэр алдагдалтай ажиллаж байгаа нь үнэ тариф нь бодит өртгийг нөхөж чадахгүйд хүргэж өөрийн хөрөнгийн өсөлтийг сааруулж байна.
- Хэсэгчилсэн дулаан хангамжийн байгууллагуудын хэрэглэгч бага, хүчин чадлын ашиглалт жигд бус байдал нь нэгж үйлчилгээний өртөг өндөр гарахад нөлөөлдөг байна. Энэ нь нийт байгууллагын 45.0 хувь нь өрийн дарамттай (40.0 хувиас дээш), 30 хувь нь үйл ажиллагааны алдагдалтай байхад нөлөөлж байна. Мөнгөн урсгалын тэнцвэр алдагдсан нь нийлүүлэгчдийн өглөг хуримтлагдах эрсдэлтэйг харуулж байна.

⁷⁸Эрчим хүч хэмнэлтийн бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчныг сайжруулах, урамшуулал, хөшүүрэг би болгох хүрээнд;

⁷⁹Нэгдсэн сүлжээний өвлийн оргил ачааллын үеийн цахилгаан эрчим хүчний ачааллыг бууруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд;

⁸⁰Хэрэглэгч, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх хүрээнд;

БҮЛЭГ 3. НИЙСЛЭЛИЙН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИД ХОЛБОГДООГҮЙ АЙЛ ӨРХИЙН ГЭР, БАЙШИНГИЙН ДУЛААЛГА ХИЙХ, САЙЖРУУЛСАН ТҮЛШ ҮЙЛДВЭРЛЭХ, НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХАД 2.1 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛСАН Ч ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНГ ҮЗҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Оршил

Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргийн хувьд тухайн бүс нутгийн дулааны станц, уурын зуухны үйлдвэрлэсэн дулааныг Багануур-Ус ОНӨААТҮГ, Чандмань налайх ОНӨААТҮГ, Илч орд ОНӨААТҮГ-аар дулаан түгээж байгаа боловч үйл ажиллагаа нь суурин газрын нийт хэрэглээний 50-аас дээш хувийг дулаанаар хангаагүй тул хэсэгчилсэн дулаан хангамжид хамрууллаа.

Багануур, Налайх дүүрэг дулаан хангамжийн чадлын дутагдалд орж, үндсэн тоноглолууд хуучирсан байна

Багануур дүүргийн дулааны станцын талаар

3.1 БНДС ТӨХК нь 9 зуух, сүлжээний 6 насос, хөөхийн 2 насостой боломжит дээд чадлаар 170 Гкал/цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай боловч 4 болон 9 дүгээр зуухны тоноглолыг хагас кокс үйлдвэрлэхээр өөрчилж, үйл ажиллагааг зогсоосноор 130 Гкал/цагийн хүчин чадалтай үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 49. БНДС-ын үндсэн тоног төхөөрөмжийн хүчин чадал, насжилтын судалгаа

№	Үндсэн тоноглол	Марк	Тоо	Хүчин чадал	Ашигт үйлийн коэффициент (хувь)	Ашиглалтад орсон огноо	Насжилт
1	Зуух №3	НТБҮШ-10	1	10 Гкал	58-69	2009	17
2	Зуух №4	БҮШ-20	1	20 Гкал	63-69.1	1980	46
3	Зуух №5	НТБҮШ-20	1	20 Гкал	78-82	1980	46
4	Зуух №6	БҮШ-20	1	20 Гкал	63-74.4	1980	46
5	Зуух №7	НТБҮШ-20	1	20 Гкал	61-81.1	1981	45
6	Зуух №8	НТБҮШ-20	1	20 Гкал	57-75.7	1983	43
7	Зуух №9	БҮШ-20	1	20 Гкал	63-69	1983	43
8	Зуух №10	БҮШ-20	1	20 Гкал	72-78.5	1989	37
9	Зуух №11	НТБҮШ-20	1	20 Гкал	71-79	1989	37
Нийт хүчин чадал			9	170 Гкал			
10	Сүлжээний насос №1	Nscr 250-200-660	1	660 м³ 21 ата	85	2015	11
11	Сүлжээний насос №2	Nscr 250-200-660	1	660 м³ 21 ата	85	2015	11
12	Сүлжээний насос №3	Nscr 250-200-660	1	660 м³ 21 ата	85	2015	11
13	Сүлжээний насос №4	Nscr 250-200-660	1	660 м³ 21 ата	85	2015	11
14	Сүлжээний насос №5	ЦН-400-210	1	400 м³ 21 ата	85	1996	30
15	Сүлжээний насос №6	Д-320-70	1	320 м³ 7 ата	80	2009	17
16	Хөөхийн насос №1	ЦН-180-340	1	180 м³ 34 ата	85	1989	37
17	Хөөхийн насос №2	ЦН-180-340	1	180 м³ 34 ата	85	1989	37

Тайлбар: Станцын суурилагдсан хүчин чадал – 130 Гкал (Нийт суурилагдсан хүчин чадал 170 Гкал-аас К-4, К-9 2 зуухны хүчин чадлыг хассан болно)

Эх үүсвэр: Багануур дулааны станц

3.2 Багануур дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо 2025 онд 4,016-д хүрч 2020 оноос 5.0 хувиар, ДЭХ-ний хэрэглээ 8.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 50. Багануур дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025
Төсөвт байгууллага	34	34	34	34	34	32
Үйлдвэр, ААНБ	120	120	121	124	129	137
Айл өрх	3,670	3,679	3,681	3,759	3,773	3,847
Нийт хэрэглэгчийн тоо	3,824	3,833	3,836	3,917	3,936	4,016

Эх сурвалж: БНДС ТӨХК

3.3 БНДС ТӨХК-ийн орлого 2020 онд 5,703.1 сая төгрөг байсан бол 2025 онд 10,680.5 сая төгрөг буюу 1.9 дахин, харин зардал 2.2 дахин өсөж, үйл ажиллагааны алдагдал 4.4 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 51. БНДС ТӨХК-ийн 2020-2025 оны үйл ажиллагааны үр дүн, татаас, өртгийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024	2025
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мянган Гкал	164.4	164.1	174.1	178.5	175.0	178.1

2	Нийт орлого	сая төгрөг	5,703.1	5,731.5	6,220.6	8,289.0	9,399.2	10,680.5
3	Нийт зардал	сая төгрөг	7,409.0	8,354.0	10,215.0	12,541.4	14,174.9	16,054.9
4	Улсын төсвийн татаас	сая төгрөг	1,010.0	1,081.9	1,318.2	2,086.4	6,260.5	2,318.2
5	Үйл ажиллагааны ашиг/ алдагдал	сая төгрөг	(695.9)	(1,540.6)	(2,676.2)	(2,166.0)	1,484.8	(3,056.2)
6	Нийт зардлаас тооцсон өртөг	төгрөг/Гкал	45,059.4	50,908.0	58,673.2	70,260.0	80,999.3	90,145.3
7	Нийт орлогоос тооцсон өртөг	төгрөг/Гкал	34,684.7	34,926.8	35,730.1	46,437.0	53,709.4	59,969.1
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг/Гкал	1.30	1.46	1.64	1.51	1.51	1.50

Эх сурвалж: БНДС ТӨХК

Налайх дүүргийн дулааны станцын талаар

3.4 Налайх дүүргийн дулааны станц 1995 онд ашиглалтад орж, KBTC-20-150 маркийн 3 зуухтай, суурилагдсан хүчин чадал нь 69.8 МВт байхаас 46.2 МВт болж буурсан боловч холбогдсон хэрэглэгчдийн ачаалал 48.6 МВт, харин хүлээгдэж буй хэрэглээ 11.9 МВт байна.

3.5 KBTC-20/150 маркийн 2, 3 дугаар зуухны галын хотол болон конвектив хэсгийн сүлжээний усны нэвтрүүлэх, зарцуулалт 247 тонн/цаг байхаас 130, 160 тонн/цаг болж буурснаар зуухны ашигт үйлийн коэффициент буурч, Ф700-200 мм-ын диаметртэй 2.2 км дулааны төв шугамын 60.0 хувь нь 30-аас дээш жилийн насжилттай ашиглалтын хугацаа дуусжээ.

3.6 НДС ТӨХК нь 2025 онд ДЭХ үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд дүүргийнхээ 38 төсөвт байгууллага, 259 аж ахуйн нэгж байгууллага, 3,119 айл өрх, 120 хувийн сууцанд халаалт болон хэрэгцээний халуун усаар хангах үйл ажиллагаа явуулж байна.

3.7 Налайх дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо 2025 онд 2020 онтой харьцуулахад 17.2 хувиар, ДЭХ-ний хэрэглээ 7.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 52. Налайх дүүргийн ДЭХ хэрэглэгчийн тоо

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025
Төсөвт байгууллага	31	35	37	37	37	38
Үйлдвэр, ААНБ	283	207	239	243	244	259
Айл өрх	2,600	2,840	2,847	2,995	3,079	3,119
Нийт хэрэглэгчийн дүн	2,914	3,082	3,123	3,275	3,360	3,416

Эх сурвалж: НДС ТӨХК

3.8 НДС ТӨХК нь 2020 онд 4.1 тэрбум төгрөг орлоготой байсан бол 2025 онд 8.8 тэрбум төгрөгт хүрч 2.2 дахин нэмэгдэж, харин зардал 5.7 тэрбум төгрөгөөс 11.9 тэрбум төгрөг болж 2.1 дахин нэмэгдснээр алдагдал буурсан боловч төсвөөс авсан татаас 2.7 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 53. НДС ТӨХК-ийн 2020-2025 оны үйл ажиллагааны үр дүн, татаас, өртгийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024	2025
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мянган Гкал	94.9	97.4	97.5	97.8	99.1	101.9
2	Нийт орлого	сая төгрөг	4,057.6	4,003.0	4,250.7	5,295.4	5,583.7	8,826.2
3	Нийт зардал	сая төгрөг	5,687.1	5,848.9	6,316.7	8,201.0	9,574.6	11,884.8
4	Улсын төсвийн татаас	сая төгрөг	1,125.4	1,251.8	1,500.0	2,140.9	4,023.2	3,000.0
5	Үйл ажиллагааны ашиг/ алдагдал	сая төгрөг	(504.1)	(594.0)	(566.1)	(764.7)	25.4	(58.6)
6	Нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг	төгрөг/Гкал	59,243.3	59,513.3	63,775.7	82,410.2	93,444.5	113,668.1
7	Борлуулалтын өртөг	төгрөг/Гкал	39,215.3	39,347.6	42,092.5	51,901.3	53,917.3	82,654.6
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг/Гкал	1.5	1.5	1.5	1.6	1.7	1.4

Эх сурвалж: НДС ТӨХК

3.9 Дээрхээс харахад БНДС ТӨХК, НДС ТӨХК-ийн дулаан үйлдвэрлэл, хэрэглэгчийн тоо тогтмол өсөн нэмэгдэж байгаа боловч үйлдвэрлэсэн ДЭХ-ийг өөрийн өртгөөс доогуур үнээр борлуулж байгаагаас орлого нь зардлаа нөхөхгүй, алдагдлын хэмжээ тогтмол өсөж, зах зээлийн зарчмаар ажиллаж чадахгүйд хүрсэн байна.

3.10 Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор Налайх дүүргийн 1, 2, 3, 4 болон 7 дугаар хороонд шинээр 114 барилга байгууламж барих, 7 дугаар хороонд гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг, 2 дугаар хороонд ашиглалтын шаардлага хангахгүй 33 барилгыг буулган дахин барилгажуулах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

3.11 Дулааны станцыг төлөвлөхдөө дүүргийн дулааны хэрэглээ 2030 онд 185 МВт-д хүрч 138.8 МВт-ын дутагдалд орох тул зайлшгүй шинэ эх үүсвэр шаардлагатай гэж үзэн, 216 МВт-ын эргэлдэх буцлах давхаргад түлш шатаах технологи бүхий 58 МВт (50 Гкал/цаг) чадалтай 3 зуух, 21 МВт (50 Гкал/цаг) чадалтай 2 зуухтай, шинэ эх үүсвэр барихаар төлөвлөж, ТЭЗҮ-ээрх ажлын зургийг Rich Well ХХК 2022 онд боловсруулж, ЭХҮТ магадлал хийж, 2026 онд 79МВт-ын эргэлдэх буцлах давхаргад түлш шатаах технологи бүхий 58МВт-ын, 21МВт-ын зуухыг эхний ээлжинд барихаар ажиллаж байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй зарим хэсгийг бага хүчин чадалтай дэд станц барьж дулаанаар хангах шийдвэрээс зөвхөн 28МВт-ын хүчин чадалтай Сэлбэ дулааны станц барьж ашиглалтад оруулсан байна

3.12 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдоогүй байршилд Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр байршил болон талбайн хэмжээг НИТХ-ын дараах шийдвэрүүдээр тогтоожээ. Үүнд:

- 2015 оны 198 дугаар тогтоолоор:
Сэлбэ дэд төв-ЧД-ийн 14, 15, 18, 19 хороо, СБД-ийн 13, 14 дүгээр хороо
Баянхошуу дэд төв- СХД-ийн 7, 8, 9, 10, 24, 26, 28 дугаар хороо
- 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тогтоолоор:
Дамбадаржаа дэд төв- СБД-ийн 16, 17 дугаар хороо
Дэнжийн мянга дэд төв- ЧД-ийн 10, 11, 12, 13 дугаар хороо
Толгойт дэд төв- СХД-ийн 1, 2, 3, 34, 35 дугаар хороо
Шар хад- БЗД-ийн 8, 9, 10, 17, 19, 24 дүгээр хороо
- 2024 оны 9 дүгээр сарын 19-ний 107 дугаар тогтоолоор:
Сэлбэ дэд төв- 2 дугаар ээлжийн байршил: СБД-ийн 12, 13 дугаар хороо, ЧД-ийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22 дугаар хороо
Дамбадаржаа дэд төв- ЧД-ийн 10, 11, 12, 13 дугаар хороо
Толгойт дэд төв- СХД-ийн 1, 2, 34 дүгээр хороо

3.13 МУЗГ, АХБ хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр-ийг УИХ 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан.

3.14 Тус хэлэлцээрээс 184,260.5 сая төгрөгийн төсөв өртөгтэй Сэлбэ дэд төв, Дамбадаржаа дэд төвийн дулааны станц барих, шугам сүлжээний угсралттай холбоотой 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 67,157.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сэлбэ дэд төвийн 28 МВт-ын хүчин чадалтай дулааны станц барих, холбогдох шугам сүлжээг угсрахтай холбоотой 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссаж, 24.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг НИТХ-ын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор ХИХУГ-ын өмчид шилжүүлсэн байна.

Хүснэгт 54. Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн дулаан хангамж, инженерийн дэд бүтцийн ажлын гүйцэтгэл, 2026 оны 4 дүгээр сарын байдлаар

№	Гэрээний нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	Ажлын явц (хувь)
1	Сэлбэ дэд төвд дулааны станцын барилгын ажил эхлүүлэх	19,824.5	100.0
2	Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	19,301.4	100.0
3	Сэлбэ дэд төвд авто зам, дулааны шугам сүлжээ болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	23,943.6	100.0
4	Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	1,909.0	100.0
5	Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	2,178.5	100.0
6	Дамбадаржаа дэд төвд баригдах дулааны станц	75,082.8	50.0
7	Дамбадаржаа дэд төвд баригдах авто зам болон дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	42,020.7	93.0
Нийт		184,260.5	

Эх сурвалж: НЗДТГ-ын харъяа Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн төслийн нэгж

3.15 Дамбадаржаа дэд төвийн 117,103.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дулааны станц болон холбогдох дэд бүтцийн ажил 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 65.4 хувь, үүнээс 75,082.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 МВт-ын дулааны станцын ажил 50.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тус тус тайлагнасан байна (*Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу*)

3.16 Сэлбэ дэд төвд 28 МВт-ын хүчин чадалтай Сэлбэ дулааны станц болон 14 ус, дулаан дамжуулах төвийг 2022 онд ашиглалтад оруулснаар Сэлбэ дэд төвийн урд хэсэг ДЭХ-д холбогдож, 2025 оны байдлаар 47 аж ахуйн нэгж байгууллага, 74 айл өрх тус станцаас дулаанаар хангагдсан байна.

3.17 Дэнжийн мянга дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, оргил ачааллын үед дулааны эх үүсвэр, дулаан хуваарилах төвийн ТЭЗҮ-ийг Ричвелл Инженеринг ХХК боловсруулж, ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тэмдэглэлээр дэмжигдсэн боловч хэрэгжүүлээгүй бөгөөд 93 МВт хүчин чадалтай хийн дулааны станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжихээр шийдвэр нь өөрчлөгджээ.

Зарим дэд төвийн барилга байгууламжид олгосон техникийн нөхцөл хүчингүй болсон нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удаашруулах эрсдэлтэй байна

3.18 “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж буй Толгойт, Баянхошуу дэд төвийн зарим барилга байгууламжид зарим барилга байгууламж дамжуулах сүлжээний хүчин чадлын хязгаарлалттай цэгээс ДЭХ-ээр хангагдахаар техникийн нөхцөл авсан, дулааны техникийн нөхцөл олгогдоод удсан учраас цаг хугацааны эрхээр одоо байгаа дулаан дамжуулах сүлжээний бодит ачаалал, хүчин чадалтайгаа бүрэн уялдахгүй байна. Тухайлбал,

- Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дулааны техникийн нөхцөл олгох ажлын хэсгээс 2015 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр олгосон Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын “Б” хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний нийт 8.9 Гкал/цагийн ачааллыг хангах 73 дугаартай техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөр дуусгавар болсон;
- ЭХЯ-аас 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр олгосон 03/2022-ДЦС-4 дугаартай Толгойт дэд төвийн хүрээнд СХД-ийн 1, 2, 3, 34, 35 дугаар хороонд баригдаж буй ус дулаан дамжуулах төвүүд болон гадна дулааны шугамын нийт 25.6 Гкал/цагийн ачааллыг хангах техникийн нөхцөл 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөр дуусгавар болсон.

3.19 Эдгээр техникийн нөхцөл нь ДЦС-4-ийн 210 МВт-ын дэд станцад өргөтгөл хийсний дараа хэрэгжих нөхцөлтэй байсан боловч одоогийн байдлаар тус коллектороос гарч буй Ø800 мм-ийн голчтой дамжуулах шугамын хэрэглээ, хүчин чадлын дээд хязгаарт хүрсэн тул нэмж техникийн нөхцөл олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

3.20 Дээрх Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын “Б” хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний ажлыг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, TRDH14-B дугаартай Толгойт дэд төвийн УДДТ болон дулаан, инженерийн хангамжийн шугам сүлжээний ажлыг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр тус тус ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн байна.

3.21 Энэ нь дулаан хангамжийн эх үүсвэр, дамжуулах сүлжээний одоогийн бодит хүчин чадал, хэрэглээний ачааллыг дахин тооцоолж, техникийн нөхцөлийг шинээр авах шаардлага үүсгэж, улмаар төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрчим хүчний хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболт хийх, хийн түлшээр ажиллах дэд төвийн технологийн шийдлийг шинэчлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд нийслэлийн өмчит аж ахуйг байгуулж, тендерт шалгаруулсан байна

3.22 НИТХ-ын 2024 оны 24/13 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотод нүүрстөрөгчийн хий ялгаруулдаг бүтээгдэхүүнийг цэвэр эрчим хүчээр солих замаар хүлэмжийн хийг бууруулах эсхүл түүнээс зайлсхийх бусад арга замыг эрэлхийлж уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-г байгуулж, дүрмийг хавсралтаар баталжээ.

Тус компанийн үндсэн зорилгыг:

- Нийслэл Улаанбаатар хотод сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар арилгах, хийн түлш болон бусад тархмал цэвэр эрчим хүчний шинэ эх үүсвэрт шилжүүлэх, энэ чиглэлийн эрх зүйн орчин, стандарт, норм дүрмийг боловсруулж, 2025 оноос эхлэн нийт 100.0 мянган айл өрхийг хийн түлш болон бусад цэвэр ДЭХ-ээр хангах дэд бүтцийг барьж байгуулах, хүлэмжийн хий ялгаруулдаг хүчин зүйлийг бууруулах чиглэлээр судалгаа, үнэлгээ хийх, хүний нөөцийг чадавхжуулах, сургалт зохион байгуулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүлэмжийн хийг бууруулсан тонн тутамд нүүрстөрөгчийн кредит цуглуулж, олон улсад арилжих зэрэг үндсэн ажлыг хэрэгжүүлэх;
- Тархмал цэвэр эрчим хүчний дэд бүтцийг барьж байгуулахдаа төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ингэхдээ энэ чиглэлийн төсөл боловсруулж, хөрөнгө оруулалт татах, техник туслалцааны зөвлөх авах, зээл, тусламж авах замаар олон улсын хүлэмжийн хийг бууруулах хөтөлбөрт хамрагдан, тэдгээртэй уялдуулан өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг шуурхай хангах, богино, дунд хугацаанд үр гарган ажиллахыг хариуцан зохион байгуулах гэж тодорхойлсон байна.

3.23 НЗД-ын Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай зарим арга хэмжээ авах тухай 2025 оны А/190 дүгээр захирамжаар компанийн дүрмийн сангийн хөрөнгөд зориулах 3,000.0 сая төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

3.24 НЗД-ын 2025 оны А/974 дүгээр захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх Тархмал дулааны эрчим хүчний хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболтын нэгдсэн ТЭЗҮ, график төсөл, техник туслалцааны зөвлөх үйлчилгээний 3,670.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т шилжүүлсэн байна.

3.25 НЗДТГ, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн хооронд 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Тархмал хэрэглээг хийн түлшээр хангах дэд бүтцийн холболтын нэгдсэн ТЭЗҮ, график төсөл, техник туслалцааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх ХТСИОНӨААТҮГ/20250303018 дугаартай, 3,670.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулжээ.

3.26 Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-аас дээрх төсөл арга хэмжээний хүрээнд шууд гэрээ байгуулах аргаар тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1.3⁸¹-т заасны дагуу гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахаар аж ахуй эрхлэгчтэй хэлэлцээ хийх тухай мэдээллийг хүргүүлжээ.

3.27 Тендерийн баримт бичигт тендерийг үнэлэх үндсэн шалгуураар үнийн харьцуулалтын аргыг сонгосон боловч Криогаз Монголиа ХХК 3,591.5 сая, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК 3,670.0 сая төгрөгөөр санал тус тус ирүүлсэн ч Криогаз Монголиа ХХК-ийн саналыг шаардлагад нийцээгүй гэж үзээд, Нийслэлийн өмчит компанийг үнийн санал харгалзахгүйгээр шалгаруулсан байна.

3.28 Мөн НХААГ-аас зохион байгуулсан Дэнжийн мянга дэд төвд баригдах 93 МВт-ын хүчин чадалтай хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэрийн технологийн шийдэл шинэчлэх ТЭЗҮ-г гүйцэтгэх 600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын нээлттэй сонгон шалгаруулалтад Грөвинг валю ХХК 478.7 сая, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК 480.0 сая, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн 481.2 сая төгрөгөөр үнийн саналыг тус тус ирүүлсэн байна.

3.29 Тухайн тендерт санал ирүүлсэн бусад компанийг мөн л шаардлага хангаагүй шалтгаанаар хасаж, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-г шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК нь аудитын хугацаанд хамтран ажиллахаас татгалзсан тул төслийн хэрэгжилттэй танилцах боломж олдоогүй болно.

3.30 Нийслэлээс өөрийн шинээр үүсгэн байгуулсан компанийг удаа дараа тендерт шалгаруулж, өндөр дүнтэй ажил гүйцүүлэх гэрээ байгуулсан нь Нийтийн албанд нийтийн

⁸¹ шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал.

болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байж болзошгүй байна.

Гэр, хорооллын айл өрхийн дулаалга, хийн түлшээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх ч айл өрхүүдийг хэрхэн сонгосон талаар баримт, судалгаа байхгүй байна

3.31 Засгийн газрын 2025 оны Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 133 дугаар тогтоолоор Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийн халаалтыг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшид шилжүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгасан байна. Үүнд:

- Гэр, амины орон сууц дулаалах;
- Цахилгаан, хийн халаагуур болон бусад дэвшилтэт технологийн шийдлээр гэр, амины орон сууцаа халаах айл өрхүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ногоон зээл олгох хүртээмжийг нэмэгдүүлэх

3.32 НИТХ-ын 2025 оны 25/59 дүгээр тогтоолоор Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, түүний хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам-ыг баталсан байна.

3.33 НЗД-ын 2025 оны А/1038 дугаартай захирамжаар эхний ээлжинд 2025 оны халаалтын улиралд гэр хорооллын гэр, амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулж, дулаалах ажиллагаанд хамрагдах өрхийн байршил, дулаалах ажлыг 2025 оны 8 дугаар сард багтаан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Баянгол, Чингэлтэй дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах 15,268.6 сая төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээний зардлаас гаргахыг НАОБТГ-т зөвшөөрсөн байна.

Хүснэгт 55. Гэр, байшин дулаалах байршлын мэдээлэл, төсөв

Дүүрэг	Хороо	Өрхийн тоо	Гэрийн дулаалгын зардал	Байшин дулаалгын зардал	Нийт
Баянгол	11	872	540.0	3,264.4	3,804.4
	16				
	10				
Чингэлтэй	11	3078	1,501.5	9,962.7	11,464.2
	11				
	13				
Нийт		3950	2,041.5	13,227.2	15,268.6

Эх сурвалж: НЗД-ын 2025 оны А/1038 дугаар захирамж

3.34 АББҮХ-ны 2025 оны 4, 5, 6 дугаар тогтоолуудаар ногоон бүсийн айл өрхийн байршлыг тогтоож, Чингэлтэй, Баянгол дүүргийн гэр хорооллын 5.0 мянга хүртэлх өрхийг дулаалж, цахилгаан болон хийн халаалтад шилжүүлэх ажлыг Нийслэлийн холбогдох байгууллагуудад үүрэг болгохын зэрэгцээ хэрэглэх хийн зуухны төхөөрөмжид Эрдэмтдийн зөвлөлөөс зөвлөмж гаргахыг даалгасан байна.

3.35 НЗД-ын 2025 оны А/1128 дугаартай захирамжаар эхний ээлжинд 2025 оны халаалтын улиралд хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж, суурилуулах өрхийн байршил, худалдан авах ажиллагааг холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг НАОБТГ-т үүрэг болгож, шаардагдах 22,495.7 сая төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээний зардлаас гаргахыг НАОБТГ-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг дүүргийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Баянгол, Чингэлтэй дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгажээ.

Хүснэгт. 56. Нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүргийн зарим хороодын гэр, байшин дулаалах болон хийн тоног төхөөрөмж суурилуулахад зарцуулах төсвийн мэдээлэл

№	Дүүрэг	Хороо	Гэр сууцтай өрхийн тоо	Байшин сууцтай өрхийн тоо	Нийт өрхийн тоо	Хийн тоног төхөөрөмжийн нийт үнэ, сая төг		Нийт
						Гэр сууц /6кВт/	Байшин сууц /10кВт/	
1	Баянгол	11	223	412	635	814.5	1,674.2	2,488.6
		16	194	356	550	708.6	1,446.7	2,155.3
		Нийт	417	768	1185	1,523.2	3,121.0	4,644.2
2	Чингэлтэй	10	506	756	1262	1,848.3	3,072.2	4,920.5
		11	209	827	1036	763.4	3,360.7	4,124.1
		13	286	1231	1517	1,044.7	5,002.4	6,047.1

Нийт	1001	2814	3815	3,656.3	11,435.2	15,091.6
Нийт	1418	3582	5000	5,179.5	14,556.2	19,735.7
Нэр	Тоо ширхэг			Нэгжийн үнэ		Нийт үнэ
Хийн тоног төхөөрөмжийн баллон худалдан авах	20,000			0.138		2,760.0
Нийт үнэ						22,495.7

Эх сурвалж: НЗД-ын 2025 оны А/1128 дугаар захирамж

3.36 НАОБТГ, БНХАУ-ын Qingdao Economic And Technological Development Zone Haier Water Heater Co, Ltd нарын хооронд 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр 12,692.3 сая төгрөгийн үнэ бүхий гэрээг байгуулж, дараах барааг нийлүүлэхээр тохиролцсон байна. Үүнд:

- Гэр сууц халаах зориулалт бүхий 6 кВт-ын хүчин чадалтай хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж 709 ширхэг;
- Байшин сууц халаах зориулалт бүхий 10 кВт хүчин чадалтай хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж 1791 ширхэг;
- 15 кг багтаамжтай хийн баллон 20,000 ширхэг.

3.37 НАОБТГ-ын даргын 2025 оны А/109 дугаар тушаалаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн Баянгол, Чингэлтэй дүүргийн гэр хорооллын айл өрхийг бүх төрлийн хийн халаагуурт шилжүүлэх ажлын хүрээнд 20.0 мянган ширхэг баллон, 5.0 мянган ширхэг хийн халаагуурын тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хамт хүлээн авч гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэн актаар хүлээлцэх Ажлын хэсгийг байгуулсан байна.

3.38 Дээрх Ажлын хэсгийн 2025 оны Хийн халаалтын төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийн 4 дүгээр хурлын тэмдэглэлд “Haier Компанитай байгуулсан 20000 ширхэг хийн баллон, 2500 ширхэг хийн халаагуурын тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг худалдан авах гэрээний гүйцэтгэлийн 40 хувьд тавьсан “Нийлүүлэгчээс барааг масс үйлдвэрлэл хийхэд бэлэн болсон тухай мэдэгдлийг захиалагчид хүргүүлнэ, захиалагч барааны эхний дээжийг шалган баталгаажуулсан байх” гэсэн шаардлагыг ажлын хэсэг хангасанд тооцож байна” гэжээ.

3.39 НАОБТГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Qingdao Economic And Technological Development Zone Haier Water Heater компанитай байгуулсан А/1128-01 дугаар гэрээний дагуу гүйцэтгэгч хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмжийг их хэмжээгээр үйлдвэрлэхэд бэлэн болсон мэдэгдлийг хүргүүлж, дамжлагын шугамыг танилцуулан, төхөөрөмжийн дээжийг хянуулан гүйцэтгэлийн 40 хувьд тавьсан шаардлагуудыг биелүүлсэн гэж үзэн актыг үйлдсэн байна.

3.40 НАОБТГ, БНХАУ-ын Qingdao Hisense Hitachi Air-Conditioning Marketing Co, Ltd нарын хооронд 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр А/1128-02 дугаартай 9,944.9 сая төгрөгийн үнэ бүхий гэрээг байгуулж, дараах барааг нийлүүлэхээр тохиролцсон байна. Үүнд:

- Гэр сууц халаах зориулалт бүхий 6 кВт-ын хүчин чадалтай хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж 709 ширхэг;
- Байшин сууц халаах зориулалт бүхий 10 кВт хүчин чадалтай хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж 1791 ширхэг.

3.41 2026 оны 3 дугаар сарын 13-ний өдрийн гэрээ дүгнэсэн актад “НАОБТГ-ын даргын 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн “А/109 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг нийлүүлэгчийн хүсэлтийн дагуу хийн түлшээр ажилладаг 6 кВт-709, 10 кВт-1791 тоног төхөөрөмжийг гэрээнд зааснаар гүйцэтгэлийн хувь тооцох нөхцөлөөр ажлын гүйцэтгэл 100.0 хувьд хүрсэн гэж үзэн бүх гишүүдийн саналаар хүлээн авсан” гэжээ.

3.42 Дээрх 2 гэрээгээр ижил төрлийн барааг, ижил тоо хэмжээгээр нийлүүлэхээр хоёр өөр компаниудтай байгуулсан байна.

3.43 НЗД-ын 2025 оны А/1175 дугаартай захирамжаар 2025-2026 оны халаалтын улиралд Баянгол дүүргийн 11,16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 10,11,13 дугаар хорооны 5.0 мянган өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд

шаардагдах 7,235.4 сая төгрөгийн зардлыг Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-т шилжүүлэхийг НАОБТГ-т арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулж, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг ТХҮТ ОНӨААТҮГ-т тус тус үүрэг болгосон байна. Үүнд:

- Шингэрүүлсэн шатдаг хий худалдаж авахад 3,781.2 сая;
- Баллон хадгалах завсрын агуулахын барилга барих ажил үйлчилгээнд 3,283.5 сая;
- Багаж, тоног төхөөрөмж авахад 15.7 сая;
- Бусад зардалд 155.0 сая.

3.44 НЗД-ын 2025 оны А/1617 дугаар захирамжаар эхний ээлжинд 2025-2026 оны халаалтын улиралд Баянгол, Чингэлтэй дүүргийн 5.0 мянган өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд шаардагдах 7,235.4 сая төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт баталсан Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээний зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг НАОБТГ-т зөвшөөрсөн байна.

Хүснэгт 57. Гэр, хорооллын айл, өрхийн дулаалга, хийн хангамжийн тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан санхүүжилтийн задаргаа, сая төгрөгөөр

№	Шийдвэрийн нэр	Дүүрэг, хороо	Өрхийн тоо	Гэрийн дулаалгын зардал	Байшингийн дулаалгын зардал	Нийт	Хяналт хэрэгжүүлэх
Нэг. Гэр, байшингийн дулаалгын зардал							
1	НЗД-ын 2025 оны А/1038 дугаартай захирамж	Баянгол 11,16, Чингэлтэй 10,11,13	3950	2,041.5	13,227.2	15,268.7	
Хоёр. Хийн тоног төхөөрөмжийн зардал							
				Гэр сууц /6кВт/	Байшин сууц /10кВт/		
2	НЗД-ын 2025 оны А/1128 дугаартай захирамж	Баянгол 11,16, Чингэлтэй 10,11,13	5000	5,179.5	14,556.2	22,495.7	
3	НЗД-ын 2025 оны А/1128 дугаартай захирамж	Баянгол 11,16, Чингэлтэй 10,11,13	5000			7,235.4	Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ
Нийт						44,999.8	

Эх сурвалж: НЗД-ийн захирамжууд

3.45 Дээрх дурдсанаас дүгнэхэд 2 дүүргийн 5 хорооны 5.0 мянган өрхийн дулааныг хийн хангамжид шилжүүлэхэд 44,999.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах зорилгоор байгуулсан үйлдвэрүүдийг импортын түлш савлах болон агуулахын зориулалтаар ашиглаж байгаа нь төлөвлөлт тооцоо судалгаагүй байгааг харуулж байна

3.46 УИХ, Засгийн газрын шийдвэрээр Эрдэнэс-Тавантолгой ХК нь Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэр барих, үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эд авах, нөөц бүрдүүлэх, иргэдэд дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй үнээр олгосон сайжруулсан шахмал түлшний зөрүүг нөхөн санхүүжүүлэх зориулалтаар 2018-2026 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 23 удаагийн 2,103.9 тэрбум төгрөгийн зээлийн гэрээг байгуулж, нийт 1,755.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. (Гэрээний дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу)

3.47 Тавантолгой түлш ХХК нь зээлийг 2025 оноос эхлэн төлөхөөр гэрээ байгуулсан ч гэрээнд өөрчлөлт оруулж, зээл төлөх хугацааг хойшлуулсан байна. Харин 2026 онд 48.4 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийх хуваарьтай боловч компани эргэн төлөлт хийх санхүүгийн боломжгүй байна. (Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хавсралт 7-оос харна уу)

3.48 БОАЖС (хуучин нэрээр)-ын 2018 оны А/479 дүгээр тушаалаар баталсан Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам-ын дагуу НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны А/1250 дугаар захирамжаар нэгдсэн тоо бүртгэлийг хийсэн тоон мэдээллийг нэгтгэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 58. Улаанбаатар хотын төвлөрсөн инженерийн байгууламжгүй хэсгийн дулааны эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл

№	Суурин эх үүсвэрийн хүчин чадлын ангилал	Нийт зуухны тоо	Байшин болон гэрт ашиглаж байгаа дулааны үүсвэр		Зууханд ашиглах түлшний төрөл, хэмжээ					Цахилгаанаар дулаан шийдвэрлэсэн тоо
			ердийн зуух	Сайжруулсан зуух	нүүрс, мянган тонн	мод, мянган метр куб	сайжруулсан түлш, мянган тонн	дизель, мянган тонн	бусад, мянган тонн	
1	Ердийн галлагаатай 3-15 квт хүчин чадалтай зуух	160,219	108,372	51,847	19.5	118.0	464.0		0.8	11,757
2	Усан халаалтын 15-100 квт хүртэл хүчин чадалтай зуух	2,306			0.93	2.13	152.53	0.002	0.93	
3	Усан халаалтын 100-4200 квт хүртэл хүчин чадалтай зуух	248			175.1	3.6	25.8		11.4	
4	Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын халаалтын зуух	182			130.0					
Нийт дүн		162,955	108,372	51,847	325.5	123.8	642.4	0.0	13.1	11,757

Эх сурвалж: НЗДТГ

3.49 Нэгдсэн тоо бүртгэлийн мэдээгээр Улаанбаатар хотод 2025 оны байдлаар ердийн галлагааны, усан халаалтын, дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын халаалтын нийт 163.0 мянган зуухыг ашиглаж байна. Тэдгээрт 325.5 мянган тонн нүүрс, 123.8 мянган метр куб түлээний мод, 642.4 мянган тонн сайжруулсан, 13.1 мянган тонн бусад түлш шаардлагатай гэж гаргажээ. Мөн 11.8 мянган айл өрх цахилгааны эрчим хүчээр халаалтаа шийдвэрлэсэн, уурын болон усан халаалтын 40 зуухыг хий болон цахилгааны эх үүсвэрт шилжүүлж 20.4 мянган тонноор нүүрсний хэрэглээг багасгасан гэжээ.

3.50 Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 22 ААНБ-ын 73 байршилд 182 халаалтын зуухыг ажиллуулж байгаагаас Багахангайд 8, Баянзүрхэд 56, Налайхад 7, Сонгинохайрханд 43, Сүхбаатарт 19, Хан-Уулд 27, Чингэлтэйд 22 байна.

3.51 Засгийн газрын 2018 оны Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 62 дугаар тогтоол, 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн Үндэсний хорооны гишүүдэд чиглэл өгөх тухай 05 дугаар тогтоолын 5-д ...Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд эрчим хүчний угаан баяжуулсан завсрын бүтээгдэхүүн /мидлинг-ийг бодит хэрэгцээнд тулгуурлан нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Тавантолгой түлш ХХК-д чиглэл болгожээ.

3.52 БОУАӨС, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай А/651/983 хамтарсан тушаал, захирамжаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс болон бүсэд мөрдөх журмыг шинэчлэн баталсан байна.

3.53 НЗД-ын 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай А/1052 дугаар захирамжаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд дулаан, эрчим хүч үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй уурын болон усан халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар зогсоож, эдгээр зуухны технологийг шинэчилж, угааж баяжуулсан нүүрс (мидлинг)-ний хэрэглээнд бүрэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг даалгажээ.

3.54 Тавантолгой түлш ХХК нь дээрх шийдвэрүүдийн дагуу 2025-2026 оны халаалтын улиралд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад хэрэглэх угааж баяжуулсан

нүүрсний хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн тооцоололд үндэслэж, Эрдэнэс Тавантолгой ХК-аас 130.0 мянган тонн нүүрс авахаар хүссэн боловч чанарын үзүүлэлт шаардлага хангаагүй тул Энержи ресурс ХХК-д угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлэх хүсэлтийг гарган, тус компанитай гэрээ байгуулан, ААНБ-уудад борлуулах үйл ажиллагааг зохион байгуулжээ.

3.55 Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Тавантолгой түлш ХХК нь Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдоогүй гэр хорооллын айл өрх, ААНБ-уудын түлшний хэрэгцээг хангах зорилгоор 2020-2025 онд 3,333.2 шахмал түлш үйлдвэрлэж, 3,149.3 мянган тонн-ыг борлуулсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 8-аас харна уу)

3.56 Тавантолгой түлш ХХК-ийн зах зээлд нийлүүлэх түлшний үнийг ОББҮХ (хуучин нэрээр)-оос тогтоосноор зах зээлийн бодит үнээр борлуулах боломжийг хязгаарлаж, алдагдалтай ажиллахад хүргэх нөхцөлүүдийн нэг болжээ. Тус хорооны 2019 оны 19/12 дугаар тогтоолоор *Сайжруулсан шахмал түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150.0 мянга, хатуу түлшний борлуулалтын нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 15.0 мянган төгрөгөөр тус тус тогтоожээ.*

3.57 Харин АББҮХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдоогүй гэр хорооллын айл өрх, ААНБ-уудад борлуулах түлшний үнийг дараах байдлаар баталжээ. Үүнд:

- Хагас коксжсон (хөх) нүүрсэн шахмал түлш: Гэр хорооллын айл өрхөд борлуулах нэг тонн тутмын үнийг НӨАТ-гүйгээр 200.0 мянган төгрөг;
- Угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс (мидлинг): ААНБ-уудад нийлүүлэх нэг тонн тутмын үнийг НӨАТ-гүйгээр 250.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна.

3.58 Мөн хагас коксжсон (хөх) нүүрсэн шахмал түлшний хангамж тасалдах эрсдэлээс сэргийлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд баяжуулж ангилсан нүүрсэн түлшийг гэр хорооллын айл өрхүүдэд нэг тонныг нь НӨАТ-гүйгээр 150.0 мянган төгрөгөөр худалдан борлуулахыг Тавантолгой түлш ХХК-д үүрэг болгожээ.

3.59 Мидлингэн шахмал түлшний 1 тонн тутмын өөрийн өртөг 2018 онд 174.1 мянган төгрөг байсан бол 2025 онд 551.4 мянган төгрөг болж, 3.2 дахин өссөн ч 150.0 мянган төгрөгөөр борлуулж, мөн 2025 оны шийдвэрээр савласан мидлингийн өртөг 300.9 мянган төгрөг байхад 150.0 мянган төгрөгөөр, хагас коксон түлшний өртөг 1,092.9 мянган төгрөг байхад 200.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож, үнийн зөрүүг хэрхэн шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүйгээс алдагдлын хэмжээ тогтмол өсөж, улмаар Эрдэнэс-Тавантолгой ХК-аас олгосон эргэн төлөх нөхцөлтэй санхүүжилтийг буцаан төлөх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

3.60 Тавантолгой түлш ХХК нь 2025-2026 оны халаалтын улиралд Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдэд сайжруулсан шахмал түлшийг борлуулалтын 434 цэгээр дамжуулан нийлүүлжээ. Төлөвлөсөн цэгүүдээс 2 нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүснэгт 59. Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг, хэрэглэгч, хэрэглээний судалгаа

	2020	2021	2022	2023	2024	2025
Сайжруулсан шахмал түлшний борлуулах цэгийн тоо						
Сонгинохайрхан	230	222	224	227	249	168
Чингэлтэй	35	91	92	94	87	60
Хан-Уул	24	53	53	45	44	42
Баянгол	16	31	30	29	26	17
Баянзүрх	82	160	159	151	130	97
Сүхбаатар	34	63	61	58	48	32
Налайх	-	-	31	33	32	20
Нийт	421	620	650	637	616	436
Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ						
Хэрэглэгчийн тоо (мянга)	150.6	198.6	173.4	179.5	162.4	172
Борлуулсан түлшний хэмжээ (мян.тн)	537.8	500.3	467	493.4	452.7	437.9

Эх сурвалж: Тавантолгой түлш ХХК

3.61 Аудитын баг гэр хорооллын айл өрхүүд дэх сайжруулсан шахмал түлшний хүртээмж, чанарын бодит байдлыг үнэлэх зорилгоор Хатуу болон хийн түлшний хяналтын нэгдсэн систем “Хотула” платформыг ашиглан 4,481 өрхийг тандан судалгаанд хамруулав. Судалгаанд оролцогчдын сууцны төрлийг авч үзвэл:

- Амины сууц (байшин)-нд амьдардаг: 49.5 хувь (2,219 өрх),
- Монгол гэрт амьдардаг: 45.2 хувь (2,025 өрх),
- Улирлаас хамааран хоёуланд нь амьдардаг: 5.3 хувь (237 өрх) байна.

3.62 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 79.7 хувь нь 80 м.кв хүртэлх талбайтай амины сууц (байшин)-нд амьдарч байна. Сууцны талбайн хэмжээнээс хамаарч өдөр тутмын түлшний хэрэглээ дараах байдалтай байна.

- 40 м.кв хүртэл: Өрхүүдийн 53.4 хувь нь өдөрт 1 хүртэлх шуудай,
- 40-80 м.кв: Өрхүүдийн 47.7 хувь өдөрт 1-2 шуудай,
- 80 м.кв-аас дээш: Өрхүүдийн 34.6 хувь нь өдөрт 2-3 шуудай түлш тус тус хэрэглэж байна.

3.63 Энэхүү үзүүлэлт нь сууцны талбайн хэмжээ болон түлшний хэрэглээ хоорондоо шууд хамааралтайг илтгэж байна. Иймд сайжруулсан түлшний хэрэглээ, нийлүүлэлтийг төлөвлөхдөө айл өрхүүдийн сууцны талбайн хэмжээг шалгуур болгон харгалзан үзэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 60. Сайжруулсан түлшний өдрийн хэрэглээ, сууцны талбайгаар

	1 хүртэл шуудай	1-2 шуудай	2-3 шуудай	3-аас дээш шуудай
40-өөс доош м.кв	53.4%	35.2%	25.6%	33.6%
40-80 м.кв	39.9%	47.7%	39.7%	33.6%
80 м.кв-аас дээш	6.7%	17.1%	34.6%	32.8%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%


Эх сурвалж: Аудитын судалгааны үр дүн

3.64 Айл өрхүүдийн түлш худалдан авах давтамж их байх тусам нөөцийн хомсдолд орох эрсдэл нэмэгдэж байна. Сайжруулсан түлшийг өдөр бүр худалдаж авдаг айл өрхүүдийн

42.9 хувь, 2-3 хоног тутамд худалдаж авдаг айл өрхүүдийн 42.1 хувь нь түлшний нөөц байнга дутагддаг гэж хариулжээ.

3.65 Энэ нь худалдан авалтын давтамж өндөр өрхүүд нийлүүлэлтийн тасалдалд хамгийн их өртөж байгааг илтгэж байна. Иймд түлшний хангамжийн тогтвортой байдлыг хангахын тулд нөөцийн удирдлага болон түгээлтийн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.


График 9. Сайжруулсан түлшний өдрийн хэрэглээ



Эх сурвалж: Аудитын судалгааны үр дүн

3.66 Түлшний нийлүүлэлт тогтворгүй байгаагаас шалтгаалан олдоц муудах үед өрхүүдийн 80.0 хувь нь өөр борлуулалтын цэг хайж хэрэгцээгээ хангадаг байна. Үлдсэн өрхүүд халаалтаа бууруулах (9.2%), өндөр үнээр худалдан авах (7.2%), эсвэл өөр төрлийн түлш хэрэглэх (3.5%) зэрэг арга хэмжээ авч байгаа нь амьжиргааны зардлыг нэмэгдүүлж, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

График 10. Түлшний олдоц муудсан авч буй арга замууд, түлшний цэгийн байршилд өгсөн үнэлгээ



Эх сурвалж: Аудитын судалгааны үр дүн

3.67 Нөгөө талаас, судалгаанд оролцогчдын 72.2 хувь нь түлш борлуулах цэг харьцангуй ойр байдаг гэж хариулсан нь газарзүйн байршлын хувьд хэрэглэгчдэд ээлтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 61. Сайжруулсан түлшний чанарт өгсөн үнэлгээ

Үнэлгээ	Илч	Утаа	Үнс	Үнэ
Маш муу	9.9%	14.7%	18.7%	14.6%
Муу	10.5%	12.6%	12.2%	11.6%
Дунд	36.8%	37.3%	31.9%	38.5%
Сайн	23.9%	19.4%	18.8%	18.2%
Маш сайн	19.0%	16.0%	18.4%	17.1%
Нийт	100%	100%	100%	100%

Эх сурвалж: Аудитын судалгааны үр дүн

3.68 Сайжруулсан түлшний чанарыг **илч, утаа, үнс, үнэ** гэсэн 4 хэмжигдэхүүнээр үнэлэхэд 31.9-38.5 хувь нь **дунд** түвшний үнэлгээ өгчээ. Харин үнсийг 30.9 хувь нь, утааг 27.2 хувь нь **муу** (маш муу ба муу) үнэлж байгаа нь утаа болон үнсний асуудалд цаашид анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна.

Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийн болон хуваарилалтын зохицуулалтыг сайжруулах шаардлага үүссэн байна

3.69 Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай хуралдааны 18 дугаартай шийдвэрийг үндэслэн Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын дагуу сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх чиг үүрэг бүхий Тавантолгой түлш ХХК үүсгэн байгуулсан байна.

3.70 Тавантолгой түлш ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах сайжруулсан шахмал түлшний баруун үйлдвэр нь ТЭЗҮ-ээрээ цагт 8-10 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, 10 шугам бүхий 3 хэсэгтэй бөгөөд жилд 600.0 мянган тонн түлш үйлдвэрлэхээр төлөвлөжээ. Тус үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний ажлыг Ногоон байгаль ХХК гүйцэтгэсэн байна.

3.71 Тавантолгой түлш ХХК-ийн төвийн үйлдвэрийг анх 2010-2012 онд улсын төсвийн хөрөнгөөр, жилд 210.0 мянган тонн хагас коксон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байгуулжээ. Уг төслийг Аморе интернэшнл ХХК болон ОХУ-ын Сибтермо компанийн хамтарсан консорциум гүйцэтгэсэн боловч технологийн шийдэл нь амжилтгүй болсны улмаас үйлдвэрийг ажиллуулах боломжгүй болсон байна. Үүний дараа ЭХЯ-аас 2018 онд тус үйлдвэрт сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх шийдвэр гаргаж, Ажлын хэсэг байгуулан холбогдох үйл ажиллагааг эхлүүлжээ.

3.72 Төвийн үйлдвэр 2019 оны 01 дүгээр сарын байдлаар нэг шугамаар хоногт 30 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай байсан ба техникийн шинэчлэл хийж “А” шугамыг ашиглалтад оруулснаар суурилагдсан хүчин чадлыг 10 дахин нэмэгдүүлснээр хоногт 300 тонн буюу жилд 100.0 гаруй мянган тоннд хүрсэн байна.

3.73 Засгийн газрын 2020 оны Нийслэл Улаанбаатар хотын зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж ашиглалтад оруулах тухай 35 дугаартай тогтоолоор Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн зүүн бүсэд шинээр барих сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц, тээвэр, машин механизм, тоног төхөөрөмжид шаардагдах нийт хөрөнгийг ТЭЗҮ, тооцоо судалгаанд үндэслэн нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлэхийг БОАЖС (хуучин нэрээр), ОББҮХ, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн удирдагуудад даалгажээ.

3.74 Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэлд дурдсанаар: Тавантолгой түлш ХХК-ийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх талаар Эрчим хүчний сайд танилцуулжээ. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох албаны хүмүүст даалгасан байна.

- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн нутагт орших зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг Эрчим хүчний сайд, Тавантолгой түлш ХХК-ийн удирдлагад;
- Нийслэлийн баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ашиглаж байсан газар, барилга байгууламжийг сайжруулсан шахмал түлшний нөөцийн агуулахын зориулалтаар ашиглах арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд, Тавантолгой түлш ХХК удирдлагад;

3.75 ОББҮХ-ны 2022 оны Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 22/09 дугаар тогтоолд дурдсанаар

- Тавантолгой түлш ХХК-ийн Зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт хийсэн ОББҮХ-ны дэргэдэх "Эрдэмтдийн зөвлөл"-ийн туршилт судалгааны дүнг үндэслэн хавсралтад заагдсан технологийн шинэчлэлийг яаралтай хийх,
- Баруун бүсийн үйлдвэрийн үйл ажиллагааг 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоох арга хэмжээ авч, үйлдвэрийн байрыг дундын бүсийн агуулахын барилгын зориулалтаар ашиглах бэлтгэл хангах, үйлдвэрийн гаднах талбайн орчны бохирдлыг бүрэн арилгаж, ногоон байгууламж байгуулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийн бүрдүүлэхийг Компанийн удирдлагад үүрэг болгосон ч 2025 оны 6 дугаар сарын байдлаар дээрх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

3.76 Улаанбаатар хотын Зүүн бүсэд 2020 онд жилд 600.0 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ боловсруулж, ЭХЯ-ны Технологийн зөвлөлөөр хэлэлцүүлжээ. Төслийн хүрээнд үйлдвэрлэлийн үндсэн хоёр цехийг 2020-2021 онд ашиглалтад оруулсан байна. Мөн 2020 онд Хотын түлш ХХК-ийн цагт 8.0 тонн түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг өөрийн эзэмшилд шилжүүлэн авснаар, тус үйлдвэрийн 3 дугаар цех болгон ажиллуулж эхэлжээ.

3.77 Компани 2023 оны 4 дүгээр сараас үйлдвэрлэлийн 3 дугаар цехийн өргөтгөл, шинэчлэлийг үе шаттайгаар гүйцэтгэж, энэ хүрээнд 50 тн/цаг хүчин чадалтай олон тасалгаат босоо хатаах төхөөрөмж, хагас автомат галлагааны зуух, уутат фильтр болон 50 тн/цаг хүчин чадалтай холигчийг шинээр суурилуулж, туршилт, тохируулгыг хийж, 2024 оны 5 дугаар сараас шахмал түлшний үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд эхний шатанд цагт 25 тонныг үйлдвэрлэсэн байна.

3.78 Уг тоног төхөөрөмж бүрэн хүчин чадлаараа ажиллаж, бэлэн байдал 80.0 хувьтай байхад цагт 40 тн шахмал түлш үйлдвэрлэх боломжтой нь туршилт, тохируулгын ажлаар баталгаажсан. Цаашид энэхүү өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үйлдвэрлэлийн 1, 2 дугаар цехэд 2024-2025 онд үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөснөөр үйлдвэрлэлийн шугамын тоог цөөлж, бүрэн хүчин чадлаараа ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр байжээ.

3.79 Төслийн хүрээнд жилд 720.0 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангахаар төлөвлөсөн байна.

3.80 Тавантолгой түлш ХХК нь Зүүн үйлдвэрийг өргөтгөх, шинэчлэх төслийн эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалт, орлого, зардлын тооцооллыг 10 жилийн хугацаатайгаар төлөвлөж, уг төслийн хүрээнд үйлдвэрлэлийн цехүүдийн өргөтгөл, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих, шинэ тоног төхөөрөмжийн худалдан авалт,

угсрах, хуучирч элэгдсэн үндсэн хөрөнгийг сольж шинэчлэхээр техникийн болон санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан байна.

3.81 Сайжруулсан шахмал түлшний түүхий эд болох мидлингийг Энержи ресурс ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 2018-2025 онд нийт 3,259.3 мянган тонныг Тавантолгой түлш ХХК-д олгосон байна.

Хүснэгт 62. Тавантолгой түлш ХХК-ийн 2018-2025 онд Энержи ресурс ХХК-аас татан авсан мидлинг, мянган тонн

Үйлдвэрийн нэр	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Авто тээвэр	13.75	706.30	312.49	631.72	426.45	-	-	-
Галт тэргээр	-	-	-	-	109.80	410.26	518.33	130.26
Нийт татан авалт	13.7	706.3	312.5	631.7	536.2	410.3	518.3	130.3

Эх сурвалж: Тавантолгой түлш ХХК

3.82 Сайжруулсан шахмал түлшний түүхий эдийг Энержи ресурс ХХК-аас үнэ төлбөргүйгээр нийлүүлсэн, Эрдэнэс-Тавантолгой ХК-аас хүү, торгуульгүйгээр эргэн төлөх нөхцөлөөр зээл олгосоор байхад тооцоо судалгаагүй хэрэглээнээс хэт өндөр хүчин чадалтай үйлдвэр байгуулсан, төвийн үйлдвэрийг агуулах болгож, баруун бүсийн үйлдвэрийг татан буулгасан, харин Зүүн бүсийн үйлдвэр БНХАУ-аас худалдан авсан шахмал түлшийг уутлах, тараах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хүснэгт 63. Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгийн нэгтгэл, тэрбум төгрөг

№	Байршил	Дансны нэр	Тоо хэмжээ	Хөрөнгийн анхны өртөг	Хөрөнгийн дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Баруун үйлдвэр	Барилга, байгууламж	28,007.0	36.59	45.22	7.89	39.60
2		Тоног төхөөрөмж	632.0	39.57	41.11	18.08	23.37
4		Тавилга эд хогшил	1,053.0	0.92	0.92	0.44	0.48
5		Компьютер дагалдах хэрэгсэл	165.0	0.30	0.30	0.26	0.04
6		Бусад үндсэн хөрөнгө	230.0	1.93	1.99	0.58	1.41
7		Программ хангамж	6.0	0.11	0.11	0.04	0.06
8		Дуусаагүй барилга	5.0	-	2.61	-	-
		Баруун үйлдвэрийн дүн	30,098.0	79.42	92.25	27.29	64.96
1	Төвийн үйлдвэр	Барилга, байгууламж	3,406.5	6.83	9.54	2.14	11.06
2		Тоног төхөөрөмж	171.3	19.20	20.52	7.82	12.70
4		Тавилга эд хогшил	176.0	0.09	0.09	0.07	0.02
5		Компьютер дагалдах хэрэгсэл	102.0	0.18	0.22	0.16	0.06
6		Бусад үндсэн хөрөнгө	21.0	0.91	0.91	0.18	0.73
7		Программ хангамж	1.0	0.15	0.15	0.04	0.11
8		Газар эзэмших эрх	3.0	5.40	5.40	0.05	5.35
9		Дуусаагүй барилга	2.0	-	3.67	-	-
		Төвийн үйлдвэрийн дүн	3,882.8	32.76	40.49	10.46	30.03
1	Зүүн үйлдвэр	Барилга, байгууламж	91,135.3	72.79	90.75	11.32	127.16
2		Тоног төхөөрөмж	1,765.0	79.52	92.99	27.80	65.31
3		Тээврийн хэрэгсэл	149.0	17.96	18.42	10.91	7.51
4		Тавилга эд хогшил	2,679.0	1.54	1.54	0.80	0.74
5		Компьютер дагалдах хэрэгсэл	1,184.0	3.53	3.56	2.91	0.65
6		Бусад үндсэн хөрөнгө	3,550.3	4.60	7.60	1.77	5.84
7		Программ хангамж	52.0	1.93	2.68	1.56	1.12
8		Бусад биет бус хөрөнгө	21.0	0.98	1.11	0.82	0.30
9		Дуусаагүй барилга	9.0	-	47.85	-	-
		Зүүн үйлдвэрийн дүн	100,544.5	182.85	266.50	57.89	208.61
		Нийт үйлдвэрийн хөрөнгийн дүн	134,525.3	295.03	399.24	95.63	303.61

Эх сурвалж: Тавантолгой түлш ХХК

3.83 Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй айл өрх, ААНБ-ыг сайжруулсан шахмал түлшээр хангах зорилгоор байгуулсан Баруун, Төвийн, Зүүн үйлдвэрүүд нь данс бүртгэлээр 399.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгөөс 95.6 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 303.6 тэрбум төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

3.84 Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх 3 үйлдвэр нь 1,520.0 мянган тонн үйлдвэрлэх хүчин чадалтай боловч 2021 онд дээд хэмжээ нь 601.2 мянган тонн түлш үйлдвэрлэж, хүчин чадлынхаа 42.9 хувийг ашигласан нь үндэслэл тооцоогүй их хэмжээний үргүй зардал гаргасныг харуулж байна.

Хүснэгт 64. Тавантолгой түлш ХХК-ийн 2018-2025 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, мянган тонн

Үйлдвэрийн нэр	Суурилагдсан хүчин	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
----------------	--------------------	------	------	------	------	------	------	------	------

	чадалд тонн/жил								
Баруун үйлдвэр	600.0	-	187.9	467.0	430.7	393.8	206.4	70.9	-
Төвийн үйлдвэр	200.0	2.3	15.5	42.8	44.0	33.3	152.7	183.8	33.0
Зүүн үйлдвэр	720.0	-	-	20.5	126.4	146.5	145.5	254.2	188.6
Нийт үйлдвэрлэл	1,520.0	2.3	203.4	530.3	601.2	573.6	504.6	508.8	221.6
ТЭЗҮ-ээрх хүчин чадал			600.0	1,400.0	1,400.0	1,400.0	1,400.0	1,400.0	1,400.0
Үйлдвэрлэл, хүчин чадлын зөрүү			396.6	869.7	798.8	826.4	895.4	891.2	1,178.4
Хүчин чадал ашиглалт, хувиар			33.9	37.9	42.9	41.0	36.0	36.3	15.8

Эх сурвалж: ТТТ ХХК

3.85 Дээрх хэмжээний буюу 399.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 1,520.0 мянган тонн түлш үйлдвэрлэх хүчин чадалтай 3 үйлдвэр байгуулаад ТЭЗҮ-д заасан үйлдвэрлэл явуулаагүйгээс гадна Баруун үйлдвэрийн 10 шугамын 7 шугамын үйл ажиллагааг зогсоож, буулгаснаас цаашид үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон байна.

3.86 Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

- Багануур хүрэн нүүрсний стратегийн ордыг түшиглэн хүрэн нүүрсийг нам температурт боловсруулж, түүхий нүүрсэнд агуулагдах хорт нэгдэл, дээдэмхий бодисыг бууруулсан, утаа багатай хөх нүүрс үйлдвэрлэх "Нүүрс-пиролизын үйлдвэр" байгуулах асуудлыг судлах;
- Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэж байгаа сайжруулсан шахмал түлшээр Нийслэл Улаанбаатар хотын хэрэглэгчдийг хангах асуудлыг судалж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулахаар чиглэл өгсөн байна.

3.87 АББҮХ-ны дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаартай зөвлөмжөөр:

- Тавантолгой түлш ХХК-ийн шинээр үйлдвэрлэх гэж буй сайжруулсан шахмал түлшний анхдагч түүхий эд болох Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн олборлож буй "тэг" давхаргын нүүрсний баяжуулсан нүүрсний хүхэрлэг хийн (SO2) хүлцэх хэмжээ стандартад заасан хэмжээнээс дунджаар 1.66 дахин их, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн хүлцэх хэмжээ 1.45 дахин их байгааг анхаарч, шахмал түлш хийхээр сонгон хэрэглэх тохиолдолд дахин баяжуулах, эсвэл баяжуулалтын технологио солих, эсвэл анхдагч нүүрсний өөр эх үүсвэрийг судлах шаардлагатай. Энэ тохиолдолд гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран туршилт судалгааны ажлыг бүрэн хийж, эрсдэлийг бууруулах;
- Туршилтаар хийсэн шахмал түлшин дэх нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн хүлцэх хэмжээ лабораториудын шинжилгээгээр 1.4 дахин их гарч, "Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага" MNS 5216:2016 стандартын шаардлагыг хангахгүй байгааг анхаарч технологийн горимыг хянах, сайжруулах.
- ЭХЯ, ОББҮХ-той хамтран 2023 онд хийсэн хагас коксон түлшний туршилт, судалгааны үр дүнд үндэслэн ирэх галлагааны улирал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахын тулд хагас коксон шахмал түлшийг импортоор авах тохиолдолд тухайн түлшний дээжний нарийвчилсан шинжилгээг хийж, дүгнэлт гаргуулах;
- Цаашид хагас коксоор шахмал түлш үйлдвэрлэх, шахмал түлшний түүхий эдийг өөр эх үүсвэрээр солих туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлэх гэснийг хуралдаанд оролцсон гишүүд бүгд дэмжсэн байна гэжээ.

3.88 АББҮХ-ны 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Үндэсний хорооны гишүүдэд чиглэл өгөх тухай 04 дүгээр тогтоолоор Тавантолгой түлш ХХК-ийн шинээр үйлдвэрлэх сайжруулсан шахмал түлшний анхдагч түүхий эд болох Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн олборлож буй "тэг" давхаргын нүүрсний баяжуулсан нүүрсний чанарын үзүүлэлт, уг түүхий эдээр үйлдвэрлэсэн түлшний үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй, ЭХС-ын 2023 оны А/94 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн туршилт, судалгааны ажлын тайланд үндэслэн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах болон 2025-2026 оны галлагааны улиралд түлшээр тасралтгүй хангах зорилгоор импортын бэлэн түлшийг (хөх нүүрс) хэрэглэгчдэд зориулан жижиглэн савлах, агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

3.89 Улаанбаатар хотод хагас кокс түлш үйлдвэрлэх үйлдвэр байхгүйн улмаас БНХАУ-аас импортын түлш худалдан авахаар 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Тавантолгой түлш ХХК, БНХАУ-ын компанитай ТТТ-2025-94 дугаартай гэрээ байгуулсан байна. Уг гэрээгээр хагас коксжуулсан шахмал түлшний нэг тонныг 738.5 мянган төгрөгөөр тооцон, нийт 306.0 мянган тонныг 225,981.0 сая төгрөгөөр импортлон авчээ.

3.90 НИТХ-ын 2025 оны 25/21 дугаартай тогтоолоор хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээнд хяналт тавьж, пийшин, яндан, зуухны битүүмжийг шалгах, засвар үйлчилгээ хийх, зөв галлагааны горим, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх санамж зөвлөмжийг тараах, судалгаа Мэдээлэл авч нэгтгэх, сургалт зохион байгуулах, угаарын хий мэдрэх төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, хяналтын системээр тасралтгүй хянах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бодит мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үндсэн чиг үүрэг бүхий Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ байгуулж, дүрмийг баталжээ.

3.91 НЗД-ын 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/496 дугаар захирамж, тус төвийн даргын 2025 оны А/01 дугаартай тушаалаар Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг дарга, еранхий менежер, ерөнхий инженер тус бүр 1, үндсэн 74, гэрээт 500 байхаар баталсан байна.

3.92 Гэрээт ажилчдад 2025 онд давхардсан тоогоор 2634 ажилтанд 1,343.7 сая төгрөгийн цалинг олгосон боловч ажлын тайлан баримтаар нотлогдохгүй учраас үр дүнг үнэлэх боломжгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 9-өөс харна уу)

Тавантолгой түлш ХХК нь төрийн өмчийн хөрөнгийг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй шилжүүлж, данс бүртгэлээс хасаж холбогдох журмыг зөрчсөн байна

3.93 Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийг үндэслэн Тавантолгой түлш ХХК шахмал түлшийг тасралтгүй үйлдвэрлэх, түүхий эдийн тээвэрлэлт болон эцсийн бүтээгдэхүүнийг агуулах, борлуулалтын цэгүүдэд хүргэх зорилгоор 60 ширхэг өөрөө буулгагч автомашиныг нэг бүрийн үнийг 202.6 сая төгрөг, нийт 12,156.0 сая төгрөгөөр 2019 онд худалдан авчээ.

3.94 Үүнээс 37 ширхэгийг худалдан борлуулахаар дуудлага худалдаа⁸²-г удаа дараа зохион байгуулсан ч санал ирээгүй ба 2024 онд Монгол Улсын Шадар сайдаас дээрх автосамосвалыг гамшгийн үеийн хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх болон хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаанд ашиглуулах зорилгоор ОБЕГ-т хүлээлгэн өгөх аман үүрэг өгсөн байна.

3.95 Тавантолгой түлш ХХК-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэр⁸³-ээр компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 37 ширхэг автомашиныг ОБЕГ-т хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах ажлын комисс байгуулж, тэдгээр автомашиныг ОБЕГ-т үнэ төлбөргүй шилжүүлэн өгч⁸⁴, холбогдох акт үйлдсэн байна.

3.96 Тавантолгой түлш ХХК нь хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх асуудлаар эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулахаар 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 01/1201 дугаар албан бичгээр хүсэлт гаргасан байна. Гэтэл тус хүсэлт гаргахаас өмнө, тодруулбал, 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр тухайн хөрөнгийг бодитоор шилжүүлэн, хүлээлцсэн актыг үйлджээ.

3.97 ТБОНӨТХ-аар төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг данснаас хасах санал, шинээр авах шийдвэр гаргах⁸⁵, төрийн өмчийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, эсхүл Засгийн газрын зөвшөөрснөөр ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжүүлэх зохицуулалттай байхад Тавантолгой түлш ХХК нь ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр тухайн хөрөнгийг ОБЕГ-т шилжүүлж, хүлээлцсэн акт үйлдэж хууль зөрчсөн байна.

3.98 Түүнчлэн дээрх автомашинуудыг Тавантолгой түлш ХХК нь 2024 оны санхүүгийн тайланд хөрөнгийн бүртгэлээс хасаж тайлагнасан байна. Харин ОБЕГ нь өөрийн хөрөнгөд бүртгэж аваагүй (2026 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар) нь хөрөнгө үргүйдэх нөхцөл болсон байна.

⁸²ТӨБЗГ-ын 2023 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 454 дүгээр тогтоолоор дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсөн

⁸³ 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/220 тоот тушаалаар

⁸⁴ 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

⁸⁵ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэг "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах"

3.99 Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸⁶-д заасан аж ахуйн бүх ажил гүйлгээ, хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлыг заавал бүртгэх үүрэг, мөн Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1⁸⁷-д заасан анхан шатны баримт бүрдүүлэх, бүртгэлийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх үүргийг тус тус зөрчсөн болно.

3.100 Үүний улмаас үнэ төлбөргүй олж авсан хөрөнгийг орлогоор бүртгээгүйгээс татвар ногдох орлого дутуу тодорхойлогдож, улмаар татварын тайлан бодит бус гарах нөхцөл бүрдсэн байна.

⁸⁶14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

⁸⁷29.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх;

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

Бодлого, төлөвлөлт болон хяналтын чиглэлд:

1. Эрчим хүчний тухай хуулийн хүрээнд Эрчим хүчний яам төвлөрсөн дулаан хангамжийн бодлогыг, харин Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаан хангамжийн бодлогыг тодорхойлж байгаа нь салбарын бодлогын нэгдмэл байх зарчмыг алдагдуулж бодлогын давхардал, чиг үүргийн зөрчил үүсгэж, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжлийн уялдаа холбоо алдагдах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна.
2. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогогүйгээс ажиллах хүчийг тогтвортой хадгалах механизм, цалин хөлс, урамшууллын нэгдсэн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.
3. Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг хүн амын өсөлтийн хандлагатай уялдуулан боловсруулаагүй нь ирээдүйн дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.
4. Төвлөрсөн дулаан хангамжийн барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоосон салбарын онцлогт нийцсэн норм, дүрэм, журам байхгүй нь засвар, шинэчлэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, засвар шинэчлэлт хийхэд тодорхойгүй байдал үүсгэж, ашиглалтын аюулгүй, найдвартай байдал буурах, норм стандартын нэгдмэл байдал алдагдах эрсдэл үүссэн байна.
5. Эх үүсвэртэй шууд холбогдсон хэрэглэгчийн ачааллыг дулаан хангамжийн сүлжээний нийт ачаалал, хэрэглээ, горим тохируулгад нэгдсэн байдлаар бүртгэж, төлөвлөөгүй нь төвлөрсөн дулаан хангамжийн системийн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлох, өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг оновчтой төлөвлөх, ачаалал шилжүүлэх, сэлгэн залгалтыг үр ашигтайгаар зохион байгуулах, удирдахад хүндрэл үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
6. Үнэ тарифын бодлого, зохицуулалтыг хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байгаа нь салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд санхүү, эдийн засгийн дарамт үүсэх шалтгааны нэг болж байна.
7. Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны анхан шатны бүртгэл болон нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй нь бодлогын шийдвэрийг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан гаргах, салбарын гүйцэтгэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарлахаас гадна ижил төрлийн мэдээллийг байгууллагууд давхардуулан цуглуулах, мэдээллийн зөрүүтэй байдал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Мөн эрчим хүчний салбарын мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийг батлаагүй нь салбарын мэдээллийн технологийн хөгжил хоцрох эрсдэлийг үүсгэсэн байна.
8. Эрчим хүчний салбарын хяналт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй нь зөрчил давтагдах нөхцөлийг бүрдүүлж, улмаар дулааны эрчим хүчний үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй болохоос гадна тасралтгүй, найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Бүтэц чиг үүргийн давхардал, удирдлагаар хангах үйл ажиллагаа

9. Эрчист Монгол ХХК, Бүтээмжийн менежер зэрэг чиг үүрэг давхардуулан байгууллага, албан тушаалыг бий болгосон Засгийн газрын шийдвэр нь төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны шуурхай байдал алдагдах, шат дамжлагыг нэмэгдүүлж, төсвийг үр ашиггүй зарцуулахад нөлөөлсөн байна.
10. Нийслэлийн зохицуулах зөвлөл, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, төрийн

албан хаагчид хавсран ажиллаж байгаа нь тэдний үндсэн ажлын гүйцэтгэл, бүтээмжид сөргөөр нөлөөлөхөөс гадна ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийн зааг ялгаа алдагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

11. Эрчим хүчний зохицуулах хороо болон Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд төрийн байгууллага, албан газар хэлбэрээр бүртгэгдсэн ч үйл ажиллагааны зохион байгуулалтын хувьд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын шинжийг давхар агуулан ажиллаж байгаа нь нэг байгууллага хариуцлагын өөр өөр хэлбэрийг хавсран хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Үүний улмаас үнэ тарифын бодлого боловсруулах, тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийн давхардал бий болж, зохицуулалтын тогтолцооны хараат бус байдал, үр нөлөөг бууруулах сөрөг үр дагаврыг бий болгожээ.
12. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК нь хуульд заасан дулаан дамжуулах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь эрх үүрэг, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэл, үнэ тариф, алдагдал зэрэг найдвартай ажиллагааны хариуцлагыг дулаан түгээх, хангах үйл ажиллагаанаас тусад нь төлөвлөх, үнэлэх боломжийг хязгаарлаж, өмчлөл эзэнгүйдэх, хариуцлага алдагдах эрсдэл үүсгэж байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн найдвартай байдал:

1. Нүүрсний борлуулалтын үнийг өөрийн өртгөөс доогуур түвшинд тогтоож байгаа нь Багануур, Шивээ-Овоогийн уурхайг санхүүгийн хүндрэлд оруулж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинэ эх үүсгүүрийг түүхий эдээр хангах нөөцийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна.
2. Төвлөрсөн дулаан хангамжийн үйл ажиллагаа хүний болон санхүүгийн нөөцийн хомсдол, техник, технологийн хоцрогдолд орж, үндсэн тоноглолын ашиглалтын нөөц хугацаа дуусаж, суурилагдсан хүчин чадлаасаа давсан ачаалал үүрч байгаа ч дорвитой арга хэмжээ авахгүй, төрөөс үнэ тарифыг тогтоосон хэмжээндээ барьж байгаа нь шугам сүлжээний аюулгүй байдал алдагдах, системийн хэмжээнд доголдох нөхцөл болжээ.
3. Дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээний засвар, шинэчлэлт хийхэд их хэмжээний хөрөнгө шаардагдахаар байхад хүчин чадлаас давсан техникийн нөхцөл олгож төвлөрсөн дулаан хангамжийн систем доголдох нөхцөл бүрдсэн байна.
4. Өмчлөгч, эзэмшигч нь тодорхойгүй 59.4 км дамжуулах, түгээх шугамын ашиглалтыг хариуцах эзэнгүй байгаа нь гэмтэл, саатал гарсан үед шуурхай засварлах, сүлжээний найдвартай ажиллагаа алдагдах эрсдэлтэй байна.
5. Аудитад хамрагдсан хугацаанд гадаадын зээл, тусламжаар хотын төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр шугам сүлжээний нэвтрүүлэх чадвар 1,874.2 Гкал-аар нэмэгдэж, 572 хэрэглэгчийг шинээр холбосон байна.
6. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн суурилагдсан болон нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөх чиглэлээр хийгдэж буй хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж байгаа ч олон жил зах зээлийн зарчмаар хөгжөөгүй салбарын хэрэгцээг хангах боломж хязгаарлагдмал байхад төсөл, арга хэмжээг иж бүрэн, үе шаттай, харилцан уялдаатай төлөвлөж, хэрэгжүүлээгүйгээс өмнөх жилүүдэд оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч, зарим байгууламж ашиглалтгүй байна.
7. Түүнчлэн эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ТЭЗҮ-г давтагдах байдлаар болон олон тоогоор боловсруулж, их хэмжээний хөрөнгө зарцуулсан ч 2020-2026 онд Улаанбаатар хотод эрчим хүчний дутагдлыг арилгах шинэ үүсвэр бий болоогүй байна.

Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хэсгийг дулаанаар хангахад:

1. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй айл, өрхийг дулаанаар хангах чиглэлээр дулааны дэд төвүүд барих, гэр, байшинг дулаалах, айл өрхүүдийг сайжруулсан

түлшээр хангахад 2018-2025 онд 2.1 их наяд төгрөгийг зарцуулсан ч төвлөрсөн нийслэлийн дулаан хангамжид холбогдоогүй хэсгийн дулаан хангамжийн найдвартай байдал хангагдаагүй байна.

2. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах зорилгоор байгуулсан 399.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 3 үйлдвэрээс 1 нь ашиглатгүй, 1 нь импортын түлш савлах, 1 нь агуулахын зориулалтаар ашиглагдаж байгаа нь төлөвлөлт, судалгаагүй их хэмжээний хөрөнгө үргүй зарцуулсныг харуулж байна.
3. Дээрх үйлдвэрийг байгуулах, иргэдэд хөнгөлөлттэй үнээр сайжруулсан түлш нийлүүлэхэд Тавантолгой түлш ХХК-ийн Эрдэнэс-Тавантолгой ХК-аас эргэн төлөх нөхцөлтэй авсан 1.7 их наяд төгрөгийн зээлийг хэрхэн барагдуулах нь тодорхойгүй, эрх зүйн орчин бүрдээгүй, компани эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах байдлаар аргацааж байгаа ч өөрийн хүчээр эргэн төлөх боломжгүй байна.
4. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийслэлийн төсвөөр дулааны тархмал эх үүсвэрийг ашиглах төрийн өмчит компани байгуулж, эзэмшиж, тендерт давуу эрхээр шалгаруулж, шууд гэрээ байгуулж, компани ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа нь Иргэдийн төлөөлөгчдийн хяналт хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг алдагдуулж, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй байна.
5. Зарим дулааны дэд төвүүдийн барилга байгууламжийн ажил нь эхэлсэн ч төлөвлөсөн хугацаанд хийгдэхгүй байгаагаас олгосон техникийн нөхцөлийн хугацаа хүчингүй болж төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удаашруулах эрсдэлтэй байна.
6. Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь хий ашиглан дулаан үйлдвэрлэж буй Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын тухайн жилийн үнэ тарифыг тооцоход төвлөрсөн дулаан хангамжийн системд хамаарах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тариф тооцох аргачлалыг ашиглаж байгаа нь тарифын тооцоолол үндэслэлтэй гэж үзэх боломжгүй болгож байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илэрсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Эрчим хүчний салбарын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх байгууллагуудын эрх мэдлийн давхардлыг арилган, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, чиг үүрэг, хариуцлагыг иж бүрэн тодорхойлсон эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Хэсэгчилсэн дулаанаар хангах чиглэлээр нийслэлээс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний үр дүнг үнэлж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ орхигдуулж, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй тогтолцоог өөрчилж, ашиг сонирхлоос ангид хяналт үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх;
- Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэр байгуулах, түлшний нийлүүлэлтийг санхүүжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөд дүгнэлт хийж, хөрөнгө оруулалтын үргүй зардал үүсэх нөхцөлийг арилгах, улмаар иргэдийг дулаанаар хангах асуудлыг урт хугацааны, тогтвортой, салбар хоорондын уялдааг хангасан нэгдсэн бодлогоор төлөвлөж, хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулна уу.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор “1 гигакалор/цаг болон түүнээс дээш дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ... шийдвэрлэнэ” гэж эрх олгосон нь салбарын бодлого тодорхойлох байгууллагын чиг үүрэгт нийцээгүй, давуу байдал олгож байгаа тул чиг үүрэгт нийцүүлж өөрчлөлт оруулах;
- Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээний чиглэлээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн зохицуулалтыг арилгах арга хэмжээ авч, шинээр чиг үүргийн давхардал, орон тоо бий болгохгүй байх;
- Эрчим хүчний зохицуулах хорооны хариуцлагын хэлбэрийг тодорхой болгож, хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Тавантолгой түлш ХХК-ийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч, цаашид тус компанийг зах зээлийн зарчмаар ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Эрчим хүчний сайдад:

1. Эрчим хүчний яаманд Зөвшөөрлийн тухай хуулиар олгосон чиг үүргийг Эрчим хүчний тухай хуульд тусгах замаар эрх зүйн уялдааг хангах арга хэмжээг авах;
2. Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор “1 гигакалор/цаг болон түүнээс дээш дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ... шийдвэрлэнэ” гэсэн нь яамны чиг үүрэгт нийцэхгүй байгаа тул өөрчлөлт оруулах;
3. Дулааны эрчим хүчний дамжуулах тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
4. Нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн системийн үйл ажиллагааны аюулгүй, найдвартай ажиллагааг хангах стратегийн болон эрсдэлийн үеийн төлөвлөлтийг хотын хүн амын хэтийн өсөлттэй уялдуулан шинэчлэн боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх;
5. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн болон мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлах;

6. Салбарын төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийг хуульд заасан бүрэлдэхүүнээр томилж, үр дүнд суурилсан гүйцэтгэлээр удирдах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийн зааг ялгааг баримтлах;
7. Төвлөрсөн дулаан хангамжийн барилга байгууламжийн ашиглалтын жишиг хугацааг тогтоосон салбарын норм, дүрмийг боловсруулж, батлуулж, мөрдүүлэх;
8. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, төлөвлөлт хийх чиг үүргийг нэгдсэн хяналтад оруулж, зөвхөн хэрэгжүүлэх боломжтой үед, иж бүрэн тооцоо судалгаа, улсын нэгдсэн төлөвлөлтөд үндэслэн боловсруулж, үргүй зардал нэмж гаргахаас сэргийлэх;
9. Дундын болон хувийн хэвшлийн өмчлөлийн 200 мм ба түүнээс дээш голчтой шугам сүлжээг дулааны эрчим хүч дамжуулах, түгээх, хангах чиг үүрэг бүхий байгууллагын өмчлөлд шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож, улмаар шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний хариуцлагыг тодорхой болгох.
10. Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны мэдээлэл цуглуулах нэгдсэн аргачлал, ангилал, үзүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, анхан шатны бүртгэлийг стандартчилан мэдээллийн нэгдсэн санг үе шаттайгаар бүрдүүлж, байгууллагууд хооронд мэдээлэл солилцох, мэдээллийг ашиглах уялдаа холбоог хангах;
11. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн тоноглол, дамжуулах, түгээх, хангах шугам сүлжээний техникийн үзүүлэлт, нийт ачаалал, хэрэглээний нэгдсэн бүртгэлийг хийх, шугам сүлжээний бодит ачааллыг дахин тодорхойлох ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;
12. Дулааны эх үүсвэрүүдийн өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах нүүрсний тооцоо судалгааг хийх, нарийвчилсан төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх;
13. Дулааны эх үүсвэрүүдийн үндсэн тоноглол, тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хэрэгцээ шаардлагад үндэслэн тооцож, цаг хугацааны дарааллаар эрэмбэлж, шат дараалан хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай дараагийн шатны санхүүгийн эх үүсвэрийг богино хугацаанд шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хүртэх боломжтой болгох;
15. Дулааны эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээний хүчин чадал нь хэтэрсэн байршлуудад нийтийн зориулалтаас бусад барилга байгууламжид шинээр техникийн нөхцөл олгохгүй байх;
16. Салбарын хяналтын газрын хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг арилгах ажлыг төлөвлөж, үе шаттай, үр дүнтэй хэрэгжүүлэх.

Эрчим хүчний зохицуулах хорооны даргад:

1. Салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны зардалд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан зардлыг индексжүүлэх замаар дулааны эрчим хүчний үнэ тарифыг бодит түвшинд хүргэх, тогтвортой байдлыг хангах арга хэмжээг үе шаттайгаар тууштай хэрэгжүүлэх.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг батлуулах ажлыг эрчимжүүлэх;
2. Орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчийг хасаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

3. Төслийн хүрээнд баригдсан нийгмийн барилга байгууламж, дулаан дамжуулах, түгээх сүлжээний техникийн нөхцөлд дахин тооцоолол хийж, шинэчилж, төслийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах;
4. Нийслэлийн түвшинд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад аж ахуйн нэгжүүдийг өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлж, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг тууштай баримтлах.
5. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй хэсэгт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хүрээнд баригдаж буй нийгмийн барилга байгууламж, дулаан дамжуулах болон түгээх сүлжээний техникийн нөхцөлд дахин тооцоолол хийж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. Эрчим хүчний төлөвлөлт хийх арга зүйг шинэчлэн боловсруулах;

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. Байгууллагын дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын тогтвортой бүтцээр ажиллах;
2. Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлаас хэтэрсэн байршлуудад нийтийн зориулалтаас бусад барилга, байгууламжид шинээр дулаан хангамжийн техникийн нөхцөл олгохгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах;

Дулааны 2,3,4 дүгээр цахилгаан станц болон Налайхын, Багануурын дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарт:

1. Дулааны эх үүсвэрүүдийн үндсэн, туслах тоноглолуудын ашиглалтын нөөц хугацааг мэргэжлийн байгууллагын шалгалт, тохируулга, техникийн дүгнэлтэд үндэслэн тогтоох;
2. Насжилт өндөртэй үндсэн тоноглолын аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, шинэчлэх арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх;
3. Эх үүсвэрүүдэд шууд холбогдсон хэрэглэгчдийн дулааны ачааллыг төвлөрсөн дулаан хангамжийн нийт ачаалал, горимын тооцоонд нэгтгэн бүртгэж, төлөвлөлтөд тусгах, ДЦС-4 ТӨХК-ийн 210 МВт-ын коллектор станцаас гарч буй 16а магистраль болон Баянгол чиглэлийн дулааны шугамуудын ашиглалт, горим тохируулгыг нэгдсэн удирдлага, зохицуулалттай болгох.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

№	Шалгагдагч байгууллага	Ирүүлсэн саналын тоо	Тусгасан байдал		Үндэсний аудитын газрын тайлбар
			Хүлээн авсан санал	Хүлээж аваагүй санал	
1	Эрчим хүчний яам	15	9	6	13 санал нь УБДС ТӨХК-аас ирүүлсэн саналтай давхацсан ба үүнээс 6 саналыг хүлээн авсан.
2	Эрчим хүчний зохицуулах хороо	-	-	-	Тусгайлан санал ирүүлээгүй
3	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК	13	7	6	Тайлангаар өгсөн холбогдох зөвлөмжүүдтэй давхацсан агуулга байсан тул 6 саналыг хүлээж аваагүй.
4	Тавантолгой түлш ХХК	6	-	6	Хангалттай бөгөөд зохистой хэмжээнд нотлох баримтыг ирүүлээгүй тул Аудитын тайланд оруулах боломжгүй байна.

Эрчим хүчний яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2^д хуудас

Хүлээн авч танилцууна уу.



ТӨРИЙН НАГИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

• 172600000464

Эрчим хүчний яамны
2026 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
172600000464 дугаар албан бичгийн хавсралт

“УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН БЭЛЭН БАЙДАЛ,
ХЭРЭГЛЭГЧДИЙГ ДУЛААНААР ХАНГАХ, ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”
СЭДВЭЭР ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛУУД

НЭГ. ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛТАЙ ЗААЛТУУД:

46-р хуудас:

Эрчим хүчний шинэ эх үүсвэр нэмэгдээгүй байхад хүчин чадлаас давсан хэрэглээнд техникийн нөхцөл олгоосор байгаа нь төвлөрсөн дулаан хангамжийн системд доголдол үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Өөрчлөлт:

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нь эрс тэс уур амьсгалтай бөгөөд дулаан хангамж хамгийн чухал. Улс орны хөгжлийн гол түлхүүр барилгын салбар дулаан хангамжийгээр урагшлахгүй. 5-10 сарын богино хугацаанд барилгажилт явагддаг. Ийм учраас техникийн нөхцөл олголтыг шууд зогсоох хүндрэлтэй бөгөөд улс орны эдийн засагт асар их хохиролтой. Харин зурга төсөл боловсруулах, хөрөнгө оруулалт төлөвлөх, барилга барих зөвшөөрлүүдийг авахын тулд зурга төслийн шатанд техникийн нөхцөл олголтыг үргэлжлүүлэн хийх саналтай байна. Харин оргил ачааллын үед ажиллах Тэрхмэл эх үүсвэрүүд болон дулаан хангамжийн хүчин чадал нэмэгдсэн үед холбоотын ажлыг хийх шаардлагатай.

Дулаан хангамжийн эх үүсвэр шинээр жаралтай барьж ашиглалтанд оруулах шаардлагатай бөгөөд өрөнхий төлөвлөгөөг жаралтай батлуулж төлөвлөлтэй хангах бичил эх үүсвэрүүдийг богино хугацаанд барих.

51-р хуудас:

2.56 Халаалтын улирлын 2025-2026 оны дулааны тооцорт ачаалал 3,609.7 Гкал/ц-т харгалзах сүлжээний усны тооцорт зарцуулалт 45,121 тн/цаг байхаар байна Харин гадна агаарын температур (-24°C)-ийн үеийн харьцангуй ачаалал нь 2,597.0 Гкал/ц сүлжээний усны зарцуулалт 31,260 тн/цаг байхаар горимын тооцорол гарсан байна Гэвч эх үүсвэрүүдийн өвлийн оргил ачааллын үед авч ажиллах боломжит чадлаар сүлжээний зарцуулалтыг өвлийн горимд 30,650 тн/цаг-аар баталж байгаа нь тооцооллын хэмжээнд хүрэхээргүйгээр буюу дутуу төлөвлөж байгааг харуулж байна.

Өөрчлөлт:

Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон нийт хэрэглэгчдийн тооцорт ачаалал 3609.7 Гкал/ц, харгалзах сүлжээний усны зарцуулалт 45,121 тн/цаг байхаар байна. Харин гадна агаарын температур (-24°C)-ийн үеийн харьцангуй ачаалал нь 2,597.0 Гкал/ц сүлжээний усны зарцуулалт 31,260 тн/цаг байхаар горимын тооцорол гарсан байна. Гэвч эх үүсвэрүүдийн өвлийн оргил ачааллын үед авч ажиллах

боломжит чадлаар сүлжээний зарцуулалтыг өвлийн горимд 30,650 тн/цаг-аар баталж байгаа нь тооцооллын хэмжээнд хүрэхээргүйгээр буюу дутуу байгаа нь дулаанжуулалтын тоноглогын хүчин чадал хүрэлцэхгүй болсныг харуулж байна.

51-р хуудас:

2.57 Горимын тооцоог ингэж дутуу хийсэн нь гадна агаарын температур урт хугацаагаар горимын тооцооноос илүү гарсан тохиолдолд хэрэглэгч шаардлагатай дулаанаа авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байдалд хүрснийг харуулж байна.

Өөрчлөлт:

Горим тооцоонд тусгаж тооцон гадна агаарын температураас (-24°C) бодит байдалд гадна агаарын температур урт хугацаагаар илүү хүйтэрсэн тохиолдолд хэрэглэгч шаардлагатай дулаанаа авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байдалд хүрсн байна.

56-р хуудас:

2.76 ДЭХ-ийг дамжуулах, түгээхэд нийтдээ 674.1 км шугам сүлжээ ашиглаж байгаагийн 553.3 км буюу 82.1 хувь нь 200 мм-ээс дээш голчтой, 120.8 км буюу 17.9 хувь нь 200 мм хүртэл голчтой шугам байна. Үүнээс хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй байна.

Тайлбар: ДЭХ-иос өвсөн эх сурвалжийн давуу хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй, тус шугам сүлжээнд 3 жилийн байдлаар нийт 85 удаагийн эзэмлэйд гарсан гэж оруулсан нь тодорхойгүй. Өмчлөгч эзэмшигч нь тодорхойгүй 59.4 км урттай шугамын хувьд тухайн шугамнаас дулааны эрчим хүчээр хангагдаж буй иргэн хуулийн этгээд нь тус шугамын ашиглалтыг, засвар үйлчилгээг харуулж ажиллах шаардлагатай тул өмчлөгч, эзэмшигч нь эх үүсвэр Ө.200мм болон түүнээс дээш голчтой салаа шугам бүр нь нэг болон 2-оос дээш хэрэглээ, иргэн, хуулийн этгээд, аж ахуй нэгж байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулааны эрчим хүчээр хангагдах тул олт эзэнгүй шугам гэсэн ойлголт байхгүй юм.

Өөрчлөлт:

2.76 ДЭХ-ийг дамжуулах, түгээхэд нийтдээ 674.1 км шугам сүлжээ ашиглаж байгаагийн 553.3 км буюу 82.1 хувь нь 200 мм-ээс дээш голчтой, 120.8 км буюу 17.9 хувь нь 200 мм хүртэл голчтой шугам байна. Үүнээс хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй байгаа тул тухайн салаа шугамуудас дулааны эрчим хүчээр хангагдаж иргэн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх асуудлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд төрийн болон нийслэлийн өмчид шилжүүлж өгөх.

80-р хуудас: Бодлого, төлөвлөлт болон хяналтын чиглэл:

3-р заалт

3. Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг хүн амын өсөлтийн хандлагатай уялдуулан боловсруулаагүй, 2045 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2.1 дахин нэмэгдэх нөхцөлд дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдал алдагдах эрсдэлийг бодитоор нэмэгдүүлж байна.

Тайлбар: Тус компанийн бэлтгэж тооцооны инженер нь тухайн жилд, ойрын үед холбогдох барилга, байгууламжуудыг зурга төсөл тооцон техникийн нөхцөлийн дулааны ачааллаар нь тооцож урт хугацааны төлөвлөлтөд нийт ачааллыг тооцож тусгадаг. Өөрөөр хэлбэл өйл өрх бүрээр биш цаашид шинээр холбогдох барилгуудын хайлалтыг, хэрэгцээний халуун ус, салхиныг нийлсэр ачааллаар тооцож, өвөн нэмэгдэх нийт хэрэглээг жил бүрээр төлөвлөдөг тул гүйцэтгэл нь бодитой бүтээгддэг.

Өөрчлөлт:

Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжлийн өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулган төлөвлөх шаардлагатай бөгөөд хүн амын өсөлтийг урьдчилан тооцож 2045 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2.1 дахин нэмэгдэх нөхцөлд дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдал алдагдах эрсдэлийг бодитоор нэмэгдүүлэх тул эх үүсвэрүүдэд хийгдэхээр төлөвлөгдсөн өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж ойрын хугацаанд хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

5-р заалт

5. Эх үүсвэртэй шууд холбогдсон хэрэглэгчийн ачааллыг дулаан хангамжийн сүлжээний нийт ачаалал, хэрэглээ, горим тохируулгад нэгдсэн байдлаар бүртгэж төлөвлөлтөй нь төвлөрсөн дулаан хангамжийн системийн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлох, өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг оногтой төлөвлөх, ачаалал шилжүүлэх, сэлгэн залгалтыг урь шийтгэйгээр зохион байгуулах, удирдахад хүндрэл үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өөрчлөлт:

Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон бүх барилга байгууламжийн халаалтын ачаалал, газаржуулалт, хэрэгцээний халуун усны ачааллыг дахин нэвчилэн шинээр тооцоолох, хэмжээт хийх аргачлалын дагуу тооцож нийтлэх ажлыг зохион байгуулах. Мөн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлж өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг илүү оногтой тооцож төлөвлөх, ингэснээр сэлгэн залгалтыг урь шийтгэйгээр зохион байгуулах, удирдахад хүндрэл үүсгэх эрсдэлийг бууруулах болно.

81-р хуудас: Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн тоноглол, шугам сүлжээний аюулгүй найдвартай байдал:

2-р заалт

2. Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өвлийн оргил ачааллын горимын тооцооллыг дутуу төлөвлөж байгаа нь хэрэглэгчид зорилтот хэмийн дулаанаар хангагдаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Тайлбар: Нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем нь гидравлик тооцооны хувьд гадна агаарын -39°C утаанд 135/70°C температурын горимоор ажиллаж төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон дийлэнхийн таслагданы агаарын температур нь 18-22°C хэмийн хэмжээнд хэрэглэгчид дулааны эрчим хүчээр хангагдах нөхцөл байдлаар өвсөн эх сурвалжийн давуу хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй, тус шугам сүлжээнд 3 жилийн байдлаар нийт 85 удаагийн эзэмлэйд гарсан гэж оруулсан нь тодорхойгүй. Өмчлөгч эзэмшигч нь тодорхойгүй 59.4 км урттай шугамын хувьд тухайн шугамнаас дулааны эрчим хүчээр хангагдаж буй иргэн хуулийн этгээд нь тус шугамын ашиглалтыг, засвар үйлчилгээг харуулж ажиллах шаардлагатай тул өмчлөгч, эзэмшигч нь эх үүсвэр Ө.200мм болон түүнээс дээш голчтой салаа шугам бүр нь нэг болон 2-оос дээш хэрэглээ, иргэн, хуулийн этгээд, аж ахуй нэгж байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулааны эрчим хүчээр хангагдах тул олт эзэнгүй шугам гэсэн ойлголт байхгүй юм.

Өөрөөр хэлбэл эх үүсвэрүүдийн дулаанжуулалтын тооцоололунд нь насжилтын хуваага бүрхэж элэгдэх, бүрэн хүчин чадлаараа нээгдэн ажиллаж боломжгүй болсон тул тус компани нь хотын сүлжээний горим ажиллагааг бодит утаанд нь нийцүүлэн бууруулж хувирах горим ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг.

Өөрчлөлт:

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өвлийн оргил ачааллын горимын тооцооллыг харьцангуй ачааллаар тооцож дутуу төлөвлөж байгаа нь хэрэглэгчид зорилтот хэмийн дулаанаар хангагдаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

83-р хуудас: Зөвлөмж

Эрчим хүчний сайдад:

5. Дундын болон хувийн хэвшлийн 200 мм ба түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчлөлд шилжүүлж зохицуулалтын эрх зүйн тогтолцоог тодорхой болгож, хөрөнгө эзэнгүйдэх нөхцөлийг бүрдүүлж болгох.

Тайлбар: Дундын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр хийгдсэн 200 мм болон түүнээс дээш голчтой бүх шугамыг өмчлөгч, эзэмшигчид зөвшөөрөлгүйгээр шууд уна төлбөртэй төрийн өмчид шилжүүлж авах боломжгүй тул тус компанийн дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл олгох хууль эрх зүйн нөхцөл бүрхэж, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл олгосон нөхцөлд нийт иргэн хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид өмчлөлд байгаа 200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай салаа шугамын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх. Нийслэл хотын хэмжээнд 200 мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай шугамыг нийт шугамын 36.8% буюу 102.3 км нь насжилт өндөртэй/бүрддэг нь төрийн өмчид шилжүүлэн бүртгэж авах боломжтой юм. Харин 400 мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах салаа шугамуудын өмчлөлийн төрийн болон нийслэлийн өмчид шилжүүлэх, 400 мм хүртэлх шугамыг тухайн салаа шугамнаас хангагдах хамгийн их ачаалалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

Өөрчлөлт:

5. Дундын болон хувийн хэвшлийн 200 мм ба түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээ, улс, нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн болон өмчлөлт нь мэргэжлийн байгууллагад шилжээгүй дулаан дамжуулах сүлжээний шугам, тоноглолыг төрийн болон нийслэлийн өмчлөлд шилжүүлэх, нэг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх зохицуулалтын эрх зүйн тогтолцоог тодорхой болгож, хөрөнгө эзэнгүйдэх, нөхцөлтэй болгох, тухайн салаа шугамд гэмтэл саатан гарсан үед шуурхай засварлах зохицуулалтыг хийх.

ХОЁР. НЭМЭЛТЭЭР ОРУУЛАХ САНАЛТАЙ ЗААЛТУУД :

83-р хуудас. Зөвлөмж хэсэг:

Монгол улсын Ерөнхий сайдад:

1.Эх үүсвэрүүдийн /ДЦС-уудын/ наскилтын хугацаа дууссан дулаанжуулалтын үндсэн тоног төхөөрөмжүүдийг /зуух, турбин, генератор, үндсэн бойлер, туслах бойлер/ үе шаттай шинэчлэн солих, иж бүрэн урсгал засвар хийх хөрөнгийн асуудлыг Засгийн газарт танилцуулж хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх.

Тайлбар: тус тайлангийн 2.28-д ЭХХХ-ноос баталж, эрчим хүчний тариф тооцоход ашиглаж буй үндсэн хөрөнгийн эдэлгээний хугацаагаар тооцоход төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрийн 30 зуухны 73.3% нь, 18 турбины 66.7%, 19 генераторын 63.2% нь ашиглалтын хугацаа дууссанаас аваарын байдалд ажиллахад хүрсэн байна. гэж тодорхойлсон.

2.ДЦС, ДС-уудад боловсруулсан 1 Гкал/ц дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өөрийн өртгийг хэрэглэгчдэд борлуулж буй дулааны эрчим хүчний үнэ тарифтай нь уялдуулан судалж, цаашид нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон дулааны эрчим хүчний үнэ тарифыг үе шаттай нэмэгдүүлэн өөрийн өртөвт нь хүргэх бодлогыг хэрэгжүүлэх.

Тайлбар: Хэрэглэгчдэд борлуулж буй дулааны эрчим хүчний үнэ тариф нь өөрийн өртөөсөө 30-60%-иар бага байгаагаас шалтгаалж Эрчим хүчний салбарын үйлдвэр компаниуд нь алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд наскилтын хугацаа дууссан шугам, тоноглолд шаардлагатай урсгал засвар үйлчилгээг хийж чадахгүй, ашиглалтын шаардлага хангахгүй шугам, тоноглолыг сольж шинэчлэх ажил төлөвлөгөөт хэмжээнд хийгдэхгүйгээс шалтгаалж хотын төвлөрсөн дулаан хангамжийн найдвартай ажиллагаанд сөрөг нөлөө үүсчир халаалтын улирлын оргил ачааллын эх үүсвэрүүд бэлтгэл тоноглолгүй хотын дулаан хангамж хязгаарлагдах өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны даргад:

1.Шугам тоноглолд эвдрэл гэмтэл гарсан болон сүлжээний усыг өөр зориулалтаар ашигласнаас усны алдагдал гаргасан, тухайн сарын нормт хэмжээнээс илүү нэмэлт ус хэрэглэсэн тохиолдолд нэмэлт устай алдагдсан дулааныг тооцож тухайн сарын төлбөр дээр нэмж ногдуулан төлбөр авдаг болох хууль эрх зүйн зохицуулалтыг хийх тариф тогтоож өгөх.

Тайлбар: “УБДС” ТӨХК нь эх үүсвэрүүдээс худалдаж авсан сүлжээний усны энергийн болон нэмэлт усны төлбөрийг төлдөг боловч хотын төвлөрсөн дулаан хангамжийн холбогдсон хэрэглэгчдийн түгээх сүлжээнд ашигласан нэмэлт усны энергийн болон усны төлбөрийг хэрэглэгчдээс авч чаддаггүй. Хэрэглэгчдийн 2-р хэлхээнд усны алдагдлыг нөхөх, даралтын горимыг баруулах чиглэлээр нормоос хэтэрсэн нэмэлт усны хэрэглээг тооцож төлбөр авах хууль эрх зүйн зохицуулалт байхгүйгээс жил ирэх тусам түгээх сүлжээнд ашиглаж буй нэмэлт усны зарцуулалт өсч, дулааны эрчим хүчний алдагдал нэмэгдэж байна. Улмаар түгээх сүлжээний шугам, тоноглолд шаардлагатай засвар үйлчилгээ, шугам шинэчлэлтийн ажлуудыг хийгээгүйгээс шугам тоноглолын найдвартай ажиллагаа буурч байна.

Үндэслэл: Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 292 дугаар тогтоолын 5.2.9-т “Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж дээр суурилуулсан нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэлт устай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчдээс тооцон авна. гэж заасан байдаг бөгөөд Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэмд нэмэлт устай холбоотой заалтыг нэмэлтээр оруулсан тохиолдолд хэрэглэгчийн нормоос хэтэрсэн нэмэлт усны хэрэглээнд төлбөр тооцож авах боломжтой тул ЭХХХ-ны шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн. Одоогоор МУЗГ-т шинэчлэгдэн батлагдах “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн төслийг батлуулахаар бэлтгэл ногдуулан ажиллаж байна. Цаашид хэрэглэгчдийн нормоос хэтэрсэн нэмэлт усны хэрэглээнд тариф тогтоож төлбөр авч эхэлсэн нөхцөлд түгээх сүлжээний шугам, тоноглолын засварын ажлууд чанартай хийгдэж битүүмжилл сайжирч түгээх сүлжээнд алдагдаж буй нэмэлт усны зарцуулалт буурч төвлөрсөн дулаан хангамжийн горим ажиллагаа, үр ашгийг дээшлэнэ.

“УБДС” ТӨХК-ийн Хангай - хэрэглэгчийн дулааны эрчим хүчээр хангах гэрээний 4.3 дугаар заалт, “УБДС” ТӨХК-н Гүйцэтгэх захирлын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/97 дугаар тушаалаар хэрэглэгчдээс нэмэлт усны төлбөр тооцох аргачлалыг баталсан.

2.2023-2026 оны хугацаанд “УБДС” ТӨХК-ийн өмчлөлд шинээр бүртгэж авсан 4.1 тэрбум төгрөгийн үнэлгээтэй ф200-ф400мм голчтой 6.9 км урттай 5 салаа шугамын дамжуулах сүлжээний үйл ажиллагааны зардлыг тус компанийн тарифт нэмж тусгаж өгөх, цаашид дундын эзэмшлийн ф200мм болон түүнээс дээш голчтой шугамыг төрийн өмчид шинээр бүртгэж авах тохиолдолд тус компанийн тарифт өөрчлөлт оруулж нэмж баталж өгөх.

Тайлбар: Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13-т “дулаан дамжуулах сүлжээ” гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Эрчим хүч дамжуулах шугам, өдө станц нь төрийн өмч байна.” гэж заасан.

Мөн Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.20-д “дулаан дамжуулах 200 мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлэх” гэж заасан байдаг. 2023 оны Эрчим хүчний зохицуулах хорооны 348 дугаар тогтоолын 2 дугаар бүлгийн 2.1 дүгээрт “Дундын болон хувийн хэвшлийн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшилд байгаа ф200мм ба түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэн авах, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах.” үүргийг “УБДС” ТӨХК-д даалгасан бөгөөд жил бүр тус компанийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын чиглэлд тусгаж өгч дүгнэж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн №271 дүгээр журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоол гарснаар тухайн иргэн, хуулийн этгээдийн өмчийг төрийн өмчид бүртгэж авдаг бөгөөд шугам эзэмшигч, өмчлөгч тусгай зөвшөөрөл эзэмшигч болон аж ахуй нэгж байгууллага, иргэн хуулийн этгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдын өмчийг шууд төрийн өмчид бүртгэж авах боломжгүй юм.

Одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн зохицуулалтын дагуу ф200 мм болон түүнээс дээш голчтой шугамыг тухайн шугам эзэмшигч, өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр шууд үнэ төлбөргүй төрийн өмчид шилжүүлэн авах боломжгүй, төрийн өмчид шугамыг шилжүүлэн авах үйл ажиллагаа нь дан ганц “УБДС” ТӨХК-иас

шалтгаалах асуудал биш юм. Төрийн өмчид шилжих шугамын баримт бичгийн бүрдлийг хангах, одоогийн үнэлгээг тодорхойлох зэрэг олон үе шаттай хугацаа шаардсан ажил болдог тул жил бүр тус компанид олгож буй тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад шугамын өмчлөл шилжүүлэхтэй холбоотой асуудалд уян хатан хандаж, оновчтой зохицуулалт хийх/

“УБДС” ТӨХК нь өнөөдрийн байдлаар ф80-1200мм голчтой 376 км урттай 16 магистраль дулааны эрчим дамжуулах шугам хоолойн ашиглалт, засвар, үнэлгэ үйлчилгээ, дулаан дамжуулах, түгээх үйлчин найдвартай ажиллагааг хариуцсан 44 слесарь, зохион байгуулалтаар хангах 3 инженер ажиллаж байна. Цаашид Эрчим хүчний зохицуулах хорооноос өгсөн дээрх үүргэ даалгаврын дагуу ф200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай дулааны шугамыг нэмж төрийн өмчид шилжүүлэн авах нөхцөлд тус компанийн үйл ажиллагааны зардал огцом өсч, хүн хүч, машин механизм, ажлын байрны хэмжээ нэмэгдэх тооцоо гарч байгаа бөгөөд эдгээр шугам, тоноглолыг төрийн өмчид авсан нөхцөлд тус компанийн түгээх хангах үйл ажиллагааны зардал нэмэгдэх бөгөөд энэ асуудал нь компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдаагүй тул шууд хэрэгжүүлэх боломжгүй юм.

“УБДС” ТӨХК-ийн хувьд 2023 оноос эхлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271-р журмын дагуу 4.1 тэрбум төгрөгийн одоогийн үнэлгээтэй 6.9 км урттай 5 салаа шугамыг төрийн өмчид шилжүүлэн бүртгэж авах ажлыг зохион байгуулсан. Харин Эрчим хүчний зохицуулах хорооны зүгээс дээрх шугам, тоноглолыг төрийн өмчид бүртгэж авснаар нэмэгдэн гарах түгээх, хангах үйл ажиллагааны зардал /машин механизм, салбарт хэрэгсэл, хүн хүч/ шийдэгдээгүй байна.

Иймд өнөөдрийн нөхцөлд одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд нийслэл хотын дамжуулах шугам, сүлжээ буюу ф200 мм болон түүнээс дээш голчтой нийт 277.5 км урттай дамжуулах хоолойг өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдын өмчийг шууд төрийн өмчид шилжүүлэн авч, бүртгэх ажлыг одоогийн байдлаар шууд шилжүүлэн авахад хөрөнгө, ажиллах хүч, санхүүгийн болон бусад зардал хүрэлцэхгүй юм. Харин тус компанийн дулаанаар хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагаанаас дамжуулах үйл ажиллагааг тусгаарлан Эрчим хүчний тухай хуулийн өөрчлөлттэй уялдуулан бодлогын хэмжээнд шаардлагатай арга хэмжээг авч цаашид үе шаттай хэрэгжүүлэх саналтай байна.

ГУРАВ. ХОЛБОГДОХ ТАЙЛБАР, САНАЛ:

36-р хуудас:

1.85 ЭХХА нь 2020-2025 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө батлаагүй. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам (хүчингүй)-ын 6.1.14-т заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам (хүчингүй)-ын 6.1.1-т заасны дагуу 2020-2025 онуудад ЭХХА-ны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ХШУДАГ-ын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Хавсралт 1-51.

1.87 Мөн ЭХХА нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 11.3^а, 11.4^а, 11.5^а дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй илэрхийлж байна.

Дулаан хангамжийн системийн хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл олголт, нөхцөл, шаардлагын нийцэл, норм, стандартын хэрэгжилтэд хийсэн хяналтаар илэрсэн зөрчил, түрнийг арилгах үйл явц үр дүнгүй байна.

2024 оны ХШУДАГ-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэсэн. Аудитын тайлан, зөвлөмжийг Төсвийн Ерөнхийлөн захиргагчийн дэргэдэх Аудитын хорооны тогтоолоор баталгаажуулан, 2024 оны 9 сарын 12-ны өдрийн а/2818 албан тоотой хүргүүлэн, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Хавсралт 52-76.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Эрчим хүчний зохицуулах хороо



Хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн "Аудитын тайлангийн төсө санал авах тухай" 07/1567 дугаар албан бичгээр ирүүлсэн "Улаанбаатар хот дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх ү ажиллагааны үр дүн" сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Эрчим хүчний зохицуулах хорооноос тайлангийн төсөлд тусгайлан өг саналгүй болно.

ДАРГА



Э.ТҮВШИНЧУЛУУН

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Ф.Энгельсийн гудамж, 26 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16030
Утас/Факс: (976-11) 34 23 97,
Цахим шуудан: dhsu@ulaan.mn

2026.07.02 № 01/606
тантай 2026.06.24 -ны № 07/1566 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хууль, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны "Аудитын сэдэв батлах тухай" 25 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн сэдвээр "Үндэсний аудитын газар"-ын боловсруулсан гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах холбогдох саналуудыг гаргаж хавсралтаар хүргүүлэв.


Хавсралт 7. хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.АМАРСАНАА

1626071954



"УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ ДУЛААНААР ХАНГАХ, ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН" СЭДЭВЭЭР ХИЭСЭН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД НЭМЭГЛЭЭР ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ ТУСГАХ САНАЛ

2026 оны 07 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Тайлангийн 48-р хуудас дахь "Эрчим хүчний шинэ эх үүсвэр нэмэгдээгүй байдал хүчин чадлаас давсан хэрэглээнд техникийн нөхцөл олгогсор байгаа нь төвлөрсөн дулаан хангамжийн системд доголдол үүсэх эрсдэлийг бий болгож байна." гэснийг "Монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн, арс тэсүүр амьсгалтай бөгөөд дулаан хангамж хамгийн чухал. Улс орны хөгжлийн гол түлхүүр барилгын салбар дулаан хангамжгүйгээр урьцлахагүй. 5-10 сарын богино хугацаанд барилгажилт явагддаг. Ийм учраас техникийн нөхцөл олгогтой шууд зогсох нь улс орны эдийн засагт асар их хохиролтой. Харин зурга төсөл боловсруулах, хөрөнгө оруулалт төлөвлөх, барилга барих зөвшөөрлүүдийг авахын тулд зурга төслийн шатанд техникийн нөхцөл олгогтой үргэлжлүүлэн хийх саналтай байна. Харин оргил ачааллын үед ажиллах Тархмал эх үүсвэрүүд болон дулаан хангамжийн хүчин чадал нэмэгдсэн үед холбогдсон ажлыг хийх, дулаан хангамжийн эх үүсвэр шинээр яаралтай барьж ашиглалтад оруулахаар төлөвлөх. Мөн Хотын Ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай дулаан хангамжийн асуудлыг тусган батлуулж, хэрэгжилтийг хангах бичиг эх үүсвэрүүдийг богино хугацаанд барих." гэж өөрчлөн найруулах.

51-р хуудас дахь 2.56 дугаар зүйлийн "2.56. Халаалтын улирлын 2025-2026 оны дулааны тооцоот ачаалал 3,609.7 Гкал/ц-т харагдах сүлжээний усны тооцоот зарцуулалт 45,121 тн/цаг байхаар байна. Харин гадна агаарын температур (-24°C) ийн үеийн харьцангуй ачаалал нь 2,597.0 Гкал/ц сүлжээний усны зарцуулалт 31,280 тн/цаг байхаар горимын тооцоолон гарсан байна. Гэвч эх үүсвэрүүдийн өвлийн оргил ачааллын үед авч ажиллах боломжит чадлаар сүлжээний зарцуулалтыг өвлийн горимд 30,550 тн/цаг-аар баталж байгаа нь тооцооллын хэмжээнд хүрээхгүйгээр буюу дутуу төлөвлөж байгааг харуулж байна." гэсэн хэсгийг "Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон нийт хэрэглэгчдийн дулааны тооцоот ачаалал 3609.7 Гкал/ц, харагдах сүлжээний усны зарцуулалт 45,121 тн/цаг байхаар байна. Харин гадна агаарын температур (-24°C)-ийн үеийн харьцангуй ачаалал нь 2,597.0 Гкал/ц сүлжээний усны зарцуулалт 31,280 тн/цаг байхаар горимын тооцоолон гарсан байна. Гэвч эх үүсвэрүүдийн өвлийн оргил ачааллын үед авч ажиллах боломжит чадлаар сүлжээний усны зарцуулалтыг өвлийн горимд 30,550 тн/цаг-аар баталж байгаа нь тооцооллын хэмжээнд хүрээхгүйгээр буюу дутуу байгаа нь дулаанжуулалтын тоноглогын хүчин чадал хүрэлцэхгүй болсныг харуулж байна." гэж өөрчлөн найруулах.

51-р хуудас дахь 2.57-р зүйлийн "2.57. Горимын тооцоог нэгж дутуу хийсэн нь гадна агаарын температур урт хугацаагаар горимын тооцооноос илүү гарсан тохиолдолд хэрэглэгч шийрэлдэгтэй дулаан авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байдалд хүрснийг харуулж байна." гэсэн хэсгийг "Горим тооцоонд тусгаж тооцсон гадна агаарын температурас (-24°C) бодит байдалд гадна агаарын температур урт хугацаагаар илүү хүйтэрсэн тохиолдолд хэрэглэгч шаардлагатай дулаана авч чадахгүйд хүрэх эрсдэлтэй байдалд хүрсэн байна." гэж өөрчлөн найруулах.

56-р хуудас дахь 2.76-р зүйлийн "2.76 ДЭХ-ийг дамжуулах, түгээхэд нийтдээ 874.1 км шугам сүлжээ ашиглаж байгаагийн 553.3 км буюу 82.1 хувь нь 200 мм-ээс дээш голчтой, 120.8 км буюу 17.8 хувь нь 200 мм хүртэл голчтой шугам байна. Үүнээс хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй байна" гэснийг "2.76 Нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн дамжуулах сүлжээ 874.1 км-ийг 200 мм голчтой 376 км-ийг урттай 1-1.6 мансралт дулааны шугамыг "УБД" ТӨХК хариулан ажилладаг. Харин ДЭХ-ноос цаашид төрийн өмчид шилжүүлэхээр үүрэг болгосон иргэн хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулааны эрчим хүчээр хангагдах 200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай шугам сүлжээний өмчлөлийн асуудлыг тодорхой болгох" гэж өөрчлөн найруулах.

Тайлбар: ДЭХ-ноос авсан эх сурвалжийн дагуу хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан 59.4 км /56.4 урттай гадна дулааны шугамын өмчийн харьяалал тодорхойгүй, тус шугам сүлжээнд 3 жилийн байдлаар нийт 85 үйлдлийн гэмтлэлийг гарган гэж оруулсан нь тодорхойгүй. Өмчлөгч хэсгийг нь тодорхойгүй 59.4 км урттай шугамын хувьд тусгай шугамнаас дулааны эрчим хүчээр хангагдахгүй иргэн, хуулийн этгээд нь тус шугамын ашиглалт, засвар үйлчилгээг хянуулах шийлжл шийрэлдэгтэй түл өмчлөгч, эзэмшигч нь гэж үзнэ. Өмчлөм болон түүнээс дээш голчтой салаа шугам бүр нь нэг болон 2-оос дээш хэрэглэгч, иргэн, хуулийн этгээд, аж ахуй нэгж байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулааны эрчим хүчээр хангагдах тул өт сэлүүн шугам гэсэн ойлголт байхгүй юм. Халаалтын улиралд олон хэрэглэгч дулааны эрчим хүчээр хангагдах үндсэн эзэмшигчид дээрх 59.4 км урттай салаа шугамуудад гэмтэл өвчлөл гарсон үед засварын ажлыг хийх хариуцах эзэн нь тодорхойгүй гэж шугамын нэгжид засварлах ажил улаанвирч хангагч компанийн үйл ажиллагаанд сөрөөр нөлөөлөхөөс гадна хэрэглэгчдийн дулааны хангамжийн үйлчилгээг хянуулах хариуцаж хэрэглэгчдээс дулаан хангамжтай холбоотой гомдол саналуд гарч нэлээдгүй хүндрэлтэй үүсгэж, "УБД" ТӨХК нь төрийн өмчид шилжээгүй хэрэглэгчийн шугам, тоноглолд засварын ажлыг хийх зардал байхгүй бөгөөд хууль эрхзүйн хувьд болохгүй юм.

60-р хуудас дахь Дүгнэлт хэсгийн Бодлого, төлөвлөлт болон хяналтын чиглэлийн 3-р зүйлийн "3. Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг хүн амын өсөлтийн хандлагатай уялдуулан боловсруулаагүй, 2045 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2.1 дахин нэмэгдэх нөхцөлд дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдал алдагдах эрсдэлийг бодитоор нэмэгдүүлж байна." гэснийг "3. Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөт уялдуулан төлөвлөх шаардлагатай бөгөөд хүн амын өсөлтийг урьдчилан тооцож 2045 он гэхэд Улаанбаатар хотын хүн ам 2 дахин нэмэгдэх нөхцөлд дулаан хангамжийн хүртээмж, найдвартай байдал алдагдах эрсдэлийг бодитоор нэмэгдүүлж тул эх үүсвэрүүдэд хийгдэхээр төлөвлөгдсөн өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ойрын хугацаанд хэрэгжүүлж шаардлага үүссэн." гэж өөрчлөн найруулах.

Тайлбар: Дулаан түгээлтийн урт хугацааны төлөвлөлтийг хийхдээ айл өрх бүрээр биш цаашид нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжид шинээр холбогдох барилгудын техникийн нөхцөл, зурга төсөлд тусгагдсан халаалт, хэрэгцээний халуун ус, сэлүүнийн нийлбэр ачааллаар нь тооцож, өсөн нэмэгдэх нийт хэрэгцээг жил бүрээр төлөвлөх бөгөөд гүйцэтгэл нь бодитой дүнгддэг.

60-р хуудас Дүгнэлт хэсгийн Бодлого, төлөвлөлт болон хяналтын чиглэлийн 5-р зүйлийн "5. Эх үүсвэрүүд шугам холбогдсон хэрэглэгчийн ачааллыг дулаан хангамжийн сүлжээний нийт ачаалал, хэрэглээ, горим тохируулгад нэгдсэн байдлаар бүртгэж төлөвлөгөө нь төвлөрсөн дулаан хангамжийн системийн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлох, өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг оновчтой төлөвлөх, ачаалал шилжүүлэх, сэлгэн залгалтыг үр ашгтайгаар зохион байгуулах, удирдахад хүндрэл үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна." гэсэн хэсгийг

"5. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон бүх барилга байгууламжийн халаалтын шинээр тооцоолол, хэмжилт хийж эргэлтэлэн дагуу тооцож нийтлэх ажлыг зохион байгуулах. Мөн бодит ачааллыг үнэн зөв тодорхойлж өвлийн оргил ачааллын үед горим ажиллагааг илүү оновчтой тооцож төлөвлөх, ингэснээр сэлгэн залгалтыг үр ашгтайгаар зохион байгуулах, удирдахад хүндрэл үүсгэх эрсдэлийг бууруулах болно." гэж өөрчлөн найруулах.

61-р хуудас дахь Дүгнэлт хэсгийн Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн тоноглол, шугам сүлжээний ажиллыг найдвартай байдал, 6-р зүйлийн "2. Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өвлийн оргил ачааллын горимын тооцооллыг дутуу төлөвлөж байгаа нь хэрэглэгчид зорилтот хэмийн дулаанаар хангагдах чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна." гэснийг "2. Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өвлийн оргил ачааллын горимын тооцооллыг харьцангуй ачааллаар тооцож төлөвлөж байгаа нь хэрэглэгчид зорилтот хэмийн дулаанаар хангагдах чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна." гэж өөрчлөн найруулах.

Тайлбар: Нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем нь гидравлик тооцооны хувьд гадна агаарын -39°C-танд 135/70°C-температурын горимоор ажиллах ёстой боловч төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрүүдийн чадлын дутагдлаас шалтгаалан халаалтын улирлын оргил ачааллын үед тооцоот температурын дагуу эх үүсвэрүүд дээр барилга ажиллах техникийн боломжгүй байдаг тул "УБД" ТӨХК нь хотын сүлжээний горимыг харьцангуй ачааллаар буюу -24°C-аар горимын тооцоот бодит утганд нь нийцүүлэн бууруулан тооцож хувьсах горим ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг.

83-р хуудас дахь Зөвлөмж хэсгийн Эрчим хүчний сайдад гэсэн хэсгийн "5. Дугаар болон хувийн хэвшлийн 200мм ба түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчлөлд шилжүүлэх зохицуулалтын эрх зүйн тогтоолоор тодорхой болгож, хөрөнгө эзэнгидэх нөхцөлийг болгох." гэснийг "5. 200мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээг төр, орон нутгийн өмчлөлд шилжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг хангах, хөрөнгө эзэнгидэх нөхцөлийг өргөх." гэж өөрчлөх.

Тайлбар: Дундын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр хийгдсэн ф200мм болон түүнээс дээш голчтой бүх шугамыг өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр шууд үнэ төлбөргүй төрийн өмчид шилжүүлэн авах боломжгүй тул тус компанид дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл олгох хууль эрх зүйн нөхцөл бүрдэж, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл олгосон нөхцөлд нийт иргэн хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өмчлөлд байгаа ф200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай салаа шугамын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх. Нийслэл хотын хэмжээнд ф200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай шугамыг /нийт шугамын 36.8% буюу 102.3 км нь насжилт өндөртэй/ бүрдийг нь төрийн өмчид шилжүүлэн бүртгэж авах боломжгүй. Харин 400мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах салаа шугамуудын өмчлөлийг төрийн болон нийслэлийн өмчид шилжүүлэх. 400мм хүртэлх шугамыг тухайн салаа шугамаас хангагддаг хамгийн их ачаалалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай. Мөн 2023 онд ЭХЗХ-ны 348-р тогтоол гарснаас хойш хувийн хэвшлийн хөрөнгөөр хийгдсэн дундын өмчлөлийн ф200мм болон түүнээс дээш голчтой салаа шугамд гэмтэл саатал гарсан үед "ОСНААУГ" ОНБААТГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь ф200мм болон түүнээс дээш голчтой шугамыг төрийн өмчид шилжих ёстой, "УБДС" ТӨХК хариуцаж засварын ажлыг хийх ёстой гэсэн байр суурийг байгаа бөгөөд гэмтэл гарсан шугамын засварын ажлыг хийхгүй байхгүй (ихийдэлүүд цөөнгүй гарч хэрэглэгчдийн дулаан хангамж хязгаарлагдаж байна. "УБДС" ТӨХК нь төрийн өмчид шилжж ирээгүй салаа шугамын засварын ажлыг хийх зардал төлөөлөгдөгүй, засварын ажлыг хийх боломжгүй юм. Иймд хуулийн этгээд, ОСНААУГ ОНБААТГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид 200мм болон түүнээс дээш голчтой шугамын гэмтлийг засварлах ёстой талаар чиглэл өгөх шаардлагатай.

Мөн одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн охиуцлалтын дагуу 200мм болон түүнээс дээш голчтой шугамыг тухайн шугам эзэмшигч, өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр шууд үнэ төлбөргүй төрийн өмчид шилжүүлэн авах боломжгүй, төрийн өмчид шугамыг шилжүүлэн авах үйл ажиллагаа нь дан ганц "УБДС" ТӨХК-иас шалтгаалах асуудал биш юм. Төрийн өмчид шилжих шугамын баримт бичгийн бүрдлийг хангах, одоогийн үнэлгээг тодорхойлох зэрэг олон үе шаттай хугацаа шаардсан ажил болдог тул жил бүр тус компанид даалгаж буй тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад шугамын өмчлөл шилжүүлэхтэй холбоотой асуудалд уян хатан хандаж, оновчтой зохицуулалт хийх.

Өнөөдрийн байдлаар нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжийн 80-1200мм голчтой 376 км урттай 16 магистраль дулааны эрчим дамжуулах шугам хоолойн ашиглалт, засвар, үзлэг үйлчилгээ, дулаан дамжуулах үеийн найдвартай ажиллагааг тус компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд ашиглалтын албаны 44 слесарь, 9 инженер хариуцаж ажиллаж байна. Чаашид Эрчим хүчний зохицуулах хорооноос өгсөн дээрх үүрэг даалгаврын дагуу 200мм болон түүнээс дээш голчтой 277.5 км урттай дулааны шугамыг нэмж төрийн өмчид шилжүүлэн авах нөхцөлд тус компанийн үйл ажиллагааны зардал огцом өсч, хүн хүч, машин механизм, оффисын байрны хэмжээ нэмэгдэх тооцоо гарч байгаа бөгөөд эдгээр шугам, тоноглолыг төрийн өмчид авсан нөхцөлд тус компанийн түгээх хангах үйл ажиллагааны зардал нэмэгдэх ба энэ асуудал нь компанийн төсөв зардалд тусгагдаагүй тул шууд хэрэгжүүлэх боломжгүй юм.

"УБДС" ТӨХК-ийн хувьд 2023 оноос эхлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271-р жуурын дагуу 4.1 тэрбум төгрөгийн өдсгийн үнэлгээтэй 6.8 км урттай 5 салаа шугамыг төрийн өмчид шилжүүлэн бүртгэж авах ажлыг зохион байгуулсан. Харин Эрчим хүчний зохицуулах хорооны зүгээс дээрх

шугам, тоноглолыг төрийн өмчид бүртгэж анхиаар нэмэгдэх гэрэх түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг /машин механизм, сэлбэг хэрэгсэл, хүн хүч/ шийдэх өгөөгүй байна.

Иймд өнөөдрийн нөхцөлд одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд нийслэл хотын дамжуулах шугам, сүлжээ буюу иргэн хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өмчлөлд байгаа 200 мм болон түүнээс дээш голчтой нийт 277.5 км урттай дамжуулах хоолойг өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдын өмчийг шууд төрийн өмчид шилжүүлэн авч, бүртгэх ажлыг одоогийн байдлаар шууд шилжүүлэн авахад хөрөнгө, ажиллах хүч, санхүүгийн болон бусад зардал хүрэлцэхгүй юм.

Нэмэлтээр оруулах санал:

1.Улс, нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн 200мм болон түүнээс дээш голчтой шугамуудыг анх ашиглалтад орсон жилд нь төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэн өгөх асуудлыг холбогдох хууль эрх зүйн баримт бичигт тусгаж оруулах. Тайлбар: /Өнөөдрийн байдлаар 2020-2026 оны хугацаанд нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн боловч 25 байршилд 200-500мм голчтой 36.8км урттай дулааны шугамын өмчлөл нь мэргэжлийн байгууллагад шилжж ирээгүйгээс тухайн салаа шугамуудад жил бүр хийгдэх засвар үйлчилгээний ажлууд хийгдэлгүй орхижээ, цаашид гэмтэл саатал гарсан нөхцөлд засварын ажлыг ямар компани хийх нь тодорхойгүй байдалд байна. Иймд улс, нийслэлийн хөрөнгөөр хийгдсэн шугамуудыг ашиглалтанд орсон тухайн жилд нь захиалагч болон гүйцэтгэгч компаниуд нь баримт бичгийн бүрдлийг хангаж мэргэжлийн байгууллагад өмчлөлийг нь шилжүүлэн өгөх нь зүйтэй./

2.Тайлангийн 83-р хуудас дахь Зөвлөмжийн Ерөнхий сөйвд гэсэн хэсэгт:

2.1 Шинэ эх үүсвэр, гудамж байгаа эх үүсгүүрүүдийн аргатгалын ажлуудыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг Улсын их хуралд ганилцуулж шийдвэрлэх.
2.2 ДЦС, ДС-уудад боловсруулсан 1 Гкал/ц дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн өөрийн өртгийг хэрэглэгчдэд борлуулж буй дулааны эрчим хүчний үнэ тарифтай нь уялдуулан судалж, цаашид нийслэл хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон дулааны эрчим хүчний үнэ тарифыг үе шаттай нэмэгдүүлэн өөрийн өртөгт нь хүргэх бодлогыг хэрэгжүүлэх гэж тус тус нэмэх.

Тайлбар:Хэрэглэгчдэд борлуулж буй дулааны эрчим хүчний үнэ тариф нь өөрийн өртөгөөсөө 30-60%-иар бага байгаагаас шалтгаалж Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниуд нь алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд насжилтын хугацаа дууссан шугам, тоноглолд шаардлагатай урсгал засвар үйлчилгээг хийж чадахгүй, ашиглалтын шаардлага хангахгүй шугам, тоноглолыг сольж шинэчлэх ажил төлөвлөгөөт хэмжээнд хийгдэхгүйгээс шалтгаалж хотын төвлөрсөн дулаан хангамжийн найдвартай ажиллагаанд сөрөг нөлөө учирч халаалтын улирлын оргил ачааллын үед эх үүсгүүрүүд бэлтгэл тоноглолыг ажилласнаар хотын дулаан хангамж хязгаарлагдах өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна/.

3.Тайлангийн 84-р хуудас дахь Зөвлөмж Эрчим хүчний зохицуулах хорооны даргад гэсэн хэсэгт "3.1.Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн хүчин чадлаар хамааруулан тогтоосон нормоос хатарсан нэмэлт үс, түүнд агуулагдах дулаонд төлбөр тооцож өгөх.

Тайлбар: "УБДС" ТӨХК нь эх үүсгүүрүүдээс худалдаж авсан сүлжээний үс, нэмэлт усны энергийн болон усны төлбөрийг төлдөг боловч хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хэрэглэгчдийн түгээх сүлжээнд ашигласан нэмэлт усны энергийн болон усны төлбөрийг хэрэглэгчдээс өвч мөддөггүй. Хэрэглэгчдийн 2-р хэлхээнд усны алдагдлыг нөхөх, даралтын горимыг баруулах чиглэлээр нормоос хэтэрсэн нэмэлт усны хэрэглээг тооцож төлбөр авах хууль эрх зүйн зохицуулалт, тодорхой тариф байхгүйгээс шалтгаалж жил ирэх тусам түгээх сүлжээнд ашиглаж буй нэмэлт усны зарцуулалт өсч, дулааны эрчим хүчний алдагдал нэмэгдэж байна. Улмаар түгээх сүлжээний шугам, тоноглолд шаардлагатай засвар үйлчилгээ, шугам шинэчлэлтийн ажлуудыг хугацаанд нь хийгээгүйгээс түгээх сүлжээний шугам, тоноглолын насжилт өсч байна. Иймд аудитын дүгнэлтэнд хэрэглэгчдийн хэрэглэсэн нэмэлт усны нормоос хэтэрсэн хэрэглээнд төлбөр тооцож авах тариф батлуулах чиглэлээр санал, арга хэмжээг тогтог оруулах.

